



**“ХҮНИЙ ЭРХЭД СУУРИЛСАН ХАНДЛАГЫГ ТӨРИЙН БОДЛОГО,
ШИЙДВЭР, ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРТ НЭВТРҮҮЛЭХ НЬ”
СУРГАГЧ БАГШ НАРТ ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА**



The Asia Foundation



УУЛ
УУРХАЙН ЯАМ



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг



The Asia Foundation

Энэхүү гарын авлагыг АНУ-ын Азийн сангаас Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүгийн дэмжлэгтэйгээр Уул уурхайн яамтай хамтран хэрэгжүүлж буй “Байгаль орчныг хамгаалахад талуудын оролцоог нэмэгдүүлэх нь-II” төслийн хүрээнд хэвлүүлэв.



“ХҮНИЙ ЭРХЭД СУУРИЛСАН ХАНДЛАГЫГ ТӨРИЙН БОДЛОГО, ШИЙДВЭР, ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРТ НЭВТРҮҮЛЭХ НЬ”

СУРГАГЧ БАГШ НАРТ ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА

Боловсруулсан:

Намсрайн Баярсайхан

“Хил хязгааргүй алхам” ТББ-ын тэргүүн



Зөвлөсөн:

Пүрэвжавын Болормаа

АНУ-ын Азийн сангийн Байгаль орчны хөтөлбөрийн ахлах зөвлөх

Хянасан:

Чимиддоржийн Эрдэнэчимэг

АНУ-ын Азийн сангийн Байгаль орчны хөтөлбөрийн зохицуулагч

ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ	7
----------------	---

БҮЛЭГ I. СУРГАЛТЫН ЗОРИЛГО, ОНЦЛОГ БАЙДАЛ, ЧИГЛҮҮЛЭГЧИЙН ҮҮРЭГ, СУРГАЛТЫН МОДУЛЫН АГУУЛГА

1.1 Сургалтын зорилго	10
1.2 Сургалтын зорилтууд	10
1.3 Сургалтын онцлог, чиглүүлэгчийн чиг үүрэг	10
1.4 Сургалтын модулын агуулга	12

БҮЛЭГ II. СУРГАЛТЫН МОДУЛЬ

Нэгдүгээр хэсэг. Сургалтын нээлт

2.1.1 Сургалтын хөтөлбөр	15
2.1.2 Сургалтын нээлт	16
2.1.3 Сургалтад оролцогчдын танилцуулга	17
2.1.4 Сургалтын бүтэц, агуулгын танилцуулга	18
2.1.5 Сургалтаас хүлээж буй үр дүнгийн зураглал	19
2.1.6 Оролцогчид хамтын дүрмээ боловсруулах цаг	20

Хоёрдугаар хэсэг. Хүний эрх, эрхэд суурилсан хандлагын тухай одоогийн ойлголт

2.2.1 Бүлгийн ажил	21
2.2.2 Хэлэлцүүлэг/Дүгнэлт	22

Гуравдугаар хэсэг. Нийгмийн бүтцийн ялгаатай байдал

2.3.1 Дасгал ажил: “Эрх мэдлийн алхалт” тоглоом	23
2.3.2 Бүлгийн ажил/ Хэлэлцүүлэг	25

Дөрөвдүгээр хэсэг. Хүний эрх түүний төрөл, хүний эрхийн зарчмууд (55 минут)

2.4.1 Хүний эрхийн ерөнхий ойлголт, төрөл ангилал, зарчмууд танилцуулга	28
2.4.2 Хэлэлцүүлэг/Дүгнэлт	28

Тавдугаар хэсэг. Асуудалд дүн шинжилгээ хийх ажил

2.5.1 Тулгамдсан асуудлыг тодорхойлох, эрэмбэлэх бүлгийн ажил	30
2.5.2 Дасгал ажил/Ярилцлага	31
2.5.3 Хэлэлцүүлэг/ Дүгнэлт	32

Зургаадугаар хэсэг. Хүний эрхэд суурилсан хандлага, түүний зарчмууд

2.6.1 Танилцуулга: Хүний эрхэд суурилсан хандлага түүний зарчмууд	33
---	----

Долоодугаар хэсэг. Бодлогын баримт бичигт эрхэд суурилсан хандлагаар дүн шинжилгээ хийх

2.7.1 Бүлгийн ажил: Хөгжлийн бодлогын баримт бичигт эрхэд суурилсан хандлагаар дүн шинжилгээ хийх бүлгийн ажил	35
2.7.2 Хэлэлцүүлэг/Дүгнэлт	36

Наймдугаар хэсэг. Сургалтын явцын үнэлгээ (60 минут)

2.8.1 Өмнөх өдрийн мэдлэгээ сэргээн хэлэлцэх	37
--	----

Есдүгээр хэсэг. Тогтвортой хөгжил түүний үзэл баримтлал

2.9.1 Танилцуулга: Тогтвортой хөгжил ба хүний эрхийн хамаарал	38
2.9.2 Хэлэлцүүлэг/Дүгнэлт	39

Аравдугаар хэсэг. Стратеги төлөвлөгөө боловсруулах

2.10.1 Бүлгийн ажил/Ярилцлага	40
2.10.2 Хэлэлцүүлэг/ Дүгнэлт	41

Арван нэгдүгээр хэсэг. Үнэлгээ, сургалтын хаалт	
2.11.1 Үнэлгээний хуудас бөглөх	42
2.11.2 Дүгнэлт ярилцлага	42
2.11.3 Сургалтын хаалт	42
БҮЛЭГ III. СУРГАЛТЫН МАТЕРИАЛ, ХЭРЭГЛЭГДЭХҮҮН	
Нэгдүгээр хэсгийн сургалтын материалын бүрэлдэхүүн:	
3.1.1 Хавсралт 1. Сургалтын бүтэц, агуулга	45
Хоёрдугаар хэсгийн сургалтын материалын бүрэлдэхүүн:	
3.2.1 Хавсралт 2. Хүний эрх түүний одоогийн ойлголтоо сэргээх дасгал ажил	47
3.2.2 Хавсралт 3. Хүний эрхийн төрлүүд (ХЭТТ болон Үндсэн хуулийн хэмжээнд)	48
Гуравдугаар хэсгийн сургалтын материалын бүрэлдэхүүн:	
3.3.1 Хавсралт 4. Нийгмийн бүтцийн зураглал “Эрх мэдлийн алхалт” тоглоомын дүрүүд, асуултууд	49
3.3.2 Хавсралт 5. Хүний эрхийн түгээмэл тунхаглал. “Нийгмийн бүтцийн ялгаатай байдал” сэдвийн бүлгийн ажлын хэрэглэгдэхүүн	52
3.3.3 Хавсралт 6. Үндсэн хууль. 2-р бүлэг 16-р зүйл. “Нийгмийн бүтцийн ялгаатай байдал” сэдвийн бүлгийн ажлын хэрэглэгдэхүүн	55
Дөрөвдүгээр хэсгийн сургалтын материалын бүрэлдэхүүн:	
3.4.1 Хавсралт 7. “Хүний эрх түүний төрөл, хүний эрхийн зарчмууд” танилцуулга	57
Тавдугаар хэсгийн сургалтын материалын бүрэлдэхүүн	
3.5.1 Хавсралт 8. “Асуудалд дүн шинжилгээ хийх” “АСУУДЛЫН МОД” загвараар асуудлыг шинжлэх удирдамж 1	59
3.5.2 Хавсралт 9. Тулгамдсан асуудалд ерөнхий дүн шинжилгээ хийх удирдамж 2 Зааварчилгаа чиглүүлэгч нарт	60
3.5.3 Хавсралт 10. Асуудал бэрхшээл хоёрын ялгаатай ойлголт	61
Зургаадугаар хэсгийн сургалтын материалын бүрэлдэхүүн:	
3.6.1 Хавсралт 11. Хүний эрхэд суурилсан хандлага (ХЭСХ)-ын танилцуулга	62
Долоодугаар хэсгийн сургалтын материалын бүрэлдэхүүн:	
3.7.1 Хавсралт 12. Орон нутгийн бодлогын баримт бичигт эрхэд суурилсан хандлагаар дүн шинжилгээ хийх зааварчилгаа 1	66
3.7.2 Хавсралт 13. Орон нутгийн бодлогын баримт бичигт эрхэд суурилсан хандлагаар дүн шинжилгээ хийх хяналтын матриц	67
Наймдугаар хэсгийн сургалтын материалын бүрэлдэхүүн:	
3.8.1 Хавсралт 14. “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал” танилцуулга	68
Есдүгээр хэсгийн сургалтын материалын бүрэлдэхүүн:	
3.9.1 Хавсралт 15. Стратеги төлөвлөгөө боловсруулах бүлгийн ажлын заавар	70
3.9.2 Хавсралт 16. Боловсруулсан стратеги төлөвлөгөө түүний үйл ажиллагаа, ХЭСХ болон тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн хянах матриц	71
Аравдугаар хэсгийн сургалтын материалын бүрэлдэхүүн:	
3.10.1 Хавсралт 17. Сургалтын үнэлгээний хуудасны загвар	72
БҮЛЭГ IV. СУРГАЛТЫН ЧИГЛҮҮЛЭГЧИД ӨГӨХ ЗӨВЛӨГӨӨ	
4.1.1 Хавсралт 18. Чиглүүлэгч сургалтад бэлтгэх талаар	75
4.2.1 Хавсралт 19. Чиглүүлэгчийн онцлог, сургалтын үед анхаарах асуудал	76
4.3.1 Хавсралт 20. Сэргээх дасгал тоглоом	82

ТОВЧИЛСОН ҮГ

БИНХ	Багийн Иргэдийн Нийтийн Хурал
БУЭ	Бичил уурхай эрхлэгчид
ЗД	Засаг дарга
ИБУТЭТОУП	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
ИБУТЭ	Иргэний болон улс төрийн эрх
КНХ	Компаний нийгмийн хариуцлага
МУ	Монгол улс
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
ОУ	Олон улс
ТББ	Төрийн бус байгууллага
УИХ	Улсын их хурал
ҮХ	Үндсэн хууль
ХХК	Хариуцлагатай хувьцаат компани
ХАОАТ	Хүн амын орлогын албан татвар
ХЭДКГ	Хүний эрхийн дээд комиссарын газар
ХЭСХ	Хүний эрхэд суурилсан хандлага
ХЭҮК	Хүний эрхийн үндэсний комисс
ХЭТТ	Хүний эрхийн түгээмэл тунхаглал
ЭЗНСЭТОУП	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт
ШХА	Швейцарийн хөгжлийн агентлаг

ӨМНӨХ ҮГ

АНУ-ын Азийн сангийн “Байгаль орчныг хамгаалахад талуудын оролцоог нэмэгдүүлэх нь-II” төслийн зорилго нь Бичил уурхай эрхлэгчдийн орон нутгийн тогтвортой хөгжилд оруулж буй хувь нэмрийг нэмэгдүүлэхийн сацуу эрүүл, аюулгүй орчинд амьдрах, зохистой ажлын байраар хангагдах эрхийг нь хангахад хувь нэмэр оруулахад оршино. “Байгаль орчныг хамгаалахад талуудын оролцоог нэмэгдүүлэх нь-II” төслийг хэрэгжүүлэх үндсэн арга барил нь Хүний эрхэд суурилсан хандлага (ХЭСХ) бөгөөд энэ нь олон улсын хүний эрхийн стандартуудад түшиглэсэн, хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангахад чиглэсэн хүний хөгжлийн үйл явцыг илэрхийлсэн үзэл баримтлалын тухай ойлголт юм.

ХЭСХ нь хүмүүс өөрсдийнх нь амьдралын хэв маяг, чанарт нөлөөлөх шийдвэр гаргахад нээлттэй, ач холбогдолтойгоор оролцдог байх боломжийг бүрдүүлэхийг зорино. Түүнчлэн “үүрэг хүлээгч” нар олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заагдсан хүний эрхийн стандартын дагуу “эрх агуулагч” нарын өмнө хүлээх ёстой үүргээ илүү сайн биелүүлэх, эрх агуулагчид нийгмийн гишүүний үүргээ ухамсарлан идэвх санаачлагатай байж, аливаа хөгжлийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд утга учиртай оролцдог, хянадаг байхад чиглэсэн тогтмол үйл явц юм.

ХЭСХ-ыг төслийн хэрэгжилтэнд тусгаснаар гарах ач холбогдол:

- **Олон улсын гэрээ хэлэлцээр, хууль тогтоомжийн хүрээнд:** зорилго, стандартууд нь дэлхийн хэмжээнд зөвшөөрөгдсөн бөгөөд Швейцарь, Монгол улс болон олон улсын хэмжээний хуулийн хүрээнд тодорхойлогдсон зарчмуудыг ажил хэрэг болгоно;
- **Хүний эрхийг хангах зорилго нь тодорхой бөгөөд нээлттэй:** орон нутгийн хөгжлийн аливаа бодлого, хөтөлбөрүүд нь ХЭСХ-ын суурь зарчмуудыг хангасан байх бөгөөд түүний хэрэгжилт нь тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн байх боломжуудад дэмжлэг болно;
- **Шийдвэр гаргах эрх мэдэл:** урт хугацааны нөлөө бүхий үр дүн гаргахад хүн бүр идэвхтэй, чөлөөтэй, утга учиртайгаар оролцох чадавхийг бэхжүүлнэ;
- **Эрх тэгш байдал:** шударга ёс, эрх тэгш байдал, эрх чөлөөг эрхэмлэж, ядуурал, мөлжлөгийн үндэс суурь болсон эрх мэдлээ хэтрүүлэн ашиглах байдлыг зогсоохыг шаарддаг. Мөн гадуурхагдсан бүлэгт хүрч ажиллах шаардлагыг хангахад туслана;
- **Үр ашигтай, гарах үр нөлөө нь их:** хариуцлага тооцох, эрх мэдэл олгох, идэвхи зүтгэл гаргах, асуудлуудад онцгой ач холбогдол өгөхөд нь дэмжлэг үзүүлнэ;
- **Хариуцлага:** төрийн болон хандивлагч байгууллагууд, хувийн хэвшил, нутгийн иргэд, хувь хүмүүсийн хүлээх хариуцлагын хэм хэмжээг тодорхой болгож дээрхи зарчмуудыг даган мөрддөг болоход нь нөлөө үзүүлнэ.

2005 онд Монгол улс засаглалыг сайжруулах явдал нь хүний хөгжлийг хангах, Мянганы хөгжлийн бусад 8 зорилгыг хэрэгжүүлэх урьдал нөхцөл мөн болохыг онцолж, ардчилсан засаглал, хүний эрхийг дэмжихэд чиглэсэн Мянганы хөгжлийн 9 дэх зорилтыг тодорхойлж баталсан дэлхийн анхны улс болсон.

Энэ нэр хүнд бүхий томоохон амлалт, үйл ажиллагаа нь Монгол улсын төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангах улмаар төрийн бодлогыг хүний эрхэд суурилсан хандлагаар төлөвлөж хэрэгжүүлэх, үр дүн, үр нөлөөг хэмжих шалгуур нь иргэн бүрийн эрх, эрх чөлөө хэрхэн хангагдсанаар үнэлэгдэх хандлагын суурь, эхлэл болсон гэж үзэж болно.

Монгол улс уул уурхайд түшиглэн хөгжихийн тулд нэг үе гадны хөрөнгө оруулагчдыг татаж хайгуул, олборлолт хийлгэхийг нэн тэргүүнд тавьдаг байсан бол одоо тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн, ногоон мөртэй эдийн засгийг бий болгох, өнөө болоод ирээдүй үеийн хүмүүсийн эрх, эрх чөлөөний боломж, сонголтуудад саад хийхгүйгээр урагшлах шаардлагатай тулгараад байна. Үүний дагуу Засгийн газраас эрдэс баялгийн салбарт төрөөс баримтлах бодлогыг гаргаж эрдэс баялагаа олборлохдоо хүний эрх, эрх чөлөөнд саад хийхгүй, тогтвортой хөгжлийг бий болгоход онцгойлон анхаарахаа илэрхийлсэн байна.

Энэ хүрээнд АНУ-ын Азийн сангаас «Байгаль орчныг хамгаалахад талуудын оролцоог нэмэгдүүлэх нь-II» төслийг хэрэгжүүлэхдээ үндэсний болон орон нутгийн түвшинд хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэхэд хувийн хэвшлийн салбар, төр засаг, иргэний нийгмийн байгууллага, ард иргэдийг хамарсан цогц үйл ажиллагаа явуулах юм. Ингэхдээ Хүний эрхэд суурилсан хандлагын зарчмуудыг бодитойгоор мөрдөж, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн орон нутгийн түвшний бодлого хөтөлбөр боловсруулан баталгаажуулах улмаар хэрэгжүүлэх, үнэлж дүгнэж, ахиц дэвшил гаргахад нь талуудад шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох, чадавх бэхжүүлэхэд чиглэн хэрэгжиж байна.

Энэ хүрээнд Монгол Улсад хүний эрх, эрх чөлөөг хангахад хувь нэмэр оруулж, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг үндэсний онцлог, хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн талуудын чадавх бэхжүүлэх нөлөөллийн ажлыг хэрэгжүүлж буй “Хил хязгааргүй алхам” ТББ нь “Хүний эрхэд суурилсан хандлага” сургалтын хөтөлбөр, аргачлалыг боловсруулсан бөгөөд хүний эрхийн чиглэлээр үр дүнтэй үйл ажиллагаа явуулдаг “Хүний эрх хөгжил төв” ТББ-тай хамтран АНУ-ын Азийн сангийн төслийн зорилтот арван аймаг, дүүрэг, сумдын Засаг дарга түүний тамгын газрын ажилтан, мэргэжилтнүүд, ИТХ-ын төлөөлөгчдөд тус сургалтыг зохион байгуулсан болно.

Тус гарын авлага нь сургалтаас сургалтын явцад улам сайжран, орон нутаг бүрийн амьдралын туршлага сургамжаар баяжиж хэвлэгдэн таны гарт хүрч байна. Иймд энэхүү гарын авлагыг илүү сайжруулахад хэрэглэгч та бүхэн санал сэтгэгдлээ бидэнтэй хуваалцахад бид таатай хүлээж авах болно.

Энэхүү гарын авлагын аливаа хэсгийг ашиглах тохиолдолд “Хүний эрхэд суурилсан хандлагыг төрийн бодлого, шийдвэр, хөгжлийн хөтөлбөрт нэвтрүүлэх нь” сургагч багшийн гарын авлагаас авч ашиглав гэж эх сурвалж болгон дурдана уу.

Хил хязгааргүй алхам төв ТББ

Утас: 99724869; 90195997; 70006061

И-тайл: swb.ngo@gmail.com



БҮЛЭГ

I

СУРГАЛТЫН ЗОРИЛГО, ОНЦЛОГ БАЙДАЛ,
ЧИГЛҮҮЛЭГЧИЙН ҮҮРЭГ, СУРГАЛТЫН МОДУЛЫН АГУУЛГА





Сургалтын зорилго

Орон нутгийн тогтвортой хөгжилд оролцогч талуудын хүний эрх, эрхэд суурилсан хандлагын талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, улмаар талуудын хамтын ажиллагаа, түншлэлийн үйл ажиллагаанд уг арга зүйг нэвтрүүлэхэд шаардлагатай мэдлэг, дүн шинжилгээ хийх ур чадвар олгох, хандлагад нөлөөлөхөд чиглэгдэнэ.

Сургалтын зорилтууд

- Оролцогч талуудын (орон нутгийн удирдлагууд, иргэд, бичил уурхай эрхлэгчид, хувийн хэвшлийн байгууллагууд) орон нутгийн тогтвортой хөгжилд оруулж буй хувь нэмрийг нэмэгдүүлэхэд хүний эрхийн мэдлэгийг сэргээх, эрхэд суурилсан хандлагын талаар мэдлэг, чадавх олгох улмаар хандлагын өөрчлөлтийг бий болгох.
- Нутгийн иргэдийн болон бичил уурхай эрхлэгчдийн өмнө тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд хүний эрхийн өнцгөөс харж, төрийн бодлого, хөгжлийн хөтөлбөрт эрхэд суурилсан дүн шинжилгээ хийх чадварыг дээшлүүлэх.
- Орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих, ардчиллыг бэхжүүлэхэд талуудын оруулах хувь нэмэр, өгөөжийг нэмэгдүүлэх.

Сургалтын онцлог, чиглүүлэгчийн чиг үүрэг

Сургалт нь ярилцлага болон дадлага ажил хосолсон, оролцогч хүн бүрийн амьдралын туршлага, мэдлэгт үндэслэсэн, оролцогчдын идэвхтэй, тэгш оролцоог хангасан, харилцан суралцаж хамтдаа хөгжих, хийнгээ суралцаж, бүтээгдэхүүн гаргах зарчимд суурилсан онцлогтой.

Сургагч багш нь чиглүүлэгчийн үүрэгтэй байна. Чиглүүлэгч өөрийн үзэл бодлыг оролцогчдод тулгаж, өгч буй мэдлэг, мэдээллээ туйлын үнэн зөв, хөдлөшгүй мэт ойлгогдохоор танилцуулахаас зайлсхийж, харин өөрийн буюу тухайн нутгийн хамт олны мэдлэг туршлага, үзэл бодол, байр суурийг хүндэтгэн оролцогчидтой мэдлэг хуваалцаж, асуудлын суурь шалтгааныг тодорхойлж улмаар эрхэд суурилсан хамтын шийдэл гаргахад нь туслах замаар сургалтыг чиглүүлнэ. Энэ зарчим сургалт эхлэхээс дуусах бүх үед мөрдөгдөнө.

Чиглүүлэгч нь өөрийгөө бусдын адил харилцан суралцах үйл явцад оролцогч гэж үзнэ. Ялангуяа хүний эрхийн сэдэвт сургалт, нөлөөллийн ажлын үед энэ байдал илүү гарч ирдэг. Өөрөөр хэлбэл, сургагч багш нь бүхнийг мэдэгч, асуудлыг шийдэгч, “хамгийн мундаг” нь биш, харин тухайн асуудлаар илүү мэдээлэлтэй, сайн сонсогч, олон янз байр суурь, үзэл бодлыг нэгтгэн дүгнэж, мэдрэмж сайтай чиглүүлэх үүрэг хүлээнэ. Учир нь хүний эрхийн асуудлаар олон жил ажиллаж, хичнээн их мэдлэг туршлага хуримтлуулсан сургагч байлаа ч энэ сэдэв, асуудлын хүрээнд үргэлж шинэ зүйл урган гарч,



үргэлж суралцаж байдгийг олон жил хүний эрхийн талаар судалгаа, сургалт, нөлөөллийн ажил хийсэн хүмүүс нотолдог. Тухайлбал, улс төрийн болон иргэний эрхийн асуудлаар олон жил судалгаа, сургалт хийсэн хүн байсан ч тэр хүнд эдийн засаг эсвэл соёлын эрхийн асуудал, эсвэл тодорхой бүлгийн эрхийн асуудлаар мэдлэг туршлага дутмаг байдаг. Түүнчлэн даяарчлал тэлэх тусам хүний эрхүүд хувьсаж өөрчлөгдөн, шинэ нэр тодорхойлолт урган гарч байна. Жишээлбэл, хөгжих эрх, оролцооны эрх гэх эрх, нэршлийг хэдхэн жилийн өмнөөс Олон улсын баримт бичгээр баталгаажуулсан жишээ дурьдаж болно.

Иймд чиглүүлэгч нь суралцагч юм. Мөн чиглүүлэгчийн анхаарах нэг зүйл нь сургалтын агуулга, үнэт зүйл, зарчмыг тайлбарлахын зэрэгцээ оролцогчдын сурч мэдэж буй зүйлд нь анхаарал хандуулж, хүмүүсийн олон янз байдлыг хүлээн зөвшөөрч, аливаа нас, хүйс болон бусад төрлийн ялгаварлал гаргахгүй хүн бүртэй тэгш харьцаж, энгийн, элгэмсэг, нээлттэй байж, оролцогчдын ялгаатай хэрэгцээ, шаардлагад мэдрэмжтэй хандах шаардлагатай.





Сургалтын модулын агуулга

Сургалтын сэдэв	“Хүний эрхэд суурилсан хандлагыг төрийн бодлого, шийдвэр, хөгжлийн хөтөлбөрт нэвтрүүлэх нь”
Сургалтын зорилго	Орон нутгийн тогтвортой хөгжлийг бий болгоход оролцогч талуудын хүний эрх, эрхэд суурилсан хандлагын талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, улмаар талуудын хамтын ажиллагаа, түншлэлийн үйл ажиллагаанд уг арга зүйг нэвтрүүлэхэд шаардлагатай мэдлэг, дүн шинжилгээ хийх үр чадвар олгоно.
Сургалтын агуулга	Орон нутгийн хөгжилд оролцогч талуудын оруулж буй хувь нэмрийг нэмэгдүүлэхэд хүний эрх, эрхэд суурилсан хандлагын талаарх мэдлэг, ойлголтыг цэгцлэх, дүн шинжилгээ хийх үр чадварт сургах замаар тэдний хандлагад нөлөөлнө.
Үндсэн сэдвүүд	Нийгмийн бүтцийн ялгаатай байдлыг “Эрх мэдлийн алхалт” дүрийн тоглолт; Хүний эрх, эрх чөлөө, хүний эрхийн зарчмууд; Асуудлын суурь шалтгааныг тогтоох дүн шинжилгээ; Хүний эрхэд суурилсан хандлага; Тогтвортой хөгжил ба хүний эрх хамаарал; Стратеги төлөвлөгөө боловсруулах арга зүй.
Сургалтын зорилтот хэсэг	Орон нутгийн удирдлага, мэргэжилтнүүд; Хувийн хэвшлийн удирдлага, мэргэжилтнүүд; Иргэний нийгмийн байгууллагын ажилтан, гишүүд; Нутгийн иргэд, хамт олон, малчид.
Хүрэх үр дүн, гарах үр нөлөө	Орон нутгийн хөгжлийн аливаа бодлого, хөтөлбөрүүд нь ХЭСХ-ын суурь зарчмуудыг хангасан байх бөгөөд түүний хэрэгжилт нь тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн байх боломжуудад дэмжлэг болох; Урт хугацааны нөлөө бүхий үр дүн гаргахад хүн бүр идэвхтэй, чөлөөтэй, утга учиртайгаар оролцох чадавхийг бэхжүүлэх; Эрх агуулагч иргэд шийдвэр гаргагчдын эрх мэдлээ хэтрүүлэн ашиглах байдлыг зогсоох, хариуцлага тооцох, эрх мэдэл олох, идэвхи зүтгэл гаргах чадавх олгох; Эрх мэдэл багатай хэсэг, гадуурхагдсан бүлэгт үүрэг хүлээгч хүрч ажиллах шаардлагын үндэслэлийг ойлгуулахад туслах.
Сургалтын хугацаа	12 цагаас бага биш, 16 цагаас хэтрэхгүй
Сургалтын арга зүй	Оролцооны аргад тулгуурлан бүлгээр ажиллах, дасгал ажил хийх, интерактив танилцуулга, хэлэлцүүлэг өрнүүлэх, хийнгээ харилцан суралцах;
Чиглүүлэгч багийн бэлтгэл	Сургалтын чиглүүлэх багт зориулсан энэхүү гарын авлага, түүний арга зүйг сайтар судалж, өөрийн болгосон байх; “Хүний эрхэд суурилсан хандлага” гарын авлагатай сайтар танилцаж үг хэллэг, ухагдахууныг өөрийн болгож эзэмшсэн байх; Сургалтын үндсэн сэдвийн танилцуулгыг өөрийн арга барил, мэдлэгээр илүү баяжуулан эзэмшсэн байх; Сургалтад хэрэглэгдэх бүлгийн ажлын удирдамж, дасгал ажлын зааварчилгааг хэрхэн ашиглах, оролцогчдод тайлбарлан таниулахад бэлтгэх; Сургалтыг оролцооны аргаар явуулах тул бүлгээр ажиллах, тоглох, оролцогчдыг хөдөлгөөнтэй байхаар сургалтын танхимыг сонгож бэлтгэх, хананд цаас нааж тогтохоор бэлтгэлийг хангах; Сургалтыг нэг чиглүүлэгч явуулах боломжгүй тул заавал 2-оос дээш чиглүүлэгчтэй баг бүрдэж зохион байгуулах бөгөөд багийн гишүүд сэдвийн хуваарилалт, ажил үүргээ урьдчилж хувааж тогтсон байх;



БҮЛЭГ

II

СУРГАЛТЫН МОДУЛЬ



2.1.1 Сургалтын хөтөлбөр

Өдөр 1	Агуулга
09:00-10:10	Сургалтын нээлт: Оролцогчдын танилцуулга Сургалтын бүтэц, агуулгын танилцуулга Сургалтаас хүлээж байгаа үр дүнгийн зураглал Оролцогчид хамтын дүрмээ боловсруулах цаг
10:10-11:10	Хүний эрх, эрхэд суурилсан хандлагын тухай одоогийн ойлголт: Бүлгийн ажил Хэлэлцүүлэг
11:10-11:25	Цайны завсарлага
11:25-13:00	Нийгмийн бүтцийн ялгаатай байдлын ойлголт: “Эрх мэдлийн алхалт” дасгал/тоглоом Бүлгийн ажил: Танай давхаргын эрх, эрх чөлөө хангагдаж байна уу? Хэлэлцүүлэг
13:00-14:00	Үдийн хоол
14:00-14:30	Хүний эрхийн тухай ерөнхий ойлголт: Хүний эрхийн төрөл, зарчмууд Хэлэлцүүлэг
14:30-15:00	Асуудалд ерөнхий дүн шинжилгээ хийх: Бүлгийн ажил Хэлэлцүүлэг
15:00-15:15	Цайны завсарлага
15:15-16:05	Хүний эрхэд суурилсан хандлагын ойлголт: Танилцуулга Хэлэлцүүлэг
16:05-17:45	Орон нутгийн бодлогын баримт бичигт Хүний Эрхэд Суурилсан Хандлага (ХЭСХ)-аар дүн шинжилгээ хийх ойлголт: Бүлгийн ажил Хэлэлцүүлэг
Өдөр 2	Агуулга
09:00-10:00	Өмнөх өдрийн агуулгыг бататгах дүгнэлт / ярилцлага
10:00-10:40	“Тогтвортой хөгжил ба хүний эрх”-ийн ойлголт: Танилцуулга Хэлэлцүүлэг
10:40-11:00	Цайны завсарлага
11:00-12:30	Стратеги төлөвлөлт: (ХЭСХ болон Тогтвортой хөгжил матриц ашиглах) Бүлгийн ажил Хэлэлцүүлэг
12:30-13:30	Үнэлгээ, дүгнэлт, хаалт Үнэлгээний хуудас Дүгнэлт ярилцлага Хаалт



2.1.2 Сургалтын нээлт (10 минут)



Зорилго:

- Сургалтын зорилго, зорилт, үйл явц, сургалтын онцлог, хүсч буй үр дүнгийн талаар нэгдсэн ойлголттой болох;
- Сургалтад оролцогчид хоорондоо хөгжилтэйгээр танилцаж, сургалтын таатай, дотно, итгэлцэл бүхий орчин, уур амьсгалыг бүрдүүлэх.



Бэлтгэл ажил:

- Зохион байгуулагчдын зүгээс санаачлага гаргаж тухайн орон нутгийн төлөөллийг, хэрэв сургалтад оролцогч нь тодорхой нэг байгууллага бол тэдний удирдлагыг, иргэд нутгийн хамт олон бол тэдний төлөөллийг нээлтэд оролцуулж үг хэлүүлэх нь сургалтаас гаргах төлөвлөгөө, бодлогын асуудлыг шийдвэрлэхэд ач холбогдол үзүүлэх үр дүнтэй. Эдгээр хүмүүс сургалт хийх болсон суурь хэрэгцээ шаардлага, хамрах хүрээ, хүлээж буй үр дүнгийн талаар мэдээлэх, оролцогчдыг бүрэн идэвхтэй оролцохыг сануулж уриалах бөгөөд эдгээр талууд оролцох боломжгүй тохиолдолд чиглүүлэгчдийн багийн ахлагч энэ мэдээллийг өгнө.
- Нээлтэд сургалтын багийн ахлагч чиглүүлэгчдийн багаа танилцуулна;
- Багийн гишүүд дараа танилцах цагаар илүү дэлгэрэнгүй танилцах тул энэ удаад зөвхөн байгууллага, нэр, сургалтын хугацаанд гүйцэтгэх үүргийн тухай товч танилцуулахад болно.



Нээлтийн үед сургалтын үндсэн зорилгыг танилцуулна

Сургалтын үндсэн зорилго: Орон нутгийн тогтвортой хөгжилд оруулж буй хувь нэмрийг нэмэгдүүлэхэд оролцогч талуудын хүний эрх, эрхэд суурилсан хандлагын талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, улмаар талуудын хамтын ажиллагаа, түншлэлийн үйл ажиллагаанд уг арга зүйг нэвтрүүлэхэд шаардлагатай мэдлэг, дүн шинжилгээ хийх үр чадвар олгох явдал юм.

Орон нутгийн тогтвортой хөгжлийг хангахад тулгарч буй олон асуудал байгаа бөгөөд түүний нэг нь яах аргагүй бичил уурхайн үйл ажиллагаа, ялангуяа зохион байгуулалтгүйгээр байгалийн нөөцийг ашиглаж буй үйл явц зайлшгүй багтаж байна. Бичил уурхай эрхлэгчдийн орон нутгийн хөгжил, нийгэм эдийн засагт оруулж буй хувь нэмэр багагүй байгаа.

Тухайлбал, Хүн амын орлогын албан татвар (ХАОАТ)-ынтөгрөг, макро түвшинд бичил уурхайчид орлоготой бол дэлгүүрийн орлого сайжирч бараа эргэлт нэмэгддэг нь үнэн. Зарим нэг газар Сэлэнгэ аймгийн БУЭ-ийн Баатар вангийн хишиг ТББ сумынхаа ойд төгрөг, Дундговь аймгийн Өлзийт сумын ТББ мөн сумынхаа ойн арга хэмжээнд 2 сая төгрөгийн хандив өгсөн жишээ байна. Цаашид түүнийг илүү үр өгөөжтэй хариуцлагатай болгох төдийгүй бичил уурхай эрхлэгчдийг өөр, эко ажлын байранд шилжүүлэх боломжуудыг нээхэд Азийн сангийн “Байгаль орчныг хамгаалахад талуудын оролцоог нэмэгдүүлэх нь-II” төсөл хувь нэмрээ оруулж байгаа талаар тайлбарлана.



Сургалт зохион байгуулж байгаа байгууллага, санхүүжүүлэгч байгууллага, төслийг танилцуулах нь зүйтэй.

Энэ сургалтыг АНУ-ын Азийн сангийн “Байгаль орчныг хамгаалахад талуудын оролцоог нэмэгдүүлэх нь - II” төслийн хүрээнд зохион байгуулж байна. Тус төсөл “Нутгийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг баталгаажуулах, түүнчлэн бичил уурхай эрхлэгчдийн зохистой ажлын байраар хангагдах эрхийг хэрэгжүүлэх замаар орон нутгийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах” зорилготой.

Энэ зорилгын хүрээнд хийгдэх үйл ажиллагаа бүрт тогтвортой хөгжлийн чиг баримжаатай чадавх олгоход анхаарлаа төвлөрүүлэх, хүний эрхэд суурилсан хандлага, жендерийн мэдрэмжтэйгээр сургалт, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үр дүнд нь хөгжилд оролцогч талуудын эрх, үүргийн талаарх мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлж, эрхээ шаардах, үүргээ хэрэгжүүлэх чадавхийг бэхжүүлэх төсөл гэдгийг нээлтийн үгэндээ заавал багтаан тайлбарлана. Энэ нь оролцогчдыг сургалтын үед тулгамдсан асуудлаа тодорхойлох, стратеги төлөвлөгөө боловсруулахад төслийн зорилтод анхаарлыг хандуулах нь ач холбогдолтой юм.

2.1.3 Сургалтад оролцогчдын танилцуулга (25 минут)



Зорилго:

Чиглүүлэгч болон оролцогчид хоорондоо танилцахаас гадна оролцогчдыг чөлөөтэй, тэгш эрхтэй, идэвхитэй, нээлттэй оролцоход нь дэмжлэг өгч, чиглүүлэгч - оролцогч хооронд чөлөөт энгийн харилцааг бий болгох, сургалтыг хөгжилтэй, бие биенээ хүндэтгэн дэмжсэн, харилцан суралцаж, хөгжилдөж суралцах боломжийг бүрдүүлэх, таатай уур амьсгал, орчин бий болгоход оршино.



Чиглүүлэгч:

Оролцогчдыг тойрог болон зогсохыг хүснэ. (хүн бүрт нүүрээ харагдахаар, хүн бүрийн нүүрийг харахаар). Тэгээд хүн бүр өөрийнхөө тухай дараах мэдээллийг товчхон өгч танилцуулна. Үүнд:

- Бүтэн нэр, болон богино нэр
- Эрхэлдэг ажил, албан тушаал
- Таны хийх дуртай хөдөлгөөн, таны очихыг хүссэн газар, таны мөрөөдөл, таны хобби гэх мэт бага цагт тухайн хүний талаар хүмүүс мэдээлэл авч болох асуултыг сонгоно.

Энэ арга бие биенээ сайн мэддэг хүмүүст ч танилынхаа тухай шинэ зүйлийг мэдэж авахад тус болдог. Ийнхүү танилцсанаар хүмүүс ижил хоббигоороо холбогдох, мөрөөдлийнхөө тухай ярилцах, тодорхой сэдвээр илүү дотно ойлголцох боломжийг олгох ач холбогдолтой. Заримдаа хүмүүс хэт дэлгэрэнгүй ярих гээд байдаг тул маш товчхон байхыг анхааруулж, чиглүүлэгчид эхэлж өөрсдийгөө танилцуулахдаа жишиг тогтоохыг хичээнэ. Гэхдээ танилцах олон арга, өөр хэлбэрүүд байдаг бөгөөд чиглүүлэгч таатай уур амьсгал, орчин бий болгоход анхаарах хэрэгтэй.



Чиглүүлэгч дүгнэнэ:

Танилцуулгын төгсгөлд чиглүүлэгч товч дүгнэж хэлэхдээ онцлог талуудыг тодорхойлж хэлнэ. Жишээ нь: нэг овогтой хүмүүс, нэг ижил нэртэй “амидаа” хүмүүс, г м. Хэн нэгний очихыг хүссэн газар нөгөө өөр нэг хүн очсон байж болно, нэг зүйр үг, онч болон хэлц үгийг хэд хэдэн хүн итгэл үнэмшлээ болгож хэлдэг байж болно. Энэ бүхнийг чиглүүлэгч сайтар тогтоож авч дүгнэх нь танилцах үйл ажиллагааг сонирхолтой болгодог.

2.1.4 Сургалтын бүтэц, агуулгын танилцуулга (5 минут)



Зорилт:

Сургалтын бүтэц, хөтөлбөрийн агуулгыг танилцуулж, сэдэв хооронд хэрхэн гинжин уялдаатай болох, оролцогчид түр чөлөө авах нь сэдэв хоорондын логик дарааллаар олгогдох мэдлэг, ур чадвараас хоцрох тул тэднийг идэвхитэй, зорилготой байж, ажлаа зохицуулж бүрэн оролцохыг анхааруулж хэлнэ.



Бэлтгэл:

Сургалтын бүтэц болон хөтөлбөрийг хувилж тараасан байна. Хэрэв дэлгэцэн дээр үзүүлэх бол компьютер, проектор бэлэн байх хэрэгтэй. Сургалтын бүтцийн дэлгэрэнгүй тайлбарыг Хавсралт 1-ээс харна уу.



Чиглүүлэгч:

- Сургалтын бүтцийг дэлгэцэн дээр харуулж, эсвэл хэвлэн тараасан хувиа харахыг хүсээд, хэсэг тус бүрээр нь товч танилцуулна. Сургалтын онцлог, оролцогчдын болон чиглүүлэгчийн үүрэг оролцоог ялган тайлбарлаж өгнө.
- Сургалтын чиглүүлэгч нар “бэлэн” буюу “зөв мэдлэг” өгөхөөс илүүтэйгээр оролцогчдын мэдлэг, амьдралын туршлагад үндэслэн, харилцан мэдлэг мэдээлэл солилцох, эргэцүүлэн бодох, хамтаар дүн шинжилгээ хийн хэлэлцэх, бусадтай хамтран шинэ ойлголт, мэдлэг, аргачлал бүтээхэд нь туслах, өөрсдөө энэ үйл явцад идэвхтэй оролцоход анхаарна.
- Сургалтад оролцогчид нь бусдад мэдээлэл өгөх, хувиараа болон хамтаар эргэцүүлэн бодох, хамтаар дүн шинжилгээ хийх, бүлгээр ажиллах, бүгдээрээ дүгнэн ярилцах, бүтээлчээр сэтгэх, бүтээх байдлаар оролцоно.
- Сургалт нь оролцооны аргад түлхүү тулгуурлахдаа уламжлалт аргыг мэдлэг зангидах хэлбэрээр хослуулан хэрэглэх болно.
- Сургалтын бүтэц, агуулга, арга зүйтэй холбоотой асууж, тодруулах зүйл байгаа эсэхийг лавлаад, сургалтаас хүсч буй үр дүнгээ тодорхойлж хуваалцахыг санал болгоно.



2.1.5 Сургалтаас хүлээж буй үр дүнгийн зураглал (20 минут)



Зорилго:

Сургалт нь оролцогчдын зорилго, сургалтад хүрэлцэн ирсэн хэрэгцээ юу байсан, хүсч буй үр дүнгийн төсөөллийн зураглал гаргаж, хүрэх үр дүнгийн талаар оролцогчдыг нэгдсэн ойлголттой болгож эхлүүлэх нь сургалтыг үр дүнтэй болгодог.




Бэлтгэл:

- “МЭДЛЭГ” “УР ЧАДВАР” “ХЭРЭГЛЭЭ” гэж гарчигласан 3 самбарын цаас ханан дээр зэргэлдээ наасан байна;
- Маркер, томоохон хэмжээтэй өнгө өнгийн цавуутай цаас бэлтгэнэ.



Чиглүүлэгч:

- Оролцогчид хүсч буй үр дүнгээ төсөөлөн зураглаж, хэлэлцэх нь сургалтыг илүү үр дүнтэй болгоход чухал ач холбогдолтой болохыг тайлбарлаад, хүн бүрт гурван өөр өнгийн карт тарааж өгнө. Нэг өнгийн картан дээр энэхүү 2 өдрийн сургалтаас ямар МЭДЛЭГ-тэй болох хүлээлттэй байгаагаа, хоёр дахь дээр нь ямар УР ЧАДВАР эзэмших хүлээлттэй байгаагаа, 3 дахь дээр нь сургалтаас олж авсан мэдлэг, ур чадвараа хэрхэн ажил амьдрал дээрээ ХЭРЭГЛЭХ зорилготой байгаа талаараа тус бүр товч, тод, уншигдахуйц бичээд зохих самбарын цаасан дээр өөрийн биеэр очиж наахыг урина. 5 минутад багтаан бичихийг сануулна.
- Чиглүүлэгчид ч өөрсдийнхөө хүсч буй үр дүнгээ энэ маягаар бичиж наана.
- Оролцогчид картуудаа тухайн самбарын цаасан дээр наасны дараа гурван самбар тус бүрийн мэдээлэлтэй танилцана. Ингэхдээ оролцогчдын хэн нэгнийг бусдадаа уншиж танилцуулахыг хүснэ. Энэ нь тухайн нэг оролцогч өөрийн болон бусад оролцогчдын хүсч буй үр дүнгийн төсөөлөлтэй танилцаж, хэрхэн ажил хэрэг болгох хүлээлттэй байгаа талаар нэгдсэн мэдээлэл авна.
- Заримдаа оролцогчид мэдлэг, ур чадварыг хооронд нь хольдог. Тиймээс “мэдлэг” болон “ур чадвар”-ын ялгааг хэлж өгч болох юм, эсвэл хэлэлцэж тодруулаад, зохих самбарын цаасан дээр зөөж наана.
- Сургалтаас хүсч буй үр дүнгийн төсөөллийг зураглаж, нэгтгэн хэлэлцсэн самбарын цаасаа сургалтын танхимд байршуулж, сургалтын төгсгөлд энэ жагсаалтаа дахин авч үзэж, хэр сайн биелсэн, аль нь биелээгүй, ямар учраас гэдгийг хэлэлцэж дүгнэнэ.





2.1.6 Оролцогчид хамтын дүрмээ боловсруулах (10 минут)



Зорилт:

Сургалтын явцыг аль болох үр дүнтэй болгоход туслах, сургалтын турш мөрдөх дүрмийг ардчилсан зарчмаар боловсруулж батлах.




Бэлтгэл:

Самбарын цаас, маркер, скоч.



Чиглүүлэгч:

- Сургалтаас хүсч буй үр дүндээ хүрэхэд “Бидэнд ямар хандлага, харилцаа, нөхцөл бүрдэх нь сургалтыг илүү үр дүнтэй болгох вэ? Юу үр дүнг нь бууруулж магадгүй вэ?” гэсэн нээлттэй 2 асуулыг заагтайгаар асуугаад 1 минут бодох боломж олгоно.
- Тэгээд А. Самбарын цаасан дээр сургалтыг үр дүнтэй болгох оролцогчдоос “шидсэн” саналын жагсаалт бичнэ. Мөн Б. Самбарын цаасан дээр Сургалтын үр дүнд саад болох зүйлсийн жагсаалтыг оролцогчдын санал болгосноор жагсаан бичнэ.
- Оролцогчдын саналын жагсаалт нь бидний баримтлах, санаж байх, бусдыгаа хүндлэх үнэт зүйл гэдгийг сануулж хананд сургалтын туршид байрлуулж мөрдөхийг сануулна.
- Оролцогчид жагсаалтанд оруулах саналаа хэлэлцээд, шаардлагатай бол шинэчилж нэмж, эсвэл хасч болно.





ХОЁРДУГААР ХЭСЭГ

Хүний эрх, эрхэд суурилсан хандлагын тухай одоогийн ойлголт

60 (минут)

2.2.1 Бүлгийн ажил (30 мин)



Зорилго:

- Хүний эрх, эрх чөлөөний талаар эргэцүүлж эхлэх;
- Хүний эрхэд суурилсан хандлагын тухай одоогийн ойлголтын төсөөллөө илэрхийлэх;
- Сургалтын төгсгөлд энэ ойлголтоо эргэн харж, дахин тодорхойлох суурийг тавих



Бэлтгэл:

Самбарын цаас, өнгө өнгийн наадаг цаас, маркер бэлтгэнэ. Ханан дээр эдийн засаг, нийгэм, соёл, иргэний, улс төрийн эрхүүдийг томоор бичиж хооронд нь зайтай нааж байрлуулсан байна. Үүнийг оролцогчдыг өөр өөрийн даалгавраа гүйцэтгэж байх зуур байрлуулсан байна. Хавсралт-2-оос харна уу.



Чиглүүлэгч:

Оролцогчдыг 3-4 бүлэгт хувааж самбарын цаас, өнгө өнгийн эсгий бал тарааж өгнө.

Бүлгүүд нэг ижил даалгавар гүйцэтгэнэ. Даалгавар үндсэн 2 хэсэгтэй.

- Эхний хэсэгт: Оролцогч бүр өөрсдийн мэддэг хүний эрхүүдийг өнгийн цаасан дээр бичиж даалгавар өгнө. Ингэхдээ нэг цаасан дээр нэг л эрх бичнэ. Эсвэл тодорхой эрхүүдийг өнгийн цаасан дээр бичсэн картыг тарааж өгнө. Ингэхдээ нэг хүнд 2-3 эрх оногдохоор картуудаа бэлтгэсэн байна.
- Өөрийн бичсэн эрхүүдээ эсвэл оногдсон карт бүхий эрхүүдийг ханан дээр байрлуулсан эрхүүдийн төрөлд (улс төрийн эрх, иргэний эрх, эдийн засгийн эрх, нийгмийн эрх, соёлын эрх) өөрөө аваачиж төрөлжүүлэн байрлуулна. 5 минутад багтаан гүйцэтгэнэ.
- Хоёрдох хэсэгт: Оролцогчид 4 багт хуваагдан сууж эхний 2 бүлэг нь баг дотроо эрх болон эрх чөлөө гэж юу болох, ялгаатай ойлголт эсэх талаар ярилцаж хариултаа самбарын цаасан дээр буулгаж тайлбарлана. Үлдсэн 2 бүлэг нь “Хүний эрхэд суурилсан хандлага гэж юу? болох талаар төсөөллөө ярилцан санал солилцож хариултаа бусдад тайлбарлана. Үүнд 5 минут зориулна гэдгийг тайлбарлаж хэлнэ.
- Бүлгүүд тав таван минутанд багтаан бүлгийн ажлаа танилцуулна. Бүлэг бүр сургалтын туршид өөр өөр илтгэгчдийг давхардуулахгүй томилохыг сануулна.



Эхний дасгал ажлыг дүгнэж хэлэлцэх:

- Оролцогчдын хананд байрлуулсан эрхүүдийг хэрхэн зөв байрласныг харахыг урьж хэлэлцүүлэг өрнүүлнэ. Энэ хугацаанд чиглүүлэгчдийн багийн нэг гишүүн оролцогчдод Хавсралт 3–т оруулсан Хүний эрхийг төрөлжүүлсэн хүснэгтийг тарааж өгнө.
- Оролцогчид өөрийн төрөлжүүлж байрлуулсан эрхийг зөв эсэхийг хүснэгттэй тулган хянаж зөв болгож байрлуулан мэдлэгээ сэргээж цэгцэлнэ.

Хоёрдох дасгал ажлыг дүгнэж хэлэлцэх:


- Оролцогчид бүлгээр хэлэлцээд 1-2-р бүлэг “Хүний эрх гэж юу болох, эрх чөлөө гэдэг юу вэ” гэдгийг тодорхойлж, ялгааг одоогийн ойлголтоор тайлбарлана. 3-4-р бүлэг “Хүний эрхэд суурилсан хандлага”-ыг яг юу гэж бодож байгаа төсөөллөө нэгтгэж тайлбарлана;
- Чиглүүлэгч бүлгүүдийн гаргаж ирсэн тодорхойлолтуудыг нэгтгэн, “Хүний эрх, эрх чөлөө”, “Хүний эрхэд суурилсан хандлага”-ын талаарх нэгдсэн тодорхойлолтыг хэрхэн гаргасан шинжүүдийг тоочиж, ярилцах ба зөв бурууг ялгаж ойлгуулах гэж мэрийхгүй. Учир нь одоогийн төсөөллөө, хожим олох мэдлэг, ур чадвар, хандлагын дараа эргэн харж эргэцүүлэн, хүсч байсан мэдлэг, ур чадвараа өөрсдөө олж авах юм.

2.2.2 Хэлэлцүүлэг/Дүгнэлт (30 минут)



Чиглүүлэгч:

Нэгдсэн тодорхойлолтын дүрслэлийг гаргахдаа дараах асуултуудыг тавьж, хариулт өгч хэлэлцэхийг хичээгээрэй.



- А хэсгийн даалгаврыг хэлэлцэхэд: Оролцогчид голдуу “Хүний эрхүүд бичих хэсэгт амьд явах, үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, мэдээлэл авах, хөдөлмөрлөх, чөлөөтэй зорчих, сонгох сонгогдох, өмчлөх эрх, гэх мэт нийтлэг яригддаг, хэвлэл мэдээллээс сонссон болон улс төрийн эрхийн талаар илүү илэрхийлэх байх. Чиглүүлэгч нь оролцогчдын гаргаж ирсэн эрхүүдийг ярилцах явцдаа самбарын цаасан дээр ангилах байдлаар төрөлжүүлэн 5 эгнээ болгон ангилсныг уншиж эргэлзэж байгаа хүн байна уу? төрөл хооронд өөрчлөх эсэх талаар товч ярилцана.
- Б хэсгийн даалгаврыг хэлэлцэхэд: Эхний 1-2-р бүлгийн гаргасан “Эрх болон эрх чөлөө” гэж юу болох ялгааг хэрхэн тайлбарлаж байгааг нухацтай сонсож хандлагыг ажиглах, бусдаас өөр санал байгаа эсэхийг асууж хэлэлцэнэ. 3-4-р бүлгийн “Хүний эрхэд суурилсан хандлага” гэж юу? болох одоогийн ойлголтоо илэрхийлсэн бүлгийн танилцуулгыг сонсож Яагаад? гэсэн асуултыг тавьж илүү ухаж тайлбарлуулах нь чухал. Оролцогчид энэ талаар ойлголт муутай, илэрхийлэх байдал хангалтгүй байж болно.
- Хэлэлцсэн хоёр хэсгийн үйл ажиллагаа бүхий цаасыг сургалтын танхимд харагдахуйц газар байрлуулна. Учир нь дараа эргэж дахин хэлэлцэх юм.
- Оролцогчдыг анхаарлаа энэ асуудлаас түр хөндийрүүлээд дараагийн сэдэвт орохыг хүснэ.

2. 3.1 Эрх мэдлийн алхалт¹: Дасгал / тоглоом (хугацаа 20 мин)

Зорилго:

- Нийгэм нэгэн цул биш, олон янзын бүлгээс бүрдэж буй, тэдгээр бүлэг эрх мэдэл, боломж, хүний эрх, эрх чөлөөгөө эдлэх боломжоороо ялгаатай, энэ бүгд нь хувь хүний хандлага, чадвартай холбоотой гэхээсээ илүү тэгш бус, шударга бус тогтолцоонуудтай холбоотойг ойлгуулж, мэдрүүлэх;
- Энэ ялгаатай байдлыг эрх мэдэл, эд баялаг, тэгш бус хуваарилалт, нийгмийн давхраажилт, улс төр, нийгэм, эдийн засаг, соёлын тогтолцоонуудтай холбон шинжлэх.
- Хэн, ямар учраас нийгэмд эрхээ тэгш эдэлж, дуу хоолойгоо гаргаж, эрх ашгаа хамгаалж, өөрийгөө үр дүнтэй төлөөлж болон төлөөлүүлж, эрхээ бүрэн эдэлж чадахгүй байгааг тодорхойлох;
- Шийдвэр гаргагчдын хувьд хүний эрх, тэгш эрх, ардчилсан нийгмийн суурь зарчмуудтай нийцсэн маягаар иргэдэд хэрхэн үйлчилж ажиллах, төрийн хүний эрхийг биелүүлэх үүргээ хэрэгжүүлэх талаар эргэцүүлэн бодож, эдгээр ойлголт, зарчмуудад суурилан өөрийн хандлага, үзэл баримтлалыг эргэн харж, эргэцүүлэхэд нь туслах.



Бэлтгэл:

Оролцогчид мөр зэрэгцэн нэг эгнээ болон зогсох, мөн урагшаа 20-иод жижиг алхам хийх, хойшоо ч 20-иод жижиг алхам хийх хангалттай зайтай байх хэрэгтэй. Оролцогчдын тоогоор дүр оноосон зурвас, асуумжийн хуудас бэлтгэнэ. Хүн бүр үзгээ барьж нэг эгнээ болж жагсана. Өөрөөр хэлбэл “тэгш гараан дээр” зогсоно. Хавсралт 4-өөс харна уу.

Чиглүүлэгч:

- Оролцогчид “Эрх мэдлийн алхалт” нэртэй дүрд хувирдаг дасгал хийнэ. Хүн бүрт нэг нэг дүр оноосон зурвас тарааж өгнө, тэр зурвасыг зөвхөн өөрөө л уншина, хажуу дахь хүндээ үзүүлж болохгүй гэдгийг хэлнэ. Дүрээ аль болох сайн, бодитоор төсөөлж, оногдсон дүрдээ аль болох сайн орж хувирахыг хичээх хэрэгтэй гэж анхааруулна. Мөн хэнд ч ямар ч дүр оногдож болно, энэ нь нийгэмд байгаа бодит хүмүүс гэдгийг сануулах хэрэгтэй. Ихэнх хүмүүс хөгжлийн бэрхшээлтэй эсвэл, шоронд байгаа хүний дүр оногдоход цээрлэх байдал ажиглагддаг тул энэ талаар сайтар тайлбарлаж ойлгуулах хэрэгтэй.

¹- Энэтхэгийн эмэгтэйчүүдийн/хүний эрхийн активист Маниша Гуптегийн боловсронгуй болгосон, МОНФЕМНЕТ үндэсний сүлжээний “Жендэрийн шударга ёс ба эр жендэр” сургалтын хүрээнд орчуулж, Монголын нөхцөлд нийцүүлэн шинэчилсэн “Эрх мэдлийн алхалт” дасгал



- Оролцогчдод дүрдээ хувирах 30-аад секунд олгоод, мөр зэрэгцүүлэн нэг эгнээ болгон өрөөний голд зогсооно. Урагшаа, хойшоо алхах хангалттай зай байх ёстойг анхаараарай.
- Оролцогч бүрт асуумжийн хуудас өгөөд дараах тайлбарыг өгнө: “Чиглүүлэгч асуултуудыг нэг нэгээр нь уншиж өгнө, асуултанд “тийм” гэж хариулбал урагш нэг алхана, “үгүй” гэж хариулбал хойш нэг алхана, хэрэв эргэлзэж түдгэлзэж байгаа бол байрандаа үлдэнэ. Гэхдээ аль болох “тийм” эсвэл “үгүй” гэсэн хариулт сонгож алхалт хийхийг хичээх хэрэгтэй. Мөн хариулт болгоноо асуумжийн хуудсан дээрээ тэмдэглэнэ. Төгсгөлд нь дүр тус бүр оноогоо тооцоолж гаргана.
- Оролцогчдоос асууж тодруулах зүйл байгаа эсэхийг лавлаад, шаардлагатай бол нэмэлт тодруулга өгнө. Мөн зай давчуу бол алхаа бүр маш жижигхэн байх шаардлагатай гэж анхааруулаарай.
- Бүх асуулт дуусахад оролцогчид нилээн тархсан, зарим нь нэлээн урд, зарим нь голд, зарим нь нэлээд хойно зогсож байх болно. Хүмүүст оноогоо дүгнэх хугацаа олгоно, байрандаа зогсож хэн ямар дүр байсан эсэхийг бусдадаа танилцуулна.
- Эхлээд хамгийн урд байгаа хүмүүсээс тэд хэн болохыг, хэдэн оноо авсныг, хүйсийн хувьд ямар харьцаатай байгааг тодруулна. Дараа нь дунд хэсэгт байгаа хүмүүсээс, сүүлд нь ард байгаа хүмүүсээс асууна. Ингэхдээ оноосон дүрээр нь аль хэсэгт эмэгтэйчүүд, хүүхэд, ахмад, эрэгтэйчүүд байгааг болон ямар насныхан хаана зогсож байгаа талаар хэлэлцэж тогтоохыг хичээх хэрэгтэй.

Жич: Тоглоомын явцад “элит”, “дундаж”, “эмзэг” бүлэгт хуваарилагдах хүмүүсийн тоо, авсан оноог сайтар тогтоогоод, дотроо тэднийг ийнхүү тооны хувьд харьцангуй тэнцвэртэй 3 бүлэгт хуваах бэлтгэлээ хийнэ.

- Чиглүүлэгч эргээд оролцогчдын өөдөөс харан, хананы наана зогсоод: “Хүмүүс ээ, миний ард манай нийгмийн бүх нөөц баялаг байна. Та нар бүгдээрээ энэ нийгмийн иргэд тул энэ бүхэн та нарынх гэсэн үг. Та бүхэн 15 хоромд багтан, нэгэн ижил алхаагаар алхаж ирээд энэ баялгаас авцгаа!” гэнэ.
- Ихэнх тохиолдолд урд байгаа хүмүүс алхах ч шаардлагагүй, гараа сунгаад хананд хүрдэг. Ард нь зогсож буй дунд хэсэгт зогсож буй хүмүүс алхаж ирээд алгаа хананд наана. Сүүлдэж ирэх тусам хананд хүрэхэд хэцүү, хүрэхгүй үлддэг. Мөн хамгийн ард байгаа хэдэн оролцогч очихыг ч оролдохгүй, байрандаа үлддэг.
- Ард үлдсэн хүмүүсээс яагаад нийгмийн баялагаас авахаар ирэхгүй байгааг нь асууж хэлэлцүүлэг өрнүүлнэ. Алхаж, гүйж ирсэн хүмүүсээс санаа, сэтгэгдлийг нь асууна, дараа нь урд, ойрхон байсан хүмүүсээс асууна.
- Хэсэг ярилцаад, оролцогчдыг дүрээсээ гараад, тойрон суухыг урина. Тэгээд дараах асуултуудыг ашиглан хэлэлцүүлэг, хамтын дүн шинжилгээг чиглүүлнэ:
 - Энэ дасгал ямар бодол, мэдрэмж төрүүлсэн бэ?
 - Хамгийн урд ямар хүмүүс байсан бэ? (Анги, давхарга, хотын, хөдөөний, эрэгтэй, эмэгтэй, албан тушаал, хөгжлийн бэрхшээл, ажиллаж буй ажил салбар, амьдралын орлого олж буй хэлбэр, бэлгийн баримжаа, нас зэргээр нь авч үзнэ);
 - Урд байсан хүмүүс урагшаа алхаад байхад ямар санагдсан бэ? Бусдаас тасраад байхад ямар мэдрэмж төрсөн бэ?



- Урд байсан хүмүүсийн дунд эмэгтэй хүн байна уу? Цөөхөн үү, олон уу? Хэдэн асуултад “тийм”, хэдэн асуултад “үгүй” гэж хариулсан бэ? Ямар нэгэн асуултанд “үгүй” гэж хэлсэн үү? Яг ямар асуултад “үгүй” гэсэн бэ? Яагаад?
- Дунд хэсэгт ямар хүмүүс байсан бэ? (Анги, давхарга, хотын, хөдөөний, эрэгтэй, эмэгтэй, албан тушаал, хөгжлийн бэрхшээл, ажиллаж буй ажил салбар, амьдралын орлого олж буй хэлбэр, бэлгийн баримжаа, нас зэргээр нь авч үзнэ);
- Ямар асуултад “тийм”, ямар асуултад “үгүй” гэж хариулсан бэ? Яагаад? Ямар мэдрэмж төрсөн бэ?
- Дунд хэсэгт эмэгтэй хүн цөөхөн байна уу, олон байна уу? Яагаад?
- Ард ямар хүмүүс байсан бэ? (Анги, давхарга, хотын, хөдөөний, эрэгтэй, эмэгтэй, албан тушаал, хөгжлийн бэрхшээл, бэлгийн баримжаа, ажиллаж буй ажил салбар, амьдралын орлого олж буй хэлбэр, нас зэргээр нь авч үзнэ);
- Яагаад хойшоо алхаад байсан бэ? Хэдэн асуултад “тийм” хэдэн асуултад “үгүй” гэж хариулсан бэ? Ямар асуултад “тийм” гэж хариулсан бэ? Яагаад? Ямар мэдрэмж төрсөн бэ?
- Ард байсан хүмүүсийн дунд эрэгтэйчүүд байна уу? Ямар эрэгтэйчүүд байна вэ?
- Эмэгтэйчүүд байна уу? Ямар эмэгтэйчүүд байна вэ?
- Нийгмийн баялагаас бүгд хүртэж чадсан уу? Үгүй бол яагаад? Ямар мэдрэмж төрсөн бэ?
- Хүмүүс яагаад ийм өөр, өөр байршилтай байна вэ?
- Энэ байршил юуг илтгээд байна вэ? Хаана байгаа хүмүүс хүний эрх, эрх чөлөөгөө илүү эдлэх боломжтой вэ? Хэний эрх, эрх чөлөө илүүтэй зөрчигдөх вэ?
- Ард байгаа, ядуу, эрх мэдэл багатай хүмүүс өөрсдийн буруугаас болоод тэнд байна уу?
- Урд яваа хүмүүс зөвхөн өөрсдийн гавъяагаар давуу эрхтэй болсон уу?
- Манай нийгэм энэ дасгалтай адилхан уу? Юугаараа адил, юугаараа өөр вэ?
- Та өөрөө, орон нутгийн шийдвэр гаргагч, төрийн үүрэг хэрэгжүүлэгчийн хувьд энэ нийгмийн хаана нь байна вэ? Та хэнийг, аль хэсгийг нь төлөөлж буй гэж бодож байна вэ?

Хэлэлцүүлгийн цаг дуусахад оролцогчдод идэвхтэй, чин сэтгэлээсээ оролцсонд нь талархлаа илэрхийлээд энэ дасгалд суурилсан бүлгийн ажилдаа орохыг санал болгоно.

2.3.2 Бүлгийн ажил: Танай бүлгийнхний эрх, эрх чөлөө хангагдаж байна уу? хэлэлцүүлэг (30 минут)



Зорилго:

Хүний эрх, эрх чөлөөний тухай ойлголтыг гүнзгийрүүлэхийн зэрэгцээ нийгмийн шударга бус бүтэцжилт, тогтолцооны улмаас хүн бүр эрх, эрх чөлөөгөө тэгш эдэлж чадахгүй байгааг мэдрүүлэх, энэ нөхцөлд иргэддээ төрийн үйлчилгээг хэрхэн хүргэж үйлчлэх, иргэд хэрхэн эрхээ хамгаалуулах, төрөөс хэний эрх ашгийг түлхүү анхаарах шаардлагатай тухай эргэцүүлэх сэдэл өгөх.



Бэлтгэл:

Хүний эрхийн түгээмэл тунхаглал (ХЭТТ)-ыг болон Үндсэн хуулийн 16–р зүйлийг хүний тоогоор хувилсан байна. Хавсралт 5, 6—аас харна уу



Чиглүүлэгч :

- Оролцогчдоос эргээд “Эрх мэдлийн алхалт”-ын дүрдээ орохыг хүсээд, тэднийг өмнөх дасгалд суурилан нийгмийн 3 давхарга буюу бүлэгт (Элит, Дундаж, Эмзэг) хуваагаад дараах тайлбарыг хэлж өгнө. Үүнд:
 - Оролцогчид “Эрх мэдлийн алхалт” дасгалын дүрүүдээрээ хоорондоо танилцаж, тэдгээр дүрийнхээ өмнөөс төсөөлөн бодож ХЭТТ болон Үндсэн хуулийн 16-р зүйлийг ашиглан ямар эрх нь хангагдаж, ямар эрх нь зөрчигдөж байгааг бүлгээрээ хэлэлцэн тодорхойлно.
 - Эрх бүрэн хангагдаж байгаа бол (+) тэмдэг, огт хангагдахгүй байгаа бол (-) тэмдэг, хагас хангагдаж (±) тэмдэглэгээг тус тус хийж нэгдсэн тоог тус бүр гаргана. Ингэхдээ тухайн эрх, эрх чөлөөний утга, ач холбогдлыг гүнзгийрүүлэн ойлгохыг хичээнэ.
 - Бүлгийн ажлыг 30 минутанд хийж, хэлэлцүүлгийн үр дүнгээ самбарын цаасан дээр тэмдэглэж, 5 минутанд танилцуулахад бэлтгэнэ.
 - Бүлгийн ажлын цаг дуусахад 5 минут үлдэхэд сануулна. 30 минут өнгөрмөгц бүлгүүдийг танилцуулга хийхийг хүснэ.
 - “Элит,” “дундаж”, “эмзэг буюу эрх мэдэл багатай” давхаргыг төлөөлсөн бүлгүүд ээлж дарааллаар танилцуулгаа хийнэ.
 - Бүлгийн танилцуулга бүрийн дараа тухайн бүлгийн гишүүдээс нэмэх, залруулах зүйл байгаа эсэхийг лавлаад, бусад оролцогчдоос асууж тодруулах, нэмж хэлэх зүйл байгаа эсэхийг лавлан товч ярилцана.

Нэгдсэн хэлэлцүүлэг:

Нэгдсэн дүгнэлт хэлэлцүүлгээ дараах асуултуудын тусламжтайгаар чиглүүлж ойлголт, эргэцүүлэл төрүүлэх хэлэлцүүлэг хийнэ.

- Эдгээр эрх, эрх чөлөө хэр чухал вэ?
- Зарим эрх, эрх чөлөө зөрчигдлөө гээд ямар сөрөг үр дагавартай вэ?
- Эрх, эрх чөлөөгөө баталгаатай эдлэх боломж байлаа гээд бидний амьдралд ямар нөлөөтэй вэ?
- Хүн бүр эдгээр эрхийг эдлэх ёстой юу?
- Зарим хүмүүс эдлэхгүй байж болох уу?
- Яагаад бид эрх, эрх чөлөөгөө тэгш эдэлж чадахгүй байна вэ? Юу саад болоод байна вэ?
- Ямар хүмүүс эрхээ бүрэн дүүрэн эдлээд, ямар нь дутуу эдлээд эсвэл огт эдэлж чадахгүй байна вэ?
- Та дүрээсээ гараад, өнөөгийн эрхэлж буй албан тушаалын, өөрийн бодит байр суурийн хувьд өөрийнхөө эрх, эрх чөлөөг хэр эдэлж байгаагаа эргэцүүлээд үзнэ үү? Таны ямар эрх хангагдаж, ямар эрх зөрчигдөж байна вэ? Энэ нь таны амьдрал, ажилд ямар нөлөө үзүүлж байна вэ?
- Таны бодлоор, төрөөс, танай ЗДТГ-аас, ИТХ-аас ямар бүлгийн эрх ашгийг илүү анхаарах ёстой гэж бодож байна вэ?



Ярилцлагыг дүгнэхдээ дараах санааг хэлнэ:

- “Хүний эрх бол хүн бүрт хүн болж төрсний хувьд угаас заяагдсан өгөгдөл. Хүний эрх нь хүн бүрийг хүмүүний эрхэм чанараа хадгалан амьдрах нөхцлөөр хангагдахад зайлшгүй шаардлагатай, наад захын стандарт;
- Хэдийгээр хүн тэгш эрхтэй төрдөг ч нийгэм хэмээх “тоглоомын талбай” тэгш биш, мөн тоглоомын дүрэм хүмүүст тэгш боломж олгодоггүй тул хүмүүсийн нилээд нь эрх, эрх чөлөөгөө бүрэн эдэлж чадахгүй, улмаар ХҮН шиг амьдарч чадахгүй байна;
- Иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх, иргэдэд үйлчлэх үүрэгтэй хүмүүс нийгэм нэгэн цул биш, нийгмийн зарим бүлэгт давуу байдал үүсгэж, зарим бүлгийнх нь эрхийг хөсөрдүүлж байдгийг ойлгоод, хүний эрх, жендэр, анги давхарга, нас зэрэг мэдрэмжтэйгээр аливаа асуудалд хандаж сурах юм бол шийдвэр гаргах үйл явц, түүний дүрэм болон агуулга өөрчлөгдөх болно;
- ХЭТТ болон Үндсэн Хуульд заагдсан, дурьдаж жагсаагдсан эрхүүдийг харьцуулан дүгнэж ярилцах. Ингэхдээ бичвэр болон агуулга талаас нь харьцуулан ярилцах нь оролцогчдын хүний эрхийн мэдлэг улам тогтох, нухацтай хэлэлцсэнээр илүү ойлгоход нь туслах ач холбогдолтойг бодолцох хэрэгтэй. Мөн энэ 2 баримт бичгийн хувьд орхигдсон өөр ямар эрхүүд байдаг, хөгжлийн явцад шинээр бий болж байгаа болон ямар эрхүүдийг Үндсэн Хуульд нэмж оруулах шаардлагатай талаар санал солилцож ярилцах (тухайлбал, хүнсний эрх, хөгжих эрх гэх мэт);
- Өөрчлөлт амар, хялбар, хурдан байхгүй нь ойлгомжтой, гэхдээ бидэнд хүний эрхийг хангахуйц нийгэм, тогтвортой хөгжил рүү дөхөхөд, ялангуяа бичил уурхайн салбарт нэн түрүүнд ахиц гаргах шаардлага байна, боломж ч байна;
- Элитүүдийн хувьд ямар эрхүүд голдуу зөрчигдөж байгааг (энэ бүлгийнхний хувьд голдуу иргэний болон улс төрийн эрх илүү зөрчигдөх байдал ажиглагддаг), харин эрх мэдэл багатай хэсгийнхний хувьд ямар эрхүүд ихэвчлэн зөрчигдөж байгааг (энэ бүлгийнхний хувьд голдуу эдийн засаг, нийгэм, соёлын эрх илүү зөрчигдөх байдал ажиглагддаг) тогтож ярилцаад, дараагийн сэдэвтэй танилцахыг урина.



ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ

Хүний эрх түүний төрөл, хүний эрхийн зарчмууд



55 (минут)

2.4.1 Хүний эрхийн ерөнхий ойлголт, төрөл ангилал, зарчмууд танилцуулга (25 минут)

Зорилго:

- Хүний эрхийн ерөнхий ойлголт, хүний эрхийн зарчмуудын талаархи мэдлэгийг сэргээх, цэгцлэх;
- ХЭТТ болон Үндсэн Хууль дахь хүний эрхийн заалтууд тус бүрийг зорилтот бүлэг, төслийн чиглэсэн асуудалтай холбож тайлбарлан таниулах, суурь мэдлэг ойлголтыг нь цэгцлэх.



Бэлтгэл:

Танилцуулга, компьютер, проектор. Танилцуулгыг оролцогчдын тоогоор хувилж тараасан байх. Хавсралт 7-оос харна уу.

Чиглүүлэгч:

- Оролцогчдыг суудалдаа суухыг уриад доорх танилцуулгыг лекц хэлбэрээр явуулна. Чиглүүлэгч нь: Ямар нэгэн чухал санаа илэрхийлснийхээ дараа оролцогчдоос тэр талаар юу гэж бодож байгааг асууж, товч ярилцаж байна. Харин “тийм үү?”, “тийм биз дээ” гэсэн тулгасан асуулт асуухаас болгоомжлох хэрэгтэй.
- Танилцуулгын төгсгөлд нэмэлт тодруулах зүйл байгаа эсэхийг чиглүүлэгч сургалтын багийн гишүүдээсээ, дараа нь оролцогчдоос лавлаж, бодит амьдрал дээр хүний эрхийн тухай, хүний ямар төрлийн эрхийг, ямар зарчмыг танайд хангасан туршлагаасаа эсвэл хэрэгждэггүй зөрчигддөг кейсээ ярилцана. (ялангуяа бичил уурхайн үйл ажиллагаанд)

2.4.2 Хэлэлцүүлэг/ Дүгнэлт: (30 минут)

Төгсгөлд нь дараах санаануудыг дүгнэж хэлнэ.

- Хүний сайн сайхан байдал, тэгш эрхийг баталгаажуулах нь энх тайван амьдралын үндэс болохыг дэлхийн хоёрдугаар дайны ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэл хүн төрөлхтөнд ойлгуулсан. Иймээс энэ уй гашууг дахин амсахгүйн тулд Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-аас Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалыг батлан 12 дугаар сарын 10-ны өдрийг “Олон улсын хүний эрхийн өдөр” хэмээн дэлхий даяар тэмдэглэх болсон;
- “Хүний эрх, эрх чөлөөг та бид зөвхөн улс төр, ажил, албан тушаалын хүрээнд, байгууллага хамт олон, олон нийтийн талбар дээр төдийгүй өөрөө өөрийнхөө эрх, эрх чөлөөг, гэр бүл, найз нөхдийнхээ хүрээнд дээдлэх, хүндэтгэх, биелүүлэх учиртай;



- Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байна. Тэдэнд оюун ухаан, өрлөг сэтгэл заяасан бөгөөд өөр хоорондоо ахан дүүсийн ёсоор харилцах ёстой²;
- Хүний эрх бол таныг хүний зэрэгтэй амьдрахад шаардагдах наад захын баталгаа юм. Хүмүүс ихэнхдээ амьд явах, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, хөдөлмөрлөх гэх мэт цөөн хэдэн эрхийг л мэддэг. Гэтэл үнэндээ эдгээрээс гадна маш олон эрхийг ОУ-ын болон Үндэсний хуулиар баталгаажуулсан байдаг;
- Хүнийг үндэс угсаа, хэл, арьс өнгө, нас хүйс, нийгмийн гарал байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно³;
- Хүний эрх жам ёсны шинжтэй. Өөрөөр хэлбэл, хүний эдлэх эрхийг аль нэг төр эсвэл хэн нэгэн хүн өгдөггүй, бүтээдэггүй. Өөрөөр хэлбэл, хүн бүрт гар хөл, чих заяаж төрдөг шиг хүний эрх төрөлхөөс заяадаг. Тэгэхээр, хүн бүр ямар ч ялгаваргүйгээр эрх, эрх чөлөөгөө эдлэх ёстой. Хүний эрх дэлхийн хаана ч ижил дээдлэгдэх учиртай;
- Ядуу байх, ажилгүй байх нь хүний эрхийн хамгийн том зөрчил юм. Хоол хүнс, хувцас, орон байр нь хангалттай, дутагдах гачигдах зүйлгүй байх нь эдийн засгийн эрх биелэгдэх үндсэн нөхцөл нь болдог. Эдийн засгийн хязгаарлагдмал, хомс, гачигдалтай байдалд байх нь хүний эрхийн бусад эрх, эрх чөлөө зөрчигдөх шууд нөхцөл болдог. Эдийн засгийн эрх, эрх чөлөө нь хангагдаагүйгээс хэн нэгний хараат болох, тэвчишгүй хөдөлмөр эрхлэх, хөдөлмөрийн мөлжлөг, хүчирхийлэлд өртөх үр дагаварт хүргэдэг. Энэ эрхийг төр биелүүлэх үүргийг ЭЗНСЭП-д баталгаажуулсан⁴. Ядуурлыг урьд өмнө хүний эрхийн зөрчил гэж төдийлөн авч үздэггүй байсан бөгөөд МХЗ-ыг тодорхойлсноор илүү тодруулж авч үздэг болсныг хэлэх хэрэгтэй;
- Хүний эрхийг ХЯЗГААРЛАЖ БОЛНО. Хүний эрх, эрх чөлөөг үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, нийгмийн эрүүл мэнд, нийгмийн ёс суртахуун, бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах зорилгоор хязгаарлаж болно. Хүний эрхийг хязгаарлах дээрх нөхцлүүдийн хил хязгаар, хэр хэмжээг олон улсын эрх зүйн баримт бичгүүдээр тодорхойлсон;
- Хүний эрх хуваагдашгүй бөгөөд нэг эрх зөрчигдөхөд бусад эрхүүд давхар зөрчигдөж байдаг. Нэг эрхээр нөгөө эрхийг барьцаалж эсвэл нэг эрх нь зөрчигдөөд бусад нь биелэгдэж байгаа гэж болохгүй юм.

² - Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал. 1946 он. Нэгдүгээр зүйл

³ - МУ-ын Үндсэн хууль. 1992 он 14.2 заалт. Төрийн мэдээлэл 1992 оны 01 дугаар.

⁴ - ЭЗНСЭП- 11-р зүйл: Улс орнууд нь хүн бүрийн болон түүний өрх гэрийн хүрэлцээтэй хоол хүнс, хувцас, орон сууцыг оролцуулан амьдарлын хүрэлцээтэй түвшинд аж төрөх, амьдарлынхаа нөхцлөө байнга сайжруулах эрхийг биелүүлнэ.

ТАВДУГААР ХЭСЭГ

Асуудалд дүн шинжилгээ хийх

70 (минут)

2.5.1 Тулгамдсан асуудлыг тодорхойлох, эрэмбэлэх бүлгийн ажил (15 минут)



Зорилго:

- Орон нутгийн тогтвортой хөгжлийг хангахад оролцогч аль ч тал, аль ч оролцогчийн хувьд аливаа хөгжлийн бодлого шийдвэр гаргахын өмнө тухайн шийдвэрийг гаргаснаар зохицуулах асуудал, хэрэгжүүлэх бодлогын асуудалд эрхэд суурилсан дүн шинжилгээ хийх нь шийдвэрийн хэрэгжилтэд чухал нөлөөтэй болохыг ойлгуулж итгэл үнэмшил төрүүлэх, иргэдийн шийдвэрийн төсөлд утга учиртай оролцох, олон нийтийн хэлэлцүүлэгт саналаа өгөх нь иргэний хариуцлага болох, хэрэгжилтийг хянах түүнчлэн дүн шинжилгээ хийх чадавх олгох;
- Бичил уурхай эрхлэгчдийн өмнө тулгамдаж буй асуудал тэдгээрийн орон нутгийн хөгжилд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэхэд, тэдэнтэй илүү үр дүнтэй түншлэл үүсгэхэд тулгарч буй асуудлын мөн чанар нь эрхэд суурилсан шинэ хандлага, илүү ардчилсан хамтын ажиллагаа шаардаж байгааг ойлгуулах, Бичил уурхай эрхлэгч (БУЭ) илүү хариуцлагатай ажиллах, шаардлага байгааг ойлгуулах.



Бэлтгэл:

Самбарын 1-2 цаас хананд байрлуулж бэлтгэсэн байна. Мөн маркер бэлтгэнэ.



Чиглүүлэгч:

- “Оюуны дайралт ба санаа бодлыг цуглуулах арга” - аар орон нутгийн тогтвортой хөгжилд саад болж байгаа, тухайн бүлэг, хамт олны өмнө тулгамдсан асуудлыг гаргуулна. Энэ арга нь оролцогчдыг санаагаа чөлөөтэй хэлэх боломж олгож, шинэ санаа гаргадгаараа бусад аргаас ихээхэн ач холбогдолтой.
- Оролцогчдын хэлсэн санааг яг тэр чигээр нь хананд байрлуулсан самбарт хэлсэн дарааллаар нь гаргацтай дугаарлан бичнэ.
- Оролцогчдыг санаагаа хэлж дууссаны дараа давхацсан болон агуулга нэг санааг багцлан өөр нэг цаасан дээр бичнэ. Ингэхдээ зөвхөн оролцогчдын санал, шийдэлд бүрэн тулгуурлана.
- Ингэж багцалж, нийт оролцогчдын саналаар дугаарлан бичсэн тулгамдсан асуудлуудаа дахин уншиж хэлэлцээд нэмэх эсвэл хасах санал байгаа эсэхийг хэлэлцэнэ. Эцсийн байдлаар тухайн орон нутагт шийдвэрлэх шаардлагатай, тулгамдсан асуудал мөн гэж үзсэн асуудлууд дээр Хавсралт 10-д оруулсан шалгуур үзүүлэлтийн дагуу нягтлан ярилцана. Тулгамдсан асуудал уу? Бэрхшээл үү? гэдгийг ялгаж ярилцаад бэрхшээлийг дарж тэмдэглэнэ.



- Ингээд үлдсэн тулгамдсан асуудлаа дахин уншиж танилцуулж батлана;
- Жагсаалтад байгаа нийтийн эрх ашигтай холбоотой гэж үзсэн, зайлшгүй шийдвэрлэх тулгамдсан асуудлуудаа эрэмбэлнэ. Оролцогч бүр өөрийн зүгээс хамгийн чухал гэж үзсэн 3 асуудлын ард (✓) тэмдэглэгээ хийх замаар нийт оролцогч саналаа өгнө. Ингээд эцэст нь жагсаалтад орсон тулгамдсан асуудал бүрийн ард хүмүүсийн өгсөн (✓) тэмдэглэгээний (саналын) нийлбэрийг гаргаж хамгийн олон санал авсан 3 хүртэл асуудлыг авч дүн шинжилгээ хийх саналыг хэлж тайлбарлана.
- Оролцогчид гурав ба түүнээс илүү асуудлыг эрэмбийн дарааллаар авч, дүн шинжилгээ хийх санал гаргаж болно. Тэгвэл тухайн үед олонхийн саналыг аваад нийт оролцогчид дэмжиж байвал нэмэлтээр авч ажиллаж болно.

2.5.2 Дасгал/Ярилцлага (45 минут)



Зорилго:

- Тулгамдсан асуудлаас гадна аливаа асуудалд дүн шинжилгээ хийх ур чадвар олгох;
- Хөгжлийг бий болгох, одоо байгаагаас илүү үр дүнтэй болгох аливаа асуудалд дүн шинжилгээ хийх, улмаар асуудлыг үүсгэж буй суурь шалтгаан, түүнд нөлөөлж буй хүчин зүйлс, тухайн асуудлаас нийгэмд үүсэн гарч буй үр дагаврыг ялгаж үзэх ур чадвар олгох.



Бэлтгэл:

- Оролцогчдын гаргасан тулгамдсан асуудлын эрэмбээр сонгож авсан асуудлын тоогоор 3-4 бүлэг болгож, бүлэг бүрт (өөрсдийнх нь сонголтоор байж болно) нэг нэг асуудал оноож өгөөд асуудлын дүн шинжилгээ хийх аргачлалыг тайлбарлаж, удирдамжийг тарааж өгнө;
- Хавсралт 8 болон 9 зааврыг оролцогчдын тоогоор хувилж тараана.



Чиглүүлэгч:

- Бүлгүүд 30 минутын дотор тулгамдсан асуудлын суурь шалтгаан, нөлөөлөгч хүчин зүйлс, сөрөг үр дагавар, уг асуудлын улмаас хамгийн их хохирч буй хүмүүс/бүлгүүд, асуудлыг шийдвэрлэхэд зайлшгүй оролцох шаардлагатай байгууллага, хувь хүмүүс, бүлгүүд (хуулиар үүрэг хүлээсэн болон нийтийн сайн сайхны төлөө зохион байгуулалттай бүлгүүд)-ийг тодорхойлж шинжилнэ. Асуудлын дүн шинжилгээгээ бүлгүүд 5 минутын дотор нийт оролцогчдод танилцуулна.
- Чиглүүлэгчид бүлгүүдэд дүн шинжилгээгээ хийхэд нь идэвхижүүлж хүний эрхийн өнцгөөс, эрхэд суурилсан асуулт тавих замаар чиглүүлж саналаа хэлж тусална.




Энэ үед бүлгүүд тухайн тулгамдсан асуудалд ШИЙДЭЛ хайхгүй зөвхөн дүн шинжилгээ хийж, **суурь шалтгааныг олно** гэдгийг сайтар сануулах хэрэгтэй. Ихэнх тохиолдолд шийдэл, хариу арга хэмжээ төлөвлөж цагаа үрэх тал байдаг



2.5.3 Хэлэлцүүлэг / Дүгнэлт (15 минут)

- Бүлгүүд өөр өөрийн оногдсон асуудалд дүн шинжилгээ хийнэ:
 - Асуудал нь өөрөө юу вэ?
 - Асуудлыг бий болгосон суурь шалтгаан нь юу вэ?
 - Асуудалд нөлөөлж буй хүчин зүйлсүүд юу юу байна вэ?
 - Асуудлаас үүсч гарсан үр дагаврууд юу юу байна вэ? гэдгийг ялгаж, удирдамжийн дагуу багаар хэлэлцэж гаргаснаа “Асуудлын мод” зурж тодорхойлсон байна.
- Бүлгүүдийн ажлыг хананд байрлуулаад, бүлгүүд өөр өөрсдийн бүлгийн ажлыг бусад багтаа танилцуулна. Тухайн баг өөр хоорондоо хэрхэн хэлэлцсэн, санал зөрүүтэй байсан эсэх, суурь шалтгаанаа хэрхэн тодорхойлсон эсэх, асуудлаа хэрхэн зөвлөлдөж тодорхойлсноо тайлбарлана. Бусад багууд сонсож санал зөрүүтэй байгаа эсэх талаар ярилцаж хэлэлцүүлэг өрнүүлнэ;
- Төгсгөлд нь тулгамдсан асуудлыг үр дүнтэй, тогтвортой шийдвэрлэхэд олон талыг, ялангуяа эрх нь зөрчигдөж буй бүлгүүдийн төлөөллийн утга учиртай оролцоог бий болгох, оролцоог дэмжих, хамтрагчидтайгаа эрх мэдэл хуваалцах, хамтрагч бүрийн чадавхыг нэмэгдүүлэх замаар өргөн хүрээнд хамтран ажиллах хэрэгтэй бөгөөд үүнд бидний одоогийн хэрэглэж буй уламжлалт удирдахуйн аргачлалын загвар хэр тохиромжтой байгаа вэ гэдгийг эргэцүүлж үзэхийг санал болгоно;
- Асуудлууд хоорондоо хамааралтай байгаа эсэх, ямар хамааралтай байгааг асууж хэлэлцүүлгийг өдөөнө;
- Нэг асуудал нөгөө асуудлын үр дагавар эсвэл нөлөөлөх хүчин зүйл болж байгаа эсэхийг харахыг сануулж чиглүүлэн аль болох асуудлыг олон талаас харах, ингэхдээ эрхэд суурилсан хандлагаар хандахад нь асуултаа чиглүүлж өгнө. Тухайлбал, хэний эрх ашиг хохирох вэ? аль бүлэгт ач холбогдолгүй байх вэ? гэх мэт асуултуудаар чиглүүлнэ.
- Чиглүүлэгчид бүлгүүдийн ажилд дүгнэлт саналаа өгөөд тэдэнд хангалттай сайн ажиллалаа гэдгийг хэлээд талархсанаа илэрхийлж, урам өгөх хэрэгтэй. Учир нь анх удаа асуудлыг тодорхойлох, суурь шалтгааныг олж тогтоох нь амар биш байдаг.



ЗУРГААДУГААР ХЭСЭГ

Хүний эрхэд суурилсан хандлага, түүний зарчмууд

50 (минут)

2.6.1 Хүний эрхэд суурилсан хандлага танилцуулга (20 минут)



Зорилго:

- Хүний эрхэд суурилсан хандлага гэж юу болох тухай онолын мэдлэг өгөх;
- Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, дэмжих, хангах нь төрийн үүрэг болохыг, төр үүрэг хүлээгч болохыг гүнзгий ойлгосон байх ба өмнөх дасгал ажлуудтай холбон ур чадвар эзэмшиж, хандлага аргачлалдаа дүгнэлт хийж эргэцүүлэх.



Бэлтгэл:

Танилцуулга, компьютер, проектор. Танилцуулгыг оролцогчдын тоогоор хувилж тараасан байх. Хавсралт 11-ээс харна уу.



Чиглүүлэгч:

- Оролцогчдыг суудалдаа суухыг уриад доорх танилцуулгыг лекц хэлбэрээр явуулна. Чиглүүлэгч нь: Ямар нэгэн чухал санаа илэрхийлснийхээ дараа оролцогчид энэ талаар юу гэж бодож байгааг асууж, товч ярилцаж явна. Харин “тийм үү?”, “тийм биз дээ” гэсэн тулгасан асуулт асуухаас болгоомжлох хэрэгтэй.
- Чиглүүлэгч танилцуулгын өмнө: Оролцогчид та бүхэн хэдийгээр төрийн алба хашдаг, хувийн хэвшилд ажилладаг, мөн БУЭ-ийн ТББ-ын гишүүн байсан ч ялгаагүй бусад иргэдийн нэгэн адил төрөөс үйлчилгээ авдаг, төрөөр хамгаалуулах эрхтэй энэ нутгийн иргэд гэдгийг хэлэх хэрэгтэй.
- Танилцуулгын төгсгөлд нэмэлт тодруулах зүйл байгаа эсэхийг чиглүүлэгч гишүүдээсээ, дараа нь оролцогчдоос лавлаж, бодит амьдрал дээр хүний эрхэд суурилсан хандлагаар ямар асуудлыг шийдэж байсан (жишээлбэл бичил уурхайн салбарт), эсвэл хичээж оролдсон тухай туршлага, эсвэл жишээ ярихыг хүснэ. Энэ талаар жижиг хэлэлцүүлэг хийж болно.
- Чиглүүлэгч нь танилцуулгын дундуур жишээ тайлбарлахдаа, асуудалд эрхэд суурилсан дүн шинжилгээ хийсэн дасгал ажлын явцаас жишээ болгон хэлж, тайлбарлах хэрэгтэй. Ингэснээр хүний эрх, эрхийн төрөл ангилал түүний дотроос эдийн засгийн болон хөдөлмөрлөх, байгаль орчны эрхүүдийн сэдэв хооронд холбож, мэдлэгийг сэргээн сануулж, урьд олсон мэдлэг ур чадварыг цэгцэлж сэргээж байх шаардлагатай.



Төгсгөлд нь дараах санаа, агуулгыг дүгнэнэ.

- Төр гэж юу вэ? Төр гэж хэн юм, ямар бүтэцтэй вэ? Яагаад “ийм олон хөл гартай” “бүтэцтэй байгаа вэ? “ Тэднийг хэн санхүүжүүлж байгаа талаар ярилцана;
- Төрийн нэн тэргүүний үүрэг ХҮМҮҮСИЙН ЭРХИЙГ ХАНГАХ, төрийн бодлогын төвд ХҮН байх ёстой. Хүн бүр эрхэмсэг, айх аюулгүй, ялгаварлал алагчлалгүй, эрх мэдэл зиндаачлалгүй, эрхтэгш, нээлттэй нийгэмд ажиллаж, амьдрах эрхтэй. Тийм нийгмийг, тийм эрх, эрх чөлөөг төр нь иргэддээ өгөх, тэр эрх, эрх чөлөөг нь ханган биелүүлэх үүрэг төрд бий;
- Харин төр нь энэ үүргээ ханган биелүүлэх, хэрэгжүүлэх онцгой чадвартай, нөөцтэй байх ёстой. Нөөц гэдэгт хүний эрхэд суурилсан хандлага, бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө гаргасан байх төдийгүй түүнийг хэрэгжүүлэх эрхэд суурилсан арга зүй, аргачлал, заавар удирдамжтай байх явдал юм. Мөн түүнийг хэрэглэж хэрэгжүүлэх хүмүүс, албан хаагчид, шийдвэр гаргагчдын мэдлэг хандлага хамгийн том нөөц болох юм.

Хүний эрхийг дэмжих, хангах, хамгаалах нь засаг төрийн зөвхөн халамж анхаарлын буюу сайн санааны үйлс төдий биш юм. Иргэд засаг төрийг эрх олж авахын тулд байгуулдаггүй, харин өөрийн эрх, эрх чөлөөгөө хамгаалуулахын тулд байгуулдаг.

- Төр эрхийг хангах үүргээ гүйцэтгэх явцдаа эрх мэдэл, дуу хоолойгоо илэрхийлэх боломж багатай бүлгийн хүмүүсийг илүү анхааран хөрөнгө төсөв хувиарлах, тэдний амьдралд нь нөлөөлөхүйц шийдвэрийг гаргахдаа тэдгээр хүмүүсийг оролцуулж, санал бодлыг тусгах үүрэгтэй;
- Хэрэв энэ оролцооны эрхийг, тэдгээрийн мэдээлэлтэй байж мэдлэг авах улмаар хөгжих эрхийг биелүүлж чадаагүй, эрхийг зөрчсөн бол засч залруулах арга хэмжээг нэн даруй авах үүрэгтэй гэдгийг сануулаад дараагийн сэдэвт анхаарахыг сануулна.



2.7.1 Хөгжлийн бодлогын баримт бичигт ХЭСХ-аар дүн шинжилгээ хийх бүлгийн ажил (30 минут)



Зорилго:

- Сэдэв 5-р дасгалын хүрээнд тухайлан сонгож авсан асуудлууд дээр бүлгээр ажиллана.
- Орон нутгийн иргэдийн нийтлэг эрх ашигт хамаатай, тулгамдсан асуудлуудыг тодорхойлж эрэмбэлэн тэдгээрийн суурь шалтгаан, нөлөөлж буй хүчин зүйлс болон нийгэм эдийн засагт үзүүлж буй ур дагавруудыг “Асуудлын мод” загвар ашиглан дүн шинжилгээ хийнэ;
- Энэ удаагийн дасгал ажлаар АСУУДАЛД биш харин асуудлыг шийдвэрлэх орон нутгийн БОДЛОГО, ХӨТӨЛБӨР-ийн баримт бичигт хүний эрхэд суурилсан хандлагаар дүн шинжилгээ хийх, бодлого боловсруулах, хэрэгжүүлэх хамтрагчдыг тодорхойлох, эрхэд суурилсан хандлагын зарчмуудыг хэрэглээ болгох үйл явцад суралцах замаар мэдлэг ур чадвараа баталгаажуулна;
- Орон нутгийн хөгжилд болон иргэдийн өмнө тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд зөвхөн шийдвэр гаргагчид төдийгүй нийгмийн олон бүлэг, сонгогчид, иргэний нийгэм, судлаачид, хэвлэл мэдээллийн хэрэгсэл зэрэг олон талын оролцоо шаардлагатай бөгөөд бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлж дүгнэх бүхий л үе шатанд тэдгээрийг оролцуулах шаардлагатай болохыг ойлгуулна.



Бэлтгэл ажил:

- 5-р хэсгийн дасгал ажлын хүрээнд хийсэн бүлэг тус бүрийн ажилласан асуудлын бүтээл тэмдэглэгээг баг тус бүрийн ар хананд байрлуулсан байна. Оролцогчдыг өмнө ажилласан бүлгээр ажиллуулна. Бүлгийн тоогоор шинээр самбарын цэвэрхэн цаас, маркер бэлтгэнэ. Бүлгүүдэд Хавсралт 12-ын ажлын удирдамж тараана;
- Тухайн орон нутгийн урт хугацааны хөгжлийн бодлого, 2012-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, 2015 оны нийгэм эдийн засгийн үндсэн чиглэлээс бүлгүүдийн сонгож авсан асуудлуудтай холбоотой зорилтуудыг сонгон авч хэвлэж бэлтгэснээ тараана.



Чиглүүлэгч:

- Бүлгийн ажил Хавсралт 9-ын удирдамжийн 9 болон 10 дахь асуултыг харах хэрэгтэй. Энэ нь тухайн асуудлыг зохицуулж буй бодлого хөтөлбөр байгаа эсэх, түүний үр нөлөөний талаар дүгнэн ярилцсан хэсгийг дахин харж сануулах хэрэгтэй.
- Дээрх бодлогын баримт бичгүүдэд хүний эрхэд суурилсан хандлагаар дүн шинжилгээ хийснээр уг ур чадварт хийнгээ суралцах, мэдлэг ур чадварыг илүү нухацтай эзэмшиж түүнийгээ хэрэглээ болгох дасгал болох тул чиглүүлэгчид дасгал ажлын үеэр бүлгүүдэд байнга тусалж ярилцана.



- Бүлгүүдийн өмнө ажилласан орон нутгийн иргэдийн нийтлэг эрх ашигт хамаатай, тулгамдсан асуудлуудын суурь шалтгаан, нөлөөлж буй хүчин зүйлс болон асуудлын байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлж буй ур дагавруудыг “Асуудлын мод” аргачлалаар дүн шинжилгээ хийсэн бүтээлүүдийг сэргээн сануулж, одоо энэ удаад энэхүү асуудлуудыг зохицуулахаар боловсруулсан бодлого, хөтөлбөрийн баримт бичгүүдэд ХЭСХ-ын үндсэн таван зарчмаар шинжилгээ хийж үзье гэж хэлнэ. Ингэхдээ тухайн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтийг үнэлэхдээ ХЭСХ-ын зарчмыг хэр мөрдөж байгаад дүгнэлт шинжилгээ хийнэ. Хавсралт 13-ын матрицыг ашиглан тийм, үгүй, хагас гэсэн үнэлгээгээр дүгнэлт хийнэ.
- Бүлэг бүрийг ажлаа танилцуулсны дараа товчхон хэлэлцүүлэг өрнүүлж, тухайн бүлгийн танилцуулгад бусад багуудын зүгээс ХЭСХ-аар хийсэн дүн шинжилгээ хэр бодитой, оновчтой болсон, мөн цаашид хэрхэн сайжруулж болох талаар бүтээлчээр, эерэгээр ярилцахад чиглүүлэгч дэмжлэг үзүүлнэ.
- Бүх бүлгийн ажилтай танилцсаны дараа үндсэн гурван асуудалд тухайн орон нутгийн төрийн үүрэг хүлээгчид ямар хандлагаар хандах, ямар аргачлалаар асуудлыг шийдвэрлэх хүчин чармайлтаа үргэлжлүүлэх талаар ярилцана.

2.7.2 Хэлэлцүүлэг/Дүгнэлт (хугацаа 25 мин)



Зорилго:

Өдрийн туршид хүний эрх, эрх чөлөөний талаар олсон мэдлэг, өөрсдийн тулгамдсан асуудлын суурь шалтгааныг тогтоох, хөгжлийн бодлогод ХЭСХ-аар дүн шинжилгээ хийх, түүнийг нэвтрүүлэхэд оролцох, хандлага сэдлийг баталгаажуулах.



Бэлтгэл:

- Бүлгүүдийн хийсэн дүн шинжилгээ бүхий цаасыг, асуудлын дүн шинжилгээний цаасны дэргэд байрлуулсан байна;
- Бүлгүүдийн ажлын танилцуулга тус бүрт чиглүүлэгчид тус бүртээ тэмдэглэгээ хийж багуудад өгөх зөвлөгөө, санал, тодруулах асуултууд бэлтгэгдсэн байна



Чиглүүлэгч:

- Бид тодорхой АСУУДАЛ түүний БОДЛОГОД 2 шатлалт дүн шинжилгээ хийлээ. Орон нутгийн түвшинд сайн бодлого байгаа, гэвч асуудал шийдвэрлэгдэхгүй хэвээр байсаар байна гэдэг нь бодлогоо эрхэд суурилсан хандлагаар дахин нягталж сайжруулах, шийдвэр гаргах арга, хандлагаа өөрчлөх болсныг харуулж байна гэдгийг тайлбарлана. Бидэнд сайн бодлого байна, гэвч асуудал санаа зовоосон хэвээр байсаар байна гэдэг нь бодлого, хөтөлбөр боловсруулах, шийдвэр гаргах арга, хандлагаа өөрчлөх болсныг анхааруулж байна гэдгийг тайлбарлана.
- Иргэд, олон нийтийн оролцоотой сургалтын хувьд оролцогчид өөрсдийн санаа зовоосон, нэн тэргүүнд шийдвэрлүүлэх шаардлагатай гэж үзсэн асуудлын талаар бодлого шийдвэр гаргахад санаачлагатай, идэвхтэй оролцох, ингэснээр эрх мэдэлжих, өөрсдийн дуу хоолой, нөлөөллөө хүчирхэгжүүлэх, улмаар шийдвэр гаргахад гэлтгүй орон нутгийнхаа тогтвортой хөгжилд гол оролцогч эзэн байх үүрэгтэй, өөриймшсэн хариуцлага авах ёстой гэдгийг дүгнэж ярилцаад энэ хэсгийг хаана.

НАЙМДУГААР ХЭСЭГ

Сургалтын явцын үнэлгээ

60 (минут)

2.8.1 Өмнөх өдрийн мэдлэгээ сэргээн хэлэлцэх



Зорилго:

Сургалтын явцыг дүгнэж, үр нөлөөгөө хэмжих, цаашид анхаарах зүйл, дутуу ойлгогдсон сэдвүүдэд тодруулга хийх бололцоог олгох. Чиглүүлэгчдийн хувьд алдаагаа олж харах, дараа дараагийн сургалтад сургамж авах



Бэлтгэл:

- Чиглүүлэгчид оролцогчдоос арай өмнө ирж, оролцогчдыг нүүр нүүрээ харж, тойрч суухаар сандлыг байрлуулсан байна;
- Ингэж суудлыг засахдаа сургалтын эхэнд гаргасан “МЭДЛЭГ”, “УР ЧАДВАР” –ын зураглалын самбар бүх оролцогчдод харагдахаар зассан байна;
- Чиглэсэн 3 асуулт бичсэн слайдыг дэлгэцэнд харуулсан байна.



Чиглүүлэгч:

- Оролцогчидтой мэндчилж, тэднийг тойрч суухыг урина. Оролцогч бүрийг сургалтын явцад шинээр мэдэж авсан, сэргээсэн мэдлэг, шинэлэг ямар ур чадварыг олж авсан, мөн хэрхэн хэрэглээ болгох сэтгэгдэл төрсөн талаар товч дүгнэж ярихыг урина. Ингэхдээ бусдадаа ярих боломж олгож товч, дүрмийн дагуу цагтаа багтаж ярихыг эвтэйхэн сануулна.
- Оролцогчдын ярьж буй дүгнэлтээс чиглүүлэгчид тэмдэглэл хийж авах бөгөөд тэдний хүлээлтийг хангаагүй ямар асуудал байгаа, түүнийг энэ сургалтаар өгөх боломжтой эсэх, боломжгүй бол хаанаас баталгаажуулж, дэлгэрүүлж авах талаар арга замыг хэлж өгнө.
- Ингэхдээ эхний өдөр хийсэн бүх зүйлийг дарааллаар, хэрхэн логиктойгоор ямар их зүйл хийснийг зааж тайлбарлан оролцогчдод баяр хүргэж урам өгөөд хоёр дахь өдрийн сургалтад хүрэлцэн ирж байгаад талархал илэрхийлнэ.




2.9.1 Танилцуулга: Тогтвортой хөгжил ба хүний эрхийн хамаарал (30 минут)



Зорилго:

- Хөгжил гэж юу болох, ямар хөгжлийг тогтвортой хөгжил гэж ойлгох, тогтвортой хөгжлийг бий болгоход оролцогч талууд, тэдгээрийн үүрэг хариуцлагын талаар гүнзгий онолын мэдлэг олж авах;
- Орон нутгийн 2015 оны нийгэм, эдийн засгийн үндсэн чиглэл баримт бичигт тогтвортой хөгжлийн үзэл баримтлалаар дүн шинжилгээ хийж мэдлэгээ баталгаажуулах чадвар эзэмшиж, хандлага аргачлалдаа дүгнэлт хийх.



Бэлтгэл:

- Танилцуулга, компьютер, проектор. Хавсралт 14-ын танилцуулгыг оролцогчдын тоогоор хувилж тараасан байх.
- Тухайн орон нутгийн 2015 оны нийгэм эдийн засгийн үндсэн чиглэлийг болж өгвөл 2014 оны үндсэн чиглэлийг авч танилцах, бүлгийн тоогоор хувилж тараах
- Монгол Улсын УИХ-аас батласан “Тогтвортой хөгжлийн бодлого”-ын зорилгыг оролцогчдын тоогоор хувилж тараах.



Чиглүүлэгч:

- Оролцогчдыг суудалдаа суухыг уриад доорх танилцуулгыг хийнэ. Чиглүүлэгч нь танилцуулгын үед ямар нэгэн чухал санаа илэрхийлснийхээ дараа оролцогчид энэ талаар юу гэж бодож байгааг асууж, товч санал солилцож ярилцана.
- Чиглүүлэгч танилцуулгын өмнө: Оролцогчдоос дараах асуултыг асууж бодох, эргэцүүлэх боломж олгоно.
 - Ер нь ХӨГЖИЛ гэж юу вэ, түүнийг юугаар хэмжих вэ?
 - Танай аймаг, сумын ХӨГЖИЛ гэдгийг та яг юу гэж хэлэх вэ? Танай сум хөгжсөнийг юугаар хэмжих вэ? Та энэ талаар юу гэж боддог вэ?
- Энэ талаар хүмүүс санал бодол, өөр өөрийн шалгуур хэмжүүрийг хэлнэ. Тэдгээрээс хамгийн дөхүүлсэн зөвийг ЯАГААД та ингэж үзэж байна? гэж дэлгэрүүлж асууж бяцхан ярилцлага



өрнүүлэх нь танилцуулгыг оролцогчид илүү ойр хүлээж авахад туслалцаа үзүүлнэ. Ялангуяа иргэдэд энэ сургалтыг зохион байгуулах үед энэ сэдвийг илүү энгийн үгээр, оролцогчдод “наалдуулж” ойртуулж ойлгуулахад анхаарах шаардлагатай.

- Танилцуулга хичээлийг Хавсралт 14-өөс харна уу.

2.9.2 Хэлэлцүүлэг/ Дүгнэлт (30 минут)

- Танилцуулгын төгсгөлд нэмэлт тодруулах зүйл байгаа эсэхийг багийн чиглүүлэгч гишүүдээсээ, дараа нь оролцогчдоос лавлаж нэмэлт мэдээлэл өгнө.
- Танай орон нутагт, суманд, багт таны бодлоор хөгжил ямар байна вэ?. Тогтвортой хөгжил бий болж байна уу?
- Та бүхэн эрх агуулагчийнхаа хувьд тогтвортой хөгжлийг бий болгоход ямар оролцоотой байж болох вэ? Таны оролцоо хэрэгтэй юу?
- Энэ талаар жижиг хэлэлцүүлэг хийж, орон нутгийн тогтвортой хөгжлийг хангая гэвэл одооноос эрхэд суурилсан хандлагын зарчмуудыг бүрэн мөрдөж боловсруулсан, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд үндэслэсэн бодлого боловсруулах ойлголтыг гүнзгийрүүлэхэд чиглэсэн өдөөсөн асуултыг нээлттэй тавьж оролцогчдын өөрчлөлт хийх, идэвхитэйгээр оролцох сэдлийг өдөөнө.
- Ингэхдээ өнөөдөр байгаа хөгжлийн бодлогоо сайжруулж хэрэгжүүлэхдээ, мөн ХЭСХ-ыг хэрэгжүүлэх бодлого хэр зэрэг үр нөлөөтэй хэрэгжиж буйг үнэлж хянахдаа ч ХЭСХ-ыг мөрдөн хэрэгжүүлэх, ер нь өдөр тутмын үйл ажиллагаандаа тогтмол мөрдөж байж гэмээ нь хүний эрхийг дээдэлсэн, хүний эрх, байгаль орчинд муу ул мөр үлдээгээгүй хөгжил л тогтвортой хөгжил болох юм гэдгийг гүнзгий ойлгуулж түүнд оролцох, нөлөөлөх хандлага сэдлийг төрүүлээд энэ хэсгийг хааж, бид яаж оролцох, яаж хянах талаар хэлэлцье гээд дараагийн сэдэв рүү шилжихийг урина.




2.10.1 Бүлгийн ажил/Ярилцлага (60 минут)



Зорилго:

Өмнөх хэсгүүдэд олж авсан мэдлэг, ухаарал, дүн шинжилгээ хийх ур чадвар болон өөрийн туршлага, бүтээлч сэтгэлгээг дайчлан, түүнийг нийтийн эрх ашгийн төлөөх хөгжлийн асуудалд хэрэглээ болгох, эрх агуулагчдын хувьд эрх мэдэлжих замаар оролцоогоо бий болгох, үүрэг хүлээгчдээс хариуцлага шаардах үүний тулд бүтээлч оролцоотой, санаачлагатай байх, хамтрагчдаа тодорхойлж хамтран ажиллах төлөвлөгөө гаргах, байгууллагуудын удирдлагуудын хувьд ажилчид, гишүүдийнхээ өмнө үүргээ хэрэгжүүлэхэд практикт бодитоор хэрэгжүүлэх “Үйл ажиллагааны төлөвлөгөө” боловсруулах.



Бэлтгэл:

- Хавсралт 15-ын бүлгийн ажлын удирдамжийг хүний тоогоор эсвэл нэг бүлэгт 2-3 оногдохоор хувилсан байх, самбарын цаас, эсгий бал, өнгө өнгийн картууд. Эхний өдөр хийсэн асуудлын дүн шинжилгээ, бодлогод ХЭСХ-аар хийсэн дүн шинжилгээнүүд бүлэг тус бүрийн арын ханан дээр ил байгаа эсэхийг хараарай;
- Аймгийн төвүүдэд хийх сургалтад зөвхөн үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах бөгөөд хэрвээ оролцогчид хүсвэл зааварчилгааны дагуу алсын хараа, зорилго, зорилтоо гаргаж болох юм;
- Боловсруулж буй үйл ажиллагааны төлөвлөгөө, түүнийг ХЭСХ-ын зарчмуудыг хэрхэн хангасан болон Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцэж чадсан эсэхийг үнэлэх. Хавсралт 16-ын матрицыг тараасан байна.



Чиглүүлэгч:

- Оролцогчдыг хүсэлтийнх нь дагуу 3-4 бүлэгт зохион байгуулна. Бүлгүүдэд хуваагдах нь оролцогчдын сонголт байж болох бөгөөд ихэвчлэн тухайн асуудлаар ажилласан багаар ажиллах сонирхол их байдаг. Гэхдээ цаг хязгаарлагдмал тул 3-аас дээш баг үүсгэх боломжгүйг тайлбарлаж өгөөрэй.
- Чиглүүлэгчийн зүгээс хоёр өдрийн сургалтын нэгдсэн тойм дүгнэлт хийнэ. Гэхдээ бид юу хийсэн бэ? Түүгээр дамжуулан ямар мэдлэг чадавхад суралцсан бэ? Асуудлын суурь шалтгаанд дүн шинжилгээ хийж эрхэд суурилсан дүгнэлт хийх, улмаар бодлогод эрхэд суурилсан хандлагын нарийн дүн шинжилгээ хийсэн. Өөрөөр хэлбэл, тулгамдсан бас шийдэл хүлээсэн асуудалд бодлогын цогц дүн шинжилгээ хийж ямар шийдэл гаргах талаар нэгдсэн ойлголттой боллоо гэдгийг хэлнэ.



- Ингээд эрх агуулагчийн сургалт, үүрэг хүлээгчийн сургалт байхаас үл хамааран зөвхөн сургалтын явцад ажилласан 3 асуудал тус бүрээр цаашид хийх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахыг тайлбарлана. Гэхдээ бид одоо байгаа нөөц чадавхидаа тохируулж төлөвлөх биш үүрэг хариуцлагаа хангалттай хэрэгжүүлэх, хүмүүсийн эрх, эрх чөлөөг бүрэн эдлүүлэх нөхцлийг бүрдүүлэх үүргээ эсвэл эрхээ эдлэх хандлагаар харж төлөвлөнө гэдгийг сануулна. Тухайлбал, Орон нутагт нөхөн сэргээгдээгүй үлдсэн талбайг сэргээж хамгаалан хүмүүсийн эрүүл аюулгүй орчинд ажиллаж, амьдрах эрхийг биелүүлэхийн тулд хамтаараа орон нутагтаа бодитой, үр дүнтэй хэрэгжүүлэх “Байгалийн нөхөн сэргээлтийг гар аргаар гүйцэтгэх төлөвлөгөө” боловсруулах бүлгийн ажил хийнэ гэх мэт.
- Оролцогчдод бүлгийн ажлын удирдамжийг тарааж өгөөд, бүлгийн ажилд 30 минут, бүлгийн илтгэгчийн танилцуулгад 5 минут зориулна гэдгийг хэлнэ.
- Стратеги төлөвлөлтөө эхний өдөр сонгосон асуудлуудад “Асуудлын мод” загвараар хийсэн дүн шинжилгээ, зураглалаа эргэж харан төлөвлөгөө хийнэ гэдгийг сануулна.
- Орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд ХЭСХ-аар хийсэн дүн шинжилгээг заавал ашиглахыг сануулж ойр байрлуулж өгнө.
- Үйл ажиллагааны төлөвлөгөөг дараахь ХЭСХ-ын зарчимд нийцсэн эсэх болон Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлсэн эсэхээ доорх матрицаар үнэлж үзэх, бусдадаа танилцуулахыг сануулна. Жишээлбэл аль нэг хөгжлийн бодлогыг ХЭСХ-аар сайжруулах ажил байж болно.
- 25 минутын дараа бүлгүүдэд 5 минут үлдсэнийг анхааруулаад, цаг дуусмагц танилцуулгаа хийхийг урина.

2.10.2 Хэлэлцүүлэг/Дүгнэлт (30 минут)

- Бүлэг бүр өөрийн оногдсон асуудлын талаар стратеги төлөвлөгөө гаргаснаа танилцуулна.
- Бүлэг тус бүрийн танилцуулгыг хэлэлцэж дуусаад, ерөнхий санаа, бүгд хамт хийж болох ажлын талаар ярилцаж, төлөвлөсөн ажлуудыг хэрхэн уялдаатай хэрэгжүүлж болох, хэрхэн ХЭСХ болон тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлж болох талаар зөвлөж, санаа сэдэл өгч, тодорхой шийдвэр, тохиролцоонд хүрэхэд нь туслахыг зорино;
- Оролцогчдод цаашид олон оролцогч талуудтай хэрхэн холбоотой хамтран ажиллах, харилцаа холбоо, түншлэлээ хөгжүүлэх, түүнийг төлөвлөлтөндөө тусгахыг санал болгоно.
- Орон нутгийн эрх баригчид, шийдвэр гаргагчид нь энэхүү 2 матрицаар гарын үсэг зурж буй шийдвэр, бодлого хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвөө хянаж үзэж дүгнэж байхыг зөвлөөрэй.

Чиглүүлэгч дүгнэлт хийх:

Төгсгөлд нь нийт оролцогчдод ХЭСХ болон тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн стратеги төлөвлөгөөтэй болсонд нь, удирдлагын багаар бодит үйл ажиллагаа хэрэгжүүлэх чин эрмэлзэлтэй, тодорхой зорилготой байгаад нь баяр хүргэж, амжилт хүснэ.

АРВАН НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

Үнэлгээ, сургалтын хаалт

40 (минут)



Зорилго:

- Сургалтын үр дүнг үнэлж, цаашид сургалтын агуулгыг баяжуулахад тус болох мэдээлэл авах;
- Оролцогчдын хүсэл эрмэлзлийг бататгаж, сургалтын мөрөөр хийх үйл ажиллагаанд сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх.



Бэлтгэл:

- Хүний тоогоор хувилсан үнэлгээний хуудаснууд, эхний өдөр хүлээлтээ тэмдэглэсэн самбарын цаас бэлдэх;
- Тухайн орон нутгийн болон байгууллага, хамт олны удирдлагаас, өөрөөр хэлбэл нээлтэд оролцогчдыг урьж ирүүлж оролцуулах;
- Хавсралт 17-ын сургалтын үнэлгээний хуудсыг оролцогчдын тоогоор тараах.



2.11.1 Үнэлгээний хуудас бөглөх (10 минут)

- Оролцогчдод “Үнэлгээ” нь аливаа сургалт, суралцах үйл явцын чухал хэсэг. Энэ нь биднийг хариуцлагажуулахаас гадна цаашид дараа дараагийн сургалтын агуулга, арга зүйгээ сайжруулж, хөгжүүлэх чухал ач холбогдолтойг тайлбарлаад үнэлгээний хуудсаа бөглөөд эргүүлж өгөхийг хүснэ;
- Үнэлгээний хуудсан дээр нэрээ тавих албагүй, аль болох ажил хэрэгч, шударгаар үнэлэхийг сануулна.

2.11.2 Дүгнэлт/Ярилцлага (20 минут)

- Оролцогчдыг үнэлгээний хуудсаа бөглөж дуусах үед бүх оролцогчдыг эхний өдрийн “хүлээлт” гэсэн тэмдэглэсэн хуудсыг харахыг хэлнэ;
- Тэгээд “хүлээлт” тус бүрээ товч хэлэлцэж, биелсэн эсэх, тийм бол хэр сайн, үгүй бол яагаад гэдгийг товч хэлэлцэнэ. Ингэхдээ хүн бүрээс сургалтын үр дүн, үйл явц, аргачлал, мэдэж/сурч авсан хамгийн чухал зүйл, сургалтын үеэр төрсөн ямар нэгэн санаа, сургалтын дараа хийе гэж бодож байгаа ямар нэгэн зүйл зэргээсээ чөлөөтэй хуваалцахыг хүснэ.
- Ингэхдээ хүн бүр санал бодлоо нэмэрлэхийг хүсч байгаа тул хүмүүс аль болох товчхон ярьж, бусдадаа боломж олгох хэрэгтэйг сануулаарай;
- Чиглүүлэгчид ч өөрсдийн санал бодлоо товч хуваалцаад дүгнэлт ярилцлагаар энэ хэсгийг төгсгөнө.

2.11.3 Сургалтын хаалт (10 минут)


- Чиглүүлэгчид оролцогчдын санал дүгнэлтийг анхааралтай сонсож, тэмдэглэл хийж авах хэрэгтэй. Энэ нь оролцогчдыг хүндэтгэж байгаагийн илрэл бөгөөд дараа уншиж сэргээхэд ихээхэн мэдээлэл агуулсан тэмдэглэл болдог;
- Оролцогчдын саналд зарим нэг тодруулга хийх шаардлага гарсан бол нэмж болно, мөн сургалтыг зохион байгуулсан чиглүүлэгчдийн багийн ахлагч сургалтыг ерөнхийд нь дүгнэж, оролцогчдыг ихээхэн ачаалалтай ажилласан, их зүйл хийснийг цохон тэмдэглэж урамшуулан, цаашид сургалтаар гаргасан төлөвлөгөөг ажил хэрэг болгох, ХЭСХ-ыг өдөр тутмын ажил, амьдралдаа хэрэгжүүлэхийг хүсч амжилт хүснэ;
- Орон нутгаас нээлтэд оролцсон хүмүүсийн төлөөллийг үг хэлж хаахыг урина;
- Хаалтын дараа оролцогчдыг дурсамжийн зураг авахуулахыг урина.



БҮЛЭГ

III

СУРГАЛТЫН МАТЕРИАЛ, ХЭРЭГЛЭГДЭХҮҮН



НЭГДҮГЭЭР ХЭСГИЙН СУРГАЛТЫН МАТЕРИАЛЫН БҮРЭЛДЭХҮҮН

Хавсралт 1

3.1.1 Сургалтын бүтэц, агуулга

Хэсэг/ сэдэв	Хэлбэр	Зорилго
Нэгдүгээр хэсэг. Нээлтийн арга хэмжээ	Сургалтын нээлт; Оролцогчид танилцуулах; Сургалтын бүтэц, агуулгын танилцуулах; Сургалтаас хүлээж байгаа үр дүнгийн зураглал хийх; Оролцогчид хамтын дүрмээ боловсруулах.	Хоорондоо танилцаж, сургалтын дотно таатай, итгэлцэл бүхий орчин, уур амьсгалыг бүрдүүлэх; Сургалтын зорилго, үйл явц, зохион байгуулалт, хүсч буй үр дүнгийн талаар нэгдсэн ойлголттой болох.
Хоёрдугаар хэсэг. Хүний эрх, эрхэд суурилсан хандлагын тухай одоогийн ойлголт	Дасгал ажил, хэлэлцүүлэг; Бүлгийн ажил; Хэлэлцүүлэг, дүгнэлт.	Хүний эрхийн тухай эргэцүүлж эхлэх; Оролцогчдын хүний эрх буюу эрхэд суурилсан хандлагын тухай одоогийн ойлголтыг тодорхойлох; Хожим энэ ойлголтоо эргэн харж, дахин тодорхойлох суурийг тавих.
Гуравдугаар хэсэг. Нийгмийн бүтцийн Зураглал	Дасгал ажил: “Эрх мэдлийн алхалт” дүрд тоглох; Бүлгийн ажил; Хэлэлцүүлэг, дүгнэлт.	Нийгэм, иргэд гэдэг нь нэгэн цул биш, өөр өөр эрх ашиг, үзэл бодол, байр суурь, зорилго, боломжтой, эрх мэдэл тэнцвэргүй, ялгаатай нөхцөлд оршиж буй олон бүлгээс бүрдэж буйг гүнзгий ойлгох; Энэ ялгаатай байдлыг эрх мэдэл, эд баялаг, боломжийн тэгш бус хуваарилалт, нийгмийн давхраажилт, улс төр, нийгэм, эдийн засаг, соёлын тогтолцоонуудтай холбон шинжлэх; Улмаар хэн ямар учраас нийгэмд эрхээ эдэлж, дуу хоолойгоо гаргаж, эрх ашгаа хамгаалж, өөрийгөө үр дүнтэй төлөөлж болон төлөөлүүлж, ардчилсан эрхээ бүрэн эдэлж чадахгүй байгааг хэлэлцэх; Хүний эрх, тэгш эрх, ардчилсан нийгмийн суурь зарчмуудтай нийцүүлэн иргэдэд хэрхэн үйлчилж ажиллах талаар эргэцүүлэн бодож, эдгээр ойлголт, зарчмуудад суурилан өөрийн хандлага, үзэл баримтлалыг эргэцүүлэх.
Дөрөвдүгээр хэсэг. Хүний эрх, Хүний эрхийн зарчмууд онолын мэдлэг олгох	РР танилцуулга; Хэлэлцүүлэг;	Хүний эрхийн үндэс; Хүний эрхийн төрлүүд: Иргэний эрх, Улс төрийн эрх, Эдийн засгийн эрх, Нийгмийн эрх, Соёлын эрх; Хүний эрхийн зарчмууд; Ардчиллын үнэт зүйлс, хүний эрхийн зарчмууд; ХЭТТ болон ҮХ-иар баталгаажсан эрхүүд тус бүрийг зорилтот бүлэг, төслийн чиглэсэн асуудалтай холбож тайлбарлан таниулах, суурь мэдлэг ойлголтыг нь цэгцлэх



Тавдугаар хэсэг. Асуудалд дүн шинжилгээ хийх	Дасгал, ярилцлага; Бүлгийн ажил; Хэлэлцүүлэг, дүгнэлт	Орон нутгийн тулгамдсан асуудлыг оролцогчдоос асууж санаа “оюуны дайралт” аргаар илрүүлэх; Тухайн асуудлуудыг оролцогчдоор өөрсдөөр нь эрэмбэлүүлэн түүнээс 2-3 нэн тулгамдсан асуудлыг сонгон авч дүн шинжилгээ хийлгэх; Асуудлын суурь шалтгаан, үр дагавар, нөлөөлж буй хүчин чадлыг ялгаж харах үр чадвар, дадал олгох.
Зургаадугаар хэсэг. Хүний эрхэд суурилсан хандлага	РР танилцуулга; Хэлэлцүүлэг	Хүний эрхэд суурилсан хандлага, Төр эрх агуулагчдын өмнө үүрэг хүлээгч болох онолын мэдлэг авах; Урьд хийсэн дасгал ажил дээр хийсэн дүн шинжилгээнд тулгуурлан ойлголтын зөрүүг зааглан ойлголт авах.
Долоодугаар хэсэг. Тодорхой шийдвэрлэх тулгамдсан асуудлуудад дүн шинжилгээ хийх	Дасгал ажил; Бүлгийн ажил; Хэлэлцүүлэг, дүгнэлт	Сэдэв 5 дахь бүлгийн ажлаар оролцогчдоор эрэмбэлсэн асуудлуудыг зохицуулж буй бодлогын баримт бичгүүдтэй танилцах, түүнд дүн шинжилгээ хийх; Сонгогдсон асуудлуудын суурь шалтгаан, үр дагавар, нөлөөлөх хүчин зүйлс дээр тогтож ажиллан суурь шалтгааныг арилгахад чиглэсэн арга хэмжээ бодлогын баримт бичигт туссан эсэх, эсвэл үр дагавар, хүчин зүйлсийг арилгахад чиглэж үү гэдэгт ХЭСХ-аар дүн шинжилгээ хийж үр чадвар, мэдлэгээ бататгах.
Наймдугаар хэсэг. Тогтвортой хөгжил ба хүний эрх онолын мэдлэг олгох	РР танилцуулга; Хэлэлцүүлэг, дүгнэлт	Хөгжил гэж юу болох, байгалийн нөөцийг ашиглахдаа хэрхэн тогтвортой хөгжлийг бий болгох талаар гүнзгий онолын мэдлэг олж авна; Тогтвортой хөгжил нь хүний эрхийг дэмжих, хүний хөгжлийг дэмжих хамаарлыг гүн ойлгоно.
Аравдугаар хэсэг. Сургалтын явцын үнэлгээ хийх	Хэлэлцүүлэг Дүгнэлт	Сургалтад оролцогчдоор сургалтын явцыг үнэлүүлэх; Чиглүүлэгчид оролцогчдын санаа бодол, дүгнэлтэд үндэслэн ахиц, өөрчлөлтөө хэмжиж үнэлэх, зарим нэг тодруулга тайлбар хийх.
Арван нэг дүгээр хэсэг. Стратеги төлөвлөгөө боловсруулах	Бүлгийн ажил; Хэлэлцүүлэг, дүгнэлт	Өмнөх хэсгүүдэд олж авсан мэдлэг, үр чадвараа болон өөрийн туршлага, бүтээлч сэтгэлгээг дайчлан, сургалтын дараагаас бодитоор хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах; Төлөвлөгөөг “ХЭСХ болон тогтвортой хөгжлийн үзэл баримтлал” матрицаар үнэлэн сайжруулах.
Арван хоёрдугаар хэсэг. Хаалт: Үнэлгээ- дүгнэлт	Үнэлгээний хуудас бөглөх; Дүгнэлт ярилцлага	Сургалтын үр дүнг дүгнэх; Сургалтын мөрөөр үр дүнтэй үйлдэл хийх урам зориг итгэл үнэмшил төрүүлэх; Зураг авхуулах.



3.2.1 Хүний эрх түүний одоогийн ойлголтоо сэргээх дасгал ажил

Хувилбар - А:

- Хананд доорх таван эрхийн төрөл тус бүрийг бичсэн 5 самбарын цаас байрлуулсан байна;
- Оролцогчид өөр өөрсдийн мэддэг эрхийг тарааж өгсөн өнгө өнгийн картад бичээд таван төрөл тус бүрийн хамаарах хэсэгт нааж байрлуулна.

Улс төрийн эрх:	Иргэний эрх:	Эдийн засгийн эрх:	Нийгмийн эрх:	Соёлын эрх:

Хувилбар - Б:

- Хананд доорх таван эрх тус бүрийг бичсэн 5 самбарын цаас байруулсан байна;
- Доорх эрхүүдийг өнгө өнгийн картад бичиж бэлтгэн, жижиг наалтаар наахаар бэлтгэсэн байна. Оролцогчдод 3-4 картыг сугалаагаар оноож өгнө. Оролцогчид өөрт оногдсон карт бүхий эрхийг дээрх таван эрх тус бүрт хамаарлаар нь ангилж байрлуулахыг хэлнэ.

Өв залгамжлах эрх
Хөдөлмөрлөх эрх
Хохирол нөхөн төлүүлэх эрх
Өлсгөлөнгөөс ангид байх
Үр удмаа үлдээх
Өмчлөх эрх
Нийгмийн хангамж эдлэх
Түр буюу байнга оршин суух газраа сонгох
Хууль зүйн туслалцаа авах эрх
Эрүүл мэндээ хамгаалуулах эрх



Хавсралт 3

3.2.2 Хүний эрхийн төрлүүд (ХЭТТ болон Үндсэн хуулийн хэмжээнд)

ХЭТТ–д заагдсан 30 зүйл эрх, Үндсэн хуулиар заасан 16- зүйл эрхүүдэд үндэслэн төрөлжүүлээ.

Иргэний эрх:	Улс төрийн эрх:	Эдийн засгийн эрх:	Нийгмийн эрх:	Соёлын эрх:
Амьд явах, эрх чөлөөтэй байх, эрүүл аюулгүй орчинд амьдрах, байгаль орчны тэнцэл алдагдахаас хамгаалуулах, боолчлолоос ангид байх, нэр төрөө хамгаалуулах, эрхзүйн чадвартай байх, эрүү шүүлтээс ангид байх, хүн бүр хуулийн өмнө адил тэгш байх, зөрчигдсөн эрхээ бүрэн сэргээх, халдашгүй байх эрх, шударга шүүхээр шүүлгэх эрх, өөрөөр өөрийгөө өмгөөлөх өмгөөлүүлэх, иргэний харъяалалтай байх, шашин шүтэх эс шүтэх, сайн дүрын үндсэн дээр гэрлэх,эрх тусгаарлах, үр удмаа үлдээх, өлсгөлөнгөөс ангид байх, усаар хангагдах г.м эрхүүдийг багтаан ойлгоно.	Төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх, Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байх, төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрх, мөрдөлт мөшгөлтөөс зугатаж өөр орноос орогнол хүсэх, үзэл бодлоо илэрхийлэх, итгэл үнэмшилтэй байх, сонгох сонгогдох, эвлэлдэн нэгдэх, жагсаал цуглаан хийх, гомдол гаргах г.м эрхүүдийг багтаан ойлгоно.	Ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, Эд хөрөнгө дангаар буюу бусадтай өмчлөх, хувийн аж ахуй эрхлэх, хөдөлмөрлөх, ажилгүйдлээс хамгаалуулах, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, адил хэмжээний хөдөлмөрд адил хэмжээний хөлс авах, хувийн болох ам бүлнийхээ ахуй амжиргааг хүний зэрэгтэй авч явахад хүрэлцэхүйц, хийсэндээ таарсан, хүрэлцэхүйц шан хөлс авах, эрх ашгаа хмагаалах үйлдвэрчний эвлэл байгуулах түүнд нэгдэх, ажил хаях, өмчлөх, өв залгамжлах залгамжлуулах г.м эрхүүдийг багтаан ойлгоно.	Улсынхаа дотор чөлөөтэй зорчих, нийгмийн хангамж эдлэх, эд мөнгөний туслалцаа авах, нэр төрөө хадгалах, хөгжих, эрүүл мэндээ хамгаалуулах, аялах, эрүүл мэндийн үйлчилгээ авах, ажлын цагаа зохистойгоор хязгаарлуулж амрах, цалинтай ээлжийн амралт эдлэх эрхийг оролцуулан амрах зав чөлөөтэй байх г.м эрхүүдийг багтаан ойлгоно.	Хүн бүр нийгмийнхээ соёлын амьдралд чөлөөтэй оролцох, урлагийн цэнгэлийг эдлэх, шинжлэх ухааны дэвшилд оролцож үр шимийг нь хүртэх, өөрийн туурвисан шинжлэх ухаан, утга зохиол, уран сайхны бүтээлийн материаллаг болон ёс суртахууны эрх ашгаа хамгаалуулах, хэвлэн нийтлэх, уламжлалт соёлоо өвлөх, хадгалах, хөгжүүлэх, хамгаалуулах г.м эрхүүдийг багтаан ойлгоно.



3.3.1 Нийгмийн бүтцийн зураглал “Эрх мэдлийн алхалт” тоглоомын дүрүүд

(Дүр тус бүрийг хэсэгчлэн хайчилж тараана)

1. Та 25 настай эмэгтэй, биеэ үнэлэгч. 15 настайдаа хойд эцэгтээ хүчиндүүлсний дараа гэрээсээ дайжиж энэ замд орсон.
2. Та 4 жилийн өмнө осолд орсон, түүнээс хойш тэргэнцэртэй. Та дундаж давхаргын 20 настай эрэгтэй.
3. Та 35 настай эмэгтэй, 4 өнчин дүүгээ тэжээдэг. Гадаадын хөрөнгө оруулалттай томоохон корпорацид хариуцлагатай албан тушаалтай.
4. Та эрэгтэй хоригдол, 40 настай. Эгчийгээ нөхрөөс нь хамгаалж зодоод хүнд гэмтэл учруулсан хэргээр ял эдэлж байгаа.
5. Та 35 настай, 100 толгой малтай малчин эмэгтэй. 10-р ангиа онц төгссөн ч аав ээж мал маллах хүн хүч дутмаг тул малчин болсон. Нийслэл болон аймагт ангийн хүүхдүүд том албан тушаалтай.
6. Та 40 настай дундаж орлоготой эмэгтэй. Та өнгөрсөн жил сумынхаа ИТХ-ын гишүүнээр сонгогдсон.
7. Та 50 настай дундаж орлоготой эрэгтэй. Та өнгөрсөн жил сумынхаа ЗД-ын орлогчоор сонгогдсон.
8. Та 35 настай үндэсний цөөнхийн эрэгтэй. Үндэсний олонх давамгайлсан суманд бичил уурхай эрхэлдэг.
9. Та 30 настай эрэгтэй малчин, ган болж бэлчээр муудсан тул зуны цагт уурхай руу нүүж нинжаддаг.
10. Та 20 настай, өсвөр наснаасаа хойш “манин” гэж дуудуулж ирсэн. Гэр бүлийнхэн хүртэл тантай ширүүн, ууртай харьцдаг.
11. Та 40 настай ядуу эмэгтэй, сумын төвд амьдардаг. Томоохон БУЭ-дэд тусалж, чулуу зөөж амьдардаг. Нөхөртэй, 2 хүүхэдтэй. Нөхөр тань хүнд өвчтэй.
12. Та 60 настай эрэгтэй, уул уурхайн улмаас бэлчээрээ алдаж, малгүй болсон тул том хот руу нүүсэн, гудамжинд амьдардаг.
13. Та 35 настай баян эрэгтэй, хотод амжилттай бизнестэй, улс төрийн холбоо сүлжээ, танил тал сайтай.
14. Та 30 настай баян эмэгтэй, гэрийн эзэгтэй, өөр ажил эрхэлдэггүй. Таны нөхөр амжилттай бизнестэй.
15. Та 50 настай малчин эмэгтэй, зудаар бүх малаа алдсан. ЕБС-д нэг, дээд сургуульд нэг хүүхэд суралцдаг.



16. Та 45 настай УИХ-ын гишүүн эрэгтэй, баян бизнес эрхлэгчид таныг дэмждэг.
17. Та 50 настай эрэгтэй, эмч, хувийн эмнэлэгтэй, орлого сайтай, жижиг хотод эхнэр, хүү, бэрийн хамт амьдардаг.
18. Та 20 настай хөдөөний эмэгтэй оюутан. Улаанбаатарт сурдаг, хамаатныдаа амьдардаг. Тэдний ам бүл 8- уулаа.
19. Та хөдөөнөөс нүүж ирээд үерийн аман дээр зөвшөөрөлгүй буусан шилжин суурьшигч, 50 настай эмэгтэй, 3 хүүхэдтэй. Бичиг баримтаа хотод бүртгүүлж амжаагүй.
20. Та хотын төвийн байрнуудын гадаах гаражийн хажууд дугуй засвар ажиллуулдаг, тэндээ эхнэр, 3 хүүхэдтэйгээ амьдардаг 40 настай эрэгтэй.
21. Та 65-аас дээш насны тэтгэвэрт гарсан эмэгтэй, охин, хүргэнтэйгээ хамт амьдардаг. 12 сарын тэтгэврийн зээл хийсэн.
22. Та 65-аас дээш насны тэтгэвэрт гарсан эрэгтэй, хүү, бэртэйгээ хамт амьдардаг. Бэр хамтдаа байхад дургүй ханддаг нь анзаарагддаг.
23. Та 50 настай аймгийн төвийн оршин суугч эмэгтэй. Өнгөрсөн жил та аймгийнхаа ИТХ-ын тэргүүлэгч гишүүн болсон.
24. Та 50 настай аймгийн төвийн оршин суугч эрэгтэй. Өнгөрсөн жилээс алтны ченж хийдэг болсон.
25. Та саяхан төрийн албанд шалгалт өгөөд орсон 28 настай ганц бие эмэгтэй.
26. Та бичил уурхай эрхлэгч 40 настай эмэгтэй. Нөхөрлөлийн ахлагч. Сүүлийн 3 сар ямар ч олз олоогүй.
27. Та гэр бүлээсээ дайжиж гудамжинд амьдардаг 12 настай эрэгтэй. Сургууль завсардсан, зах дээр тэрэг түрдэг.
28. Та ЕБС-д үйлчлэгч, эмэгтэй. Нөхөр нас барсан, одоо насанд хүрээгүй 4 хүүхдийн хамт амьдардаг.
29. Та аймгийн Нийгмийн халамжийн үйлчилгээний хэлтэст томоохон албан тушаал дээр олон жил ажилласан, эрэгтэй. Эхнэр охины хамт амьдардаг.
30. Та сумын төвд жижиг дэлгүүр ажиллуулдаг. Хилийн худалдаанд цүнх үүргэвчээр бараагаа зөөдөг, ганц бие 48 настай эмэгтэй.



3.3.1 “Эрх мэдлийн алхалт” дасгал ажлын асуултууд

Бөглөх заавар: “тийм” гэвэл **1**, “үгүй” гэвэл **0**, “эргэлзэж” байвал Х тэмдэг тавиарай.

№	Асуулт	Тийм /Үгүй/ Эргэлзээ
1	Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдэлж чадах уу, улс төрийн үзэл бодлоо илэрхийлсэн нийтлэл бичиж хэвлүүлэх боломжтой юу?	
2	Ойрын үед хүчирхийлэл, тамлан зовоох явдлаас ангид байж чадах уу?	
3	Та эсвэл таны хүүхдүүд дээд боловсрол эзэмших боломжтой юу?	
4	Та эх орны байгалийн баялагаас шударгаар хувь хүртэж чадаж байна уу?	
5	Хамт олон, орон нутгийн асуудлыг ярилцаж байхад таны үг нөлөөтэй байж чаддаг уу?	
6	Танай сарын орлого хүнсээ хангалттай худалдан авахад хүрэлцэх үү?	
7	Яаралтай, зайлшгүй хэрэгцээтэй гэхдээ үнэтэй хагалгаа хийлгэж чадах уу?	
8	Шинэ кино эсвэл дуурийн болон драмын жүжиг үзэх боломжтой юу?	
9	Харанхуй болсон хойно ганцаараа гадуур явах боломжтой юу? Гэрийнхэн зөвшөөрөх үү?	
10	Амьдарч буй орчиндоо эсвэл ажлын байр, сургууль дээрээ бэлгийн халдлага, дарамтаас ангид байж чадах уу?	
11	Эргэн тойрныхон таны эрхийг зөрчвөл шүүхэд хандаж чадах уу?	
12	Хэн нэгэн эрх мэдэлтэнд ямар нэгэн айдасгүйгээр саналаа хэлж шийдвэрлүүлж чадах уу?	
13	Амьдарч буй орчиндоо эсвэл ажлын байр, сургууль дээрээ бие махбодийн хүчирхийллээс ангид байж чадах уу?	
14	Ундны аюулгүй ус хэрэглэж чаддаг уу?	
15	Эмнэлэг дээр эмчлүүлэх гээд очиход танд хүндэтгэлтэй хандах уу?	
16	Та эрүүл агаараар амьсгалж байгаадаа итгэлтэй байна уу?	
17	Ажиллаж, амьдарч байгаа газраасаа дайжих шаардлага гарахгүй, хөөгдөж шахагдахгүй гэдэгт итгэлтэй байж чадах уу?	
18	Секс хийхдээ бэлгэвч хэрэглэх эсэх талаар хамтрагчтайгаа зөвшилцөж чадах уу?	
19	Монголын цагаан сарын баяраа зээлгүйгээр сэтгэл хангалуун тэмдэглэж чадах уу?	
20	Банкнаас хангалттай хэмжээний зээл авах боломжтой юу?	

Сургагч нь: Оролцогчдыг оноогоо тооцохыг сануулах

ТИЙМ гэсэн хариултын нийт тоо:	
ҮГҮЙ гэсэн хариултын нийт тоо:	
ЭРГЭЛЗСЭН хариултын нийт тоо:	



3.3.2 Хүний эрхийн түгээмэл тунхаглал. “Нийгмийн бүтцийн ялгаатай байдал” сэдвийн бүлгийн ажлын хэрэглэгдэхүүн

Хавсралт 5

ХҮНИЙ ЭРХИЙН ТҮГЭЭМЭЛ ТУНХАГЛАЛ

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 217/A/III/ тогтоолоор 1946 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталж, түүний бүх заалтыг дагаж мөрдөхийг гишүүн улсуудад уриалжээ.

УДИРТГАЛ

Хүн төрөлхтний ам бүлийн гишүүн бүхэнд угаас заяасан нэр төр болон тэдний адил тэгш, салшгүй эрхийг хүлээн зөвшөөрөх нь эрх чөлөө, шударга ёс, бүх нийтийн энх тайвны үндэс мөнийг иш үндэс болгон;

хүний эрхийг үл тоомсорлох, басамжлах нь зон олны ариун сэтгэлийг сэвтээн жигшээсэн балмад үйлдэлд хүргэж байсан бөгөөд хүмүүс үгээ хэлэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөтэй түүнчлэн айх аюулгүй, гачигдах зовлонгүй дэлхий ертөнцийг бий болгох нь хүн ардын эрхэм дээд эрмэлзэл мөн хэмээн үзэж;

хүмүүс эзэрхэг засаглал, дарлалын эсрэг өөрийн эрхгүй эцсийн арга болгон зэвсэглэн босоход хүргэхгүйн тулд хүний эрхийг хуулиар хамгаалах нь нэн чухал гэдгийг анхааран;

улс түмний хооронд найрсаг харилцаа хөгжүүлэхэд тус дөхөм үзүүлэх нь нэн чухлыг харгалзан;

хүн үндсэн эрхтэй, хувь хүн нэр төр, үнэ цэнэтэй, эрэгтэй, эмэгтэйчүүд тэгш эрхтэй гэдэгт

Нэгдсэн Үндэстний улс түмэн итгэл төгс байгаагаа дүрмээрээ нотлохын хамт, илүү эрх чөлөөтэй байдалд нийгмийн дэвшлийг урагшлуулах, амьдралын нөхцлийг сайжруулахад дөхөм үзүүлэхээр шийдвэрлэснийг харгалзан;

гишүүн улсууд Нэгдсэн Үндэстний Байгууллагатай хамтран хүний эрх, үндсэн эрх чөлөөг нийтээр хүндлэн сахихад тус дөхөм үзүүлэх үүрэг авсныг үндэслэн;

энэхүү үүргийг бүрэн биелүүлэхэд хүний эрх, эрх чөлөөг нийтээр нэг мөр ойлгох явдал нэн чухал ач холбогдолтойг харгалзан; тийнхүү, үүний учир,

Ерөнхий Ассамблей

Энэхүү хүний эрхийн түгээмэл тунхаглалыг дэлхийн бүх улс түмэн, бүх улс гүрэн хэрэгжүүлэхийг эрмэлзвэл зохих нийтлэг зорилт болгон дэвшүүлж, энэ зорилтын үүднээс хүн бүр, нийгмийн нэгж байгууллага бүхэн эл Тунхаглалыг байнга бодолцон гэгээрч боловсрох замаар хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн сахихад дөхөм үзүүлэхийг эрмэлзэх ёстойг, түүнчлэн үндэсний болон олон улсын хэмжээний дэвшилтэт арга хэмжээ авах замаар эдгээр эрх, эрх чөлөөг Нэгдсэн Үндэстний гишүүн улсын ард түмэн, тэдгээр улсын эрх мэдлийн нутаг дэвсгэр дээр оршин суудаг ард түмний аль алианаар нь бүх нийтээр үр нөлөөтэй хүлээн зөвшөөрүүлж, дагаж мөрдөх явдлыг хангахад тус дөхөм үзүүлэхийг эрмэлзэх ёстойг зарлан тунхаглаж байна.

1 дүгээр зүйл: Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байна. Тэдэнд оюун ухаан, өрлөг сэтгэл заяасан бөгөөд өөр хоорондоо ахан дүүгийн ёсоор харилцах ёстой.

2 дугаар зүйл: Хүн бүр энэ Тунхаглалд заасан бүхий л эрх, эрх чөлөөг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгө, язгуур угсаа болон бусад байдлын ялгааг эс харгалзан ямар ч гадуурхалгүйгээр эдлэх ёстой. Мөн түүнчлэн тухайн хүнийг харъяалдаг улс буюу нутаг дэвсгэрийн улс төр, эрх зүй болон олон улсын статус ямар ч байлаа гэсэн, тухайлбал, тусгаар тогтносон буюу асрамжинд байгаа, өөрөө эс удирдах зэрэг бүрэн эрхт байдал нь ямар ч байдлаар хязгаарлагдмал байсан тэр нь ялгаварлах үндэс болох ёсгүй.

3 дугаар зүйл: Хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрхтэй.

4 дүгээр зүйл: Хэнийг ч боолчлох буюу бусдын эрхшээлд байлгах ёсгүй. Аливаа төрлийн боолчлол болон боолын худалдааг хориглоно.

5 дугаар зүйл: Хэнд ч эрүү шүүлт тулган эсхүл хэнтэй ч хэрцгийгээр, хүний ёсноос гадуур буюу нэр төрийг нь доромжлон харьцах, шийтгэх ёсгүй.

6 дугаар зүйл: Хүн бүр хаана ч байсан эрх зүйн чадвартай байх эрхээ хүлээн зөвшөөрүүлэх эрхтэй.

7 дугаар зүйл: Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч алагчилалгүйгээр хуулиар адилхан хамгаалуулах. Хүн бүр энэхүү Тунхаглалд харшлах аливаа алагчилалаас болон тийнхүү алагчилахыг өдөөсөн турхиралтаас адилхан хамгаалуулах эрхтэй.

8 дугаар зүйл: Үндсэн хууль болон бусад хуулиар олгосон үндсэн эрх нь зөрчигдвөл хүн бүр эрх мэдэл бүхий үндэсний шүүхээр эрхээ бүрэн сэргээн тогтоолгох эрхтэй.



9 дүгээр зүйл: Хэнийг ч дур мэдэн баривчлах, саатуулах буюу хөөн зайлуулах ёсгүй.

10 дугаар зүйл: Хүн бүр тулгасан аливаа эрүүгийн ял болон эрх үүргээ тодорхойлуулахдаа хараат бус, тал хардаггүй шүүхээр бүрэн адил тэгш үндсэн дээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй.

11 дүгээр зүйл:

1. Гэмт хэрэгт буруутгагдаж буй хэн боловч өмгөөлөх бүх боломжоор хангагдсан нээлттэй шүүх хурлаар гэм буруутайг нь хуулийн дагуу тогтоох хүртэл гэм буруугүй гэж тооцогдох эрхтэй.
2. Тухайн үед үндэсний буюу олон улсын хуулийн дагуу гэмт хэрэгт эс тооцож байсан аливаа үйлдэл буюу эс үйлдлийг үндэслэж, хэнийг ч гэмт хэрэгт яллан шийтгэх ёсгүй. Түүнчлэн гэмт хэрэг гарсан тэр үед ногдуулж болох байснаас илүү хүнд ял тохоож болохгүй.

12 дугаар зүйл: Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн оролцох, орон байрны халдашгүй байдал, захидал харилцааных нь нууц болон нэр төр, алдар хүндэд нь халдах ёсгүй. Тийм оролцоо халдлагын эсрэг хэн ч бай хуулиар хамгаалуулах эрхтэй.

13 дугаар зүйл:

1. Хэн боловч улсынхаа дотор чөлөөтэй зорчих, оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхтэй.
2. Хэн боловч аливаа улс орныг, түүний дотроо эх орноо орхин явах, эх орондоо эргэж очих эрхтэй.

14 дүгээр зүйл:

1. Хэн боловч мөрдөлт мөшгөлтөөс зугтаж, өөр улсад орогнох боломжийг эрэлхийлэх болон орогнох эрхтэй.
2. Улс төрийн бус гэмт хэргийн улмаас буюу Нэгдсэн Үндэстний Байгууллагын зорилго, зарчимд харш хэрэг үйлдсэний улмаас зайлшгүй мөрдөгдөж буй тохиолдолд дээрх эрхийг эдлэж үл болно.

15 дугаар зүйл:

1. Хүн бүр иргэний харьяалалтай байх эрхтэй.
2. Аливаа хүний иргэний харьяалал болон харьяаллаа өөрчлөх эрхийг дур мэдэн цуцлах ёсгүй.

16 дугаар зүйл:

1. Насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хүмүүс арьс үндэс, яс үндэс, шашин шүтлэгтэй холбогдсон аливаа хязгаарлалтгүйгээр гэрлэх, өрх тусгаарлах эрхтэй. Тэд гэрлэхдээ, гэрлэсний дараа болон гэрлэлтээ цуцлуулах үед тэгш эрх эдлэнэ.
2. Нөхөр, эхнэр болох хоёр хүн чөлөөтэй, харилцан бүрэн зөвшөөрсөн нөхцөлд гэрлэж болно.
3. Гэр бүл бол нийгмийн жам ёсны үндсэн нэгж мөн бөгөөд нийгэм, төрөөр хамгаалуулах эрхтэй.

17 дугаар зүйл:

1. Хүн бүр эд хөрөнгийг ганцаараа буюу бусадтай хамтарч өмчлөх эрхтэй.
2. Хэний ч өмч хөрөнгийг дураар хураан авч болохгүй.

18 дугаар зүйл: Хүн бүр чөлөөтэй бодож сэтгэх, шашин шүтэх, эс шүтэх эрхтэй. Энэхүү эрхэнд шашин буюу шүтлэгээ өөрчлөх эрх чөлөө, бие даан буюу бусадтай хамтран нийтийн өмнө болон хувийн журмаар хичээл заах, хурал мөргөл хийх, шашны хийгээд зан үйлийн ёслол үйлдэх зэргээр шашин буюу шүтлэгээ номлох эрх чөлөө багтана.

19 дүгээр зүйл: Хүн бүр өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэхүү эрхэнд үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрх чөлөө, үзэл санаа, мэдээллийг улсын хилийн заагаар үл хязгаарлан аливаа арга замаар эрж сурвалжлах, хүлээж авах, түгээн дэлгэрүүлэх эрх чөлөө багтана.

20 дугаар зүйл:

1. Хүн бүр чөлөөтэй, тайван хуран цуглах, эвлэлдэн нэгдэх эрхтэй.
2. Хэнийг ч аливаа эвлэл холбоонд албадан оруулах ёсгүй.

21 дүгээр зүйл:

1. Хүн бүр улсаа удирдахад шууд буюу чөлөөтэй сонгосон төлөөлөгчдөөрөө уламжлан оролцох эрхтэй.
2. Хүн бүр улсдаа төрийн алба хаших тэгш эрхтэй.
3. Ард түмний хүсэл зориг бол засгийн эрх мэдлийн үндэс байх ёстой. Энэ хүсэл зориг нь сонгуулийн бүх нийтийн тэгш эрхийн үндсэн дээр саналыг нууцаар хураах буюу саналаа чөлөөтэй гаргах явдлыг хангахуйц өөр адил чанартай хэлбэрийг ашиглах замаар явуулж байвал зохих тогтмол, хуурамч бус сонгуулиар илрэлээ олно.

22 дугаар зүйл: Хүн бүр нийгмийн гишүүний хувьд нийгмийн хангамж эдлэх, түүнчлэн нэр төрөө хадгалах, биеэ боловсруулж хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай эдийн засаг, нийгэм, соёлын эрхээ улс бүрийн бүтэц, нөөц



бололцоотой уялдуулан үндэсний хүч чармайлт хийгээд олон улсын хамтын ажиллагааны замаар хэрэгжүүлэх эрхтэй.

23 дугаар зүйл:

1. Хүн бүр хөдөлмөрлөх, ажлаа чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн шударга, аятай нөхцлөөр хангуулах, ажилгүйдлээс хамгаалуулах эрхтэй.
2. Хүн бүр ямар ч алагчилалгүйгээр адил хэмжээний хөдөлмөрт адил хэмжээний шан хөлс авах эрхтэй.
3. Ажил хөдөлмөр эрхэлж байгаа хэн боловч хувийн болон ам бүлийнхээ ахуй амьжиргааг хүний зэрэгтэй авч явахад хүрэлцэхүйц бөгөөд зайлшгүй тохиолдолд нийгмийн хангамжийн эх үүсвэрээр нэмэн арвижуулсан, хийсэндээ таарсан, хүртээмжтэй шан хөлс авах эрхтэй.
4. Хүн бүр эрх ашгаа хамгаалах зорилгоор үйлдвэрчний эвлэл байгуулах буюу үйлдвэрчний эвлэлд нэгдэх эрхтэй.

24 дүгээр зүйл: Хүн бүр ажлын цагаа зохистойгоор хязгаарлуулах, цалинтай ээлжийн амралт эдлэх эрхийг оролцуулан амрах, зав чөлөөтэй байх эрхтэй.

25 дугаар зүйл:

1. Хүн бүр хоол хүнс, хувцас хунар, орон байр, эмчилгээ сувилгаа, нийгэм ахуйн зайлшгүй шаардлагатай үйлчилгээг оролцуулаад өөрийн болон ам бүлийнхээ эрүүл мэнд, аж амьдралыг тэтгэхэд хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрхтэй. Ажилгүйдэх, өвчлөх, тахир дутуу болох, бэлэвсрэх, өтлөх, эсхүл өөрөөс үл хамаарах бусад шалтгаанаар амь зуулгагүй болох нөхцөлд тэтгэмж авах эрхтэй.
2. Эх нялхас онцгой асрамж, туслалцаа авах эрхтэй. Баталгаатай гэр бүлээс гарсан буюу бутач гэдгээс үл хамааран бүх хүүхэд нийгмээс адилхан хамгаалалт эдлэх ёстой.

26 дугаар зүйл:

1. Хүн бүр сурч боловсрох эрхтэй. Наад зах нь анхан шатны болон ерөнхий боловсрол үнэ төлбөргүй байвал зохино. Анхан шатны боловсролыг заавал эзэмшүүлэх ёстой. Техникийн болон тусгай мэргэжлийн боловсрол нийтэд хүртээлтэй байх ёстой. Авъяас чадвартай нь уялдан хүн бүрт дээд боловсрол эзэмших боломж адилхан хүртээлтэй олгох ёстой.
2. Боловсрол нь бие хүнийг өв тэгш хөгжүүлэх, хүний эрх, үндсэн эрх чөлөөг улам бүр хүндэтгэдэг болоход чиглэх ёстой. Боловсрол нь аливаа улс түмэн, янз бүрийн арьстан хийгээд шашны бүлгүүд бие биеэ харилцан ойлгох, хүлцэн тэвчих, эвсэн найрамдах, мөн түүнчлэн Нэгдсэн Үндэстний Байгууллагаас энх тайвныг сахиулах талаар явуулж буй үйл ажиллагаанд дөхөм үзүүлэх ёстой.
3. Хүүхэддээ олгох боловсролын чиглэлийг сонгоход эцэг эх давуу эрх эдлэнэ.

27 дугаар зүйл:

1. Хүн бүр нийгмийнхээ соёлын амьдралд чөлөөтэй оролцох, урлагийн цэнгэлийг эдлэх, шинжлэх ухааны дэвшилд оролцож үр шимийг нь хүртэх эрхтэй.
2. Хүн бүр өөрийн туурвисан шинжлэх ухаан, утга зохиол, уран сайхны бүтээлийн материаллаг болон ёс суртахууны эрх ашгаа хамгаалуулах эрхтэй.

28 дугаар зүйл: Хүн бүр энэхүү Тунхаглалд заасан эрх, эрх чөлөөг бүрэн эдлэж болохуйц нийгмийн болон олон улсын дэг журамд аж төрөх эрхтэй.

29 дүгээр зүйл:

1. Хүн бүр нийгмийнхээ өмнө тодорхой үүрэг хүлээх бөгөөд гагцхүү нийгэм л бие хүний чөлөөтэй, өв тэгш хөгжлийг хангана.
2. Хүн бүр эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ гагцхүү бусдын эрх, эрх чөлөөг зохих ёсоор хүлээн зөвшөөрч хүндлэх, мөн ардчилсан нийгмийн ёс суртахууны шударга шаардлага, нийгмийн хэв журам, ерөнхий сайн сайхан байдлыг хангах үүднээс хуульчлан тогтоосноос өөр хязгаарлалтад өртөгдөх ёсгүй.
3. Эдгээр эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхдээ Нэгдсэн Үндэстний Байгууллагын зорилго, зарчимтай хэрхэвч зөрчилдүүлж болохгүй.

30 дугаар зүйл: Энэхүү Тунхаглалын ямар ч зүйлийг аль нэг улс, бүлэг буюу бие хүний зүгээс энд тунхагласан эрх, эрх чөлөөг устгахад чиглэсэн аливаа үйл ажиллагаа явуулах буюу тийм үйлдэл хийх эрх олгож байгаа мэтээр мушгин тайлбарлаж болохгүй.



3.3.3 Үндсэн хууль. 2-р бүлэг 16-р зүйл. “Нийгмийн бүтцийн ялгаатай байдал” сэдвийн бүлгийн ажлын хэрэглэгдэхүүн

Хавсралт 6

ҮНДСЭН ХУУЛЬ. 2-р бүлэг 16-р зүйл:

Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:

- 1/ амьд явах эрхтэй. Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас бусад тохиолдолд хүний амь нас бусниулахыг хатуу хориглоно;
- 2/ эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй;
- 3/ хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө;
- 4/ ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй;
- 5/ өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй;
- 6/ эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй. Иргэдэд эмнэлгийн төлбөргүй тусламж үзүүлэх болзол, журмыг хуулиар тогтооно;
- 7/ сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно. Иргэд төрөөс тавих шаардлагад нийцсэн хувийн сургууль байгуулан ажиллуулж болно;
- 8/ соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхтэй. Зохиогч, шинэ бүтээл, нээлтийн эрхийг хуулиар хамгаална;
- 9/ шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг арван найман наснаас эдэлнэ. Сонгогдох насыг төрийн зохих байгууллага, албан тушаалд тавих шаардлагыг харгалзан хуулиар тогтооно;
- 10/ нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. Нам, олон нийтийн бусад бүх байгууллага нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ. Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно. Төрийн зарим төрлийн албан хаагчийн намын гишүүнийг түдгэлзүүлж болно;
- 11/ улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална;
- 12/ төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй;
- 13/ халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална;
- 14/ Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар



шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй. Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно. Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно. Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно;

- 15/ шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй;
- 16/ итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно;
- 17/ төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална;
- 18/ улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй. Гадаадад явах, оршин суух эрхийг үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд зөвхөн хуулиар хязгаарлаж болно.



3.4.1 “Хүний эрх түүний төрөл, хүний эрхийн зарчмууд” танилцуулга

Слайд 1 Агуулга:

- Хүний эрх, эрх чөлөө
- Төрөл ангилал
- Зарчим
- Хууль эрх зүйн баталгаа

Слайд 2 Хүний эрх, эрх чөлөө гэж юу вэ?

- Хүний эрх гэдэг: хүмүүс бид, хүн болж төрсний хувьд, төрөлхөөс заяагдсан, ямар нэгэн ялгаатай байдлаас үл хамааран эдэлвэл зохих, эрхэмсэг, хүн шиг байх эрх, эрх чөлөөг хэлдэг.
- Хүний эрх нь хүнийг нэр төртэй, үнэ цэнэтэй ажиллаж амьдрах наад захын стандарт хэм хэмжээ, хүн шиг амьдрах оршихуйн үндэс юм.

Слайд 3 Хүний эрхийн төрлүүд:

- **Иргэний эрх:** Амьд явах, хөгжих, шашин шүтэх, гэрлэх, үр удмаа үлдээх, аюулгүй орчин, өлсгөлөнгөөс ангид байх, усаар хангагдах....
- **Эдийн засгийн эрх:** Хоол хүнс, хувцас, орон байр хүрэлцэхүйц орлоготой байх, хөдөлмөрлөх, ажил хаях, өмчлөх, өв залгамжлуулах....
- **Улс төрийн эрх:** Үзэл бодлоо илэрхийлэх, итгэл үнэмшилтэй байх, сонгох сонгогдох, эвлэлдэн нэгдэх, оролцох, жагсаал хийх, гомдол гаргах....
- **Нийгмийн эрх:** Амрах, эрүүл мэндийн үйлчилгээ авах, сурах, аялах, хөдөлмөрийн таатай нөхцлөөр хангагдах....
- **Соёлын эрх:** Бүтээл туурвих, хэвлэн нийтлэх, уламжлалт соёлоо өвлөх, хадгалах, урлагийн бүтээл эдлэх....

Слайд 4. Хүний эрх, эрх чөлөө нь мөн чанараараа түгээмэл, салшгүй харилцан хамааралтай, хуваагдашгүй юм.

- **Түгээмэл:** Хүн бүр өөрийн оршин суугаа газар, хүйс, арьс өнгө, шашин шүтлэг, соёл, үндэстний байдлаас үл хамааран ижил тэгш эрхтэй төрж, эрхээ эдлэх ёстой.
- **Салшгүй:** Тусгайлан заасан нөхцөлд албан ёсны, шүүхийн шийдвэрээр хязгаарласнаас бусад тохиолдолд хүний эрхийг хязгаарлах, салгах ёсгүй.
- **Хуваагдашгүй:** Иргэний, нийгмийн, соёлын болон эдийн засгийн бүхий л эрхүүд нь ач холбогдлоороо бүгд адил бөгөөд харилцаа уялдаатай. Аль нэггүйгээр бусдыг нь бүрэн дүүрэн эдлэх боломжгүй юм.

Слайд 5.

- Энэ нь төрийн бүх салбар, бүх түвшинд, орон нутгийн түвшинд ч мөн хамааралтай. Төр нь төрөөс гаргаж буй хөгжлийн бодлого, төлөвлөгөө (нийгмийн болон эдийн засгийн аль алины)-г хэрэгжилтийн өмнө болон дараа нь хүний эрхэд үзүүлсэн үр нөлөөний шалгуураар үнэлж дүгнэх албан ёсны үүрэгтэй.
- Энэхүү үүрэг нь хүний эрхийг хүн бүр адил тэгш эдлэх явдлыг хангах зорилгоор хөгжлийн үйл явцад оролцож буй болон/эсхүл нөлөөлж буй гуравдагч талын (жишээ нь корпораци) зан үйлийг зохицуулахыг мөн хамрах ёстой.

Слайд 6. Хүний эрхийн зарчмууд:

- **Хүрэлцээтэй байх:** Төрийн үйлчилгээг хэрхэн үзүүлэх талаар хуульчлах, тухайн байгууллагын барилга байгууламж, тоног төхөөрөмж, ширээ сандал, ариун цэврийн өрөө, ундны цэвэр ус, мэргэжлийн боловсон хүчин, тэдний боломжийн цалин хөлс зэрэг асуудлыг шийдсэн байна.
- **Хүртээмжтэй байх:** Ямар нэгэн ялгаварлан гадуурхалтгүйгээр үйлчлэх, аливаа нэгэн үйл ажиллагаанд хүн бүр оролцох тэгш боломж олгосон байх.
- **Хүлээн зөвшөөрөгдсөн байх:** Төрийн зүгээс шаардлагатай дүрэм журмыг ойлгомжтой байдлаар тогтоох, иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн байх, төрийн үйлчилгээ авах боломжийг орчны болон мэдээллийн түвшинд бүрдүүлсэн байх зэрэг асуудлыг хамарна.



- **Цаг үетэйгээ зохицсон байх:** Төрийн бодлого, үйлчилгээ нь нийгмийн өөрчлөлт, хөдөлгөөнд таарч зохицсон байна. Эмзэг бүлгийн хувьд тэдний хэрэгцээнд нийцсэн байхаас гадна тухайн үйлчилгээгээр дамжин бусад эрхүүдийг дэмжсэн байвал зохино.

Слайд 7. Хүний эрх, эрх чөлөө хязгаартай юу? Хүний эрх, эрх чөлөөг хязгаарлаж болох уу?

- Хэн нэгний эрх, эрх чөлөө бусад хүмүүс, нийгмийн эрх, эрх чөлөөг хөндөх, зөрчих, халдах ёсгүй. Учир нь хүмүүс түгээмэл эрхийн хүрээнд эрхээ хамгаалуулах хэдий ч эв санааны нэгдэл, бусдын сайн сайхан байдалд халдах, түүнийг сэвтээж хөндөх ёсгүй.
- Хүний эрхийг ХЯЗГААРЛАЖ БОЛНО. Хүний эрх, эрх чөлөөг үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, нийгмийн эрүүл мэнд, нийгмийн ёс суртахуун, бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах зорилгоор хязгаарлаж болно. Хүний эрхийг хязгаарлах дээрх нөхцлүүдийн хил хязгаар, хэр хэмжээг олон улсын эрх зүйн баримт бичгүүдээр тодорхойлсон.

Слайд 8. Хууль эрхзүйн баталгаа

- ОУ-ын хүний эрхийн биллүүд: Нэгдсэн үндэсний байгууллагаас гаргадаг. ХЭТТ, ИБУТЭТП, ЭЗНСЭП, нэмэлт протоколууд, бүлгээр чиглэсэн конвенциуд, бүсийн орнуудын хамтарсан тунхаглал баримт бичгүүд;
- Үндэсний хууль тогтоомж: Үндсэн хууль, тодорхой эрхүүдийг хамгаалах хууль, бодлого, хөтөлбөр, үндэсний хөтөлбөр, Засгийн газрын мөрийн хөтөлбөр, үйл ажиллагааны үндсэн чиглэл, жилийн төсөв, орон нутгийн хөтөлбөрүүд

Слайд 9. Судалгааны тайланд орсон дараахь зурагт хүний эрхийн ямар төрлийн эрхийн зөрчлүүд харагдаж байна вэ? Хүний эрхийн зарчмуудад үндэслэн тайлбарлана уу? Хэлэлцүүлэг

Жишээ 3.12

Бидний ихэнх нь 35-аас дээш настай, ажилд орьё гэхээр ажлын байр байхгүй, ажил байдаггүй тийм л хүмүүс. Унд хоолныхоо төлөө шороо ухаж байгаад нэг л өдөр хүнд алуулах байх. Уурхайн харуул хамгаалалтынхан болон ажилтнууд нь нүхэн дотор байж байхад дээрээс ирж шороо хийдэг, булдаг.

(Бүлгийн ярилцлага, Уянга сумын ХАМО иргэд)

**“БИЧИЛ УУРХАЙН САЛБАР ДАХЬ ХҮНИЙ ЭРХ”
судалгаа 2012/2013 ХЭҮК, ШХА,**




Зураг №8 ХАМО иргэдийн үйл ажиллагаа

Слайд 10. Судалгаанд оролцогчдын ярианаас та бүхэн хүний эрхийн хэрэгжилтийг болон төрийн байгууллагын ажилтаны хүний эрхийн мэдлэг, хандлагын талаар саналаа хэлнэ үү? Хэлэлцүүлэг



3.5.1 Асуудалд дүн шинжилгээ хийх

“АСУУДЛЫН МОД” загвараар асуудлыг шинжлэх удирдамж 1



- Энэ загвараар тухайн бүлгийн сонгосон асуудлыг үүсгэсэн суурь шалтгаан юу байна? АСУУДАЛ нь өөрөө яг юу вэ? Харин тэр асуудал даамжрахад болон одоог болтол шийдэгдэхгүй, хүчрэгдэхгүй байсаар байхад нөлөөлж буй хүчин зүйл юу байна? Энэ асуудлаас үүсч буй нийгэм, эдийн засаг, байгаль орчны үр дагавар нь юу байна вэ? гэдгийг бүлгээрээ ярилцаж гаргана.
- Хүмүүс эдгээрийг хооронд нь хольж, ялгаа заагийг харж чадахгүйгээс суурь шалтгаанд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулахаас илүү үр дагавартай ажиллаж их цаг, хөрөнгө, хүчээ үрдэг. Суурь шалтгаан буюу тогтолцооны гажуудлыг засахгүйгээр бид асуудлыг үр дүнтэй шийдэж чадахгүй юм.



3.5.2 Тулгамдсан асуудалд ерөнхий дүн шинжилгээ хийх удирдамж 2

Асуудалд дүн шинжилгээ хийх олон төрлийн аргачлал байдгаас энд нийтлэг хэрэглэгддэг үндсэн хоёр аргуудыг орууллаа. Сумын эсвэл байгууллага, иргэдийн түвшинд тулгамдаж буй асуудалд дүн шинжилгээ хийхэд тохиромжтой аргачлал нь “АСУУДЛЫН МОД” аргачлал юм.

А. Дараах асуултанд бүлгээрээ хэлэлцэж хариулаад, үр дүнгээ “Асуудлын мод” загварын дүрслэлээр илэрхийлнэ үү.

1	Асуудал - түүнийг аль болох илүү фокуслаж тодорхойлно уу? – МОДНЫ ИХ БИЕ
2	Энэ асуудлыг үүсгэсэн, одоог хүртэл байлгасаар байгаа суурь шалтгаан нь юу вэ? – МОДНЫ ҮНДЭС
3	Энэ асуудалд нөлөөлөгч гол хүчин зүйлс юу юу байна вэ? - НАР, САЛХИ, БОРОО
4	Энэ асуудал ямар ямар сөрөг үр дагаврыг үүсгэж байна вэ? Эерэг үр дагавар: ЖИМС, НАВЧ, ЦЭЦЭГ; Сөрөг үр дагавар: зэрлэг ургамал тэжээх, чийг их татаж бусад ногоог ургуулахгүй байх, хортой хий гаргах гэх мэт
5	Энэ асуудал хэний эрх ашгийг хамгийн ихээр/ шууд хөндөж байна вэ? Хэний эрхийг дам/ шууд бусаар зөрчихөд хүргэж байна вэ? (хэр олон хүний)
6	Энэ асуудлыг шийдвэрлэх үүрэг хүлээсэн хүмүүс/байгууллага хэн хэн бэ?
7	Энэ асуудлыг шийдвэрлэхийн төлөө хэн, ямар байгууллага ажиллаж байна вэ?
8	Энэ асуудлыг ул суурьтай шийдвэрлэх хамгийн их хүсэл сонирхол Хэнд байгаа вэ? Яагаад? Тэд энэ асуудлыг шийдвэрлэх оролдлогод оролцож байгаа юу?
9	Энэ асуудлыг шийдвэрлэх бодлого, төлөвлөгөө байгаа юу? Тухайн бодлого/ төлөвлөгөө нь орон нутгийн байгаль орчин, эдийн засаг, нийгмийн хүний эрхүүд биелэх нөхцөл бүрдэхэд тэнцвэрийг нь хэрхэн ДЭМЖИЖ байна вэ? ЯАЖ?
10	Энэ асуудлыг шийдвэрлэх бодлого, төлөвлөгөө нь орон нутгийн байгаль орчин, эдийн засаг, нийгмийн хүний эрхүүд биелэгдэх тэнцвэрт хэрхэн СААД болж байна вэ? ЯАЖ?

Зааварчилгаа – (Чиглүүлэгч нарт)

Тулгамдсан асуудлын суурь шалтгаанд дүн шинжилгээ хийх дасгал ажлыг ХОЁР ХУВИЛБАР-тай төлөвлөлөө. Учир нь Азийн сангийн зорилтот асуудал нь “уул уурхайн үйл ажиллагаагаар нөхөн сэргээгдээгүй үлдсэн талбайд бичил уурхай эрхлэгчид гар аргаар нөхөн сэргээлт хийх аргачлал бий болгож, үр дүнтэй туршиж байгаа юм. Тэрхүү аргачлалаар БУЭ иргэд өөр өөрийн орон нутагтаа нөхөн сэргээлтийн ажил хийх, улмаар ногоон ажлын байр бий болгох зорилтот асуудал юм.

1-р хувилбар: Азийн сангийн энэхүү 2 зорилтот асуудлын дагуу тухайн орон нутгийн нөхөн сэргээгдээгүй үлдсэн талбайн асуудал, мөн тухайн орон нутгийн хөдөлмөрийн насны хүн амын тодорхой хувийг эзлэх БУЭ иргэдийн ажлын байрны асуудал гэсэн үндсэн 2 сэдвийг шууд оноож өгөн суурь шалтгааны дүн шинжилгээ, ХЭСХ-ын болон тогтвортой хөгжлийн зарчимд суурилсан дүн шинжилгээ хийлгэж стратеги төлөвлөгөө боловсруулах дасгал ажил хэсэгт: “Орон нутгийн байгаль орчныг нөхөн сэргээх төлөвлөгөө” боловсруулахаар төлөвлөсөн хувилбар юм. Бичил уурхайчид, ХАМО иргэдтэй сум, орон нутгуудад нийтлэг орхигдсон талбайд нөхөн сэргээлт хийж бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлэх, бичил уурхайчдыг өөр ажлын байранд шилжүүлэх нь тулгамдсан асуудал байдаг.

2-р хувилбар: Зарим нэгэн орон нутаг нөхөн сэргээх талбай байхгүй байж болно, эсвэл ХАМО иргэд байхгүй байж болно, эсвэл түр зогссон гэх зэрэг энэ чиглэлийн асуудал нь нэн тулгамдсан биш байж болох юм. Ийм тохиолдолд тухайн орон нутагт нийтийн эрх ашигтай холбоотой нэн тулгамдсан асуудлуудыг оролцогчдоор санаа “шидэх” аргачлалаар гаргуулан жагсаалт гаргаж, түүнийг нэн чухлаас эхлэн эрэмбэлүүлж 3-4 асуудлыг сонгоно. Эдгээр сонгосон асуудлыг сургалтын туршид дасгал ажлын сэдэв болгож аваад ХЭСХ болон тогтвортой хөгжлийн зарчим дагуу дүн шинжилгээ хийж сургалтын төгсгөлд Стратеги төлөвлөгөө боловсруулах дасгал ажил хэсэгт: сургалтын дараа бодитой хийх ажлын төлөвлөгөө гаргах хувилбар.

Иймд сургалт зохион байгуулж буй тухайн орон нутгийн онцлогоос шалтгаалж аль хувилбарыг сонгохыг чиглүүлэгчдийн баг шийдэж дасгал ажлыг хийнэ.



3.5.3 Асуудал бэрхшээл хоёрын ялгаатай ойлголт

	АСУУДАЛ	БЭРХШЭЭЛ
Нөлөөллийн хүрээ	Нийтийг хамарсан, нийтийн эрх ашиг хөндөгдсөн	Тодорхой нэг хүн, гэр бүл ихэвчлэн байх бөгөөд цөөн тохиолдолд бүлэг хүмүүсийг, нэг байгууллагын хэмжээнд байж болно
Шинж нь	Асуудлыг шийдсэнээр үр ашгийг нийт иргэд хүртэх	Асуудлыг шийдсэнээр үр ашгийг нийгмийн тодорхой нэг хэсэг хүртэх
Шийдэл нь	Төрийн бодлого, хууль боловсруулан гаргах, шинэчлэх, тогтолцооны өөрчлөлт хийх	Нэг удаагийн арга хэмжээ авснаар шийдэж болох



3.6.1 Хүний Эрхэд Суурилсан Хандлага (ХЭСХ)-ын танилцуулга

Слайд 1 Агуулга:

- ХЭСХ гэж юу болох
- Төр үүрэг хүлээгч болох нь

Слайд 2 ХЭСХ гэж юу болох

- Хүний эрхэд суурилсан хандлага (ХЭСХ) нь хүмүүсийн эрхээ бүрэн эдлэх боломжийг хүн бүрт олгох зорилготой суурь зарчмуудыг хэрэглэдэг үйл явц юм.

Слайд 3. Яагаад?

- Хүмүүс ЭРХЭЭ бүрэн дүүрэн ЭДЭЛЖ, эрхэмсэг, нэр төртэй, хүн шиг амьдарч тасралтгүй ХӨГЖИЖ, амьдралын чанараа байнга дээшлүүлж байх эрхтэй.

Хөгжих эрхийн тухай тунхаглал, 1986 он НҮБ

- Хүмүүс бид, хүн бүр ялангуяа нийгмийн эрх мэдэл багатай, эрхээ бүрэн дүүрэн эдэлж бас нэхэж шаардаж чадахгүй бүлгийн хүмүүсийн эрхийн бүрэн эдлүүлэх, улмаар ХӨГЖИХ эрхийг хангахын тулд ХЭСХ хэрэгсэл болж байна.

Слайд 4. ХЭСХ хэрэгжүүлэх зарчим:

ХЭСХ-ын зарчмууд нь улс орон хамтран болон дангаараа төлөвлөж, хэрэгжүүлэхийн зэрэгцээ эдийн засаг, нийгэм, соёл, улс төрийн үйл явцын үр дүн буюу хөгжлийг хэмжих толь, хууль ёсны тогтолцооны нэг хэсэг юм.

Зарчмууд нь:

1. Олон улсын хүний эрхийн тогтолцоог хэрэгжүүлэх
2. Эрх мэдэл олгох
3. Оролцоог хангах
4. Үл ялгаварлах болон эмзэг бүлэгт тэргүүлэх ач холбогдол өгөх
5. Хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх

Слайд 5. Зарчим 1. Олон улсын хүний эрхийн зарчмыг мөрдөх

Хүний эрхэд суурилсан хандлага (ХЭСХ)- ийн хүрээнд хүний эрхийн талаарх Олон улсын болон үндэсний мөн бүс нутгийн, тодорхой бүлэг, асуудлын чиглэлээр гарсан өргөн хүрээний баримт бичгүүд, хувийн хэвшил, бизнесийн салбарын хүний эрхийг хангах үүрэг, зарчмын агуулга, тэдгээрийг мэдэж байх шаардлагатай. Мэдэх нэг хэрэг хэдий ч хамгийн гол нь түүнийг мөрддөг байх шаардлагатай. Эдгээр баримт бичгүүдийг хүлээн зөвшөөрч нэгдсэн улс орнууд нь тэдгээрийг даган мөрдөх, үндэсний хууль тогтоомждоо тусган баталгаажуулж сахин мөрдөж хэрэгжүүлэх тогтолцоог бий болгох ёстой.

МХЗ-уудад хүрэх арга нь хүний эрхэд суурилсан, зөвхөн хөгжлийн үр дүнд бус түүнчлэн хөгжилд хүрч буй арга зам, үлдэж буй ул мөрд анхаарсан байх шаардлагатай байдаг.

Слайд 6. Зарчим 2. Эрх мэдэл олгох

Эрх олгох буюу эрх мэдэлжүүлэх зарчим гэдэг нь иргэдийг өөрсдийн хувь заяа, эрх ашгийн асуудлаар, хөгжлийн асуудлаар гаргах гэж буй шийдвэрийн талаарх мэдээллийг хэрэгцээтэй үед нь, хүртээмжтэй хангах, ингэхдээ тэдний олон янз байдал, чадавхад нь тохирсон боловсруулалт бүхий мэдээллийг өгч, хоорондоо зөвлөлдөх, эрх зүйн туслалцаа авах, санал боловсруулах хангалттай хугацаатай ойлгомжтойгоор өгөх ойлголт юм. Энэ нь зөвхөн шийдвэр гаргахын өмнө гэлтгүй хэрэгжилтийн үед, үнэлэх, сайжруулах үед ч адил эрх мэдэлжүүлэх тухай ойлголт юм.

Эрх мэдэл олгох буюу эрх мэдэлжүүлэх зарчмыг хангах явдал нь ХЭСХ-ын оролцооны ба хариуцлагын тогтолцоог бий болгох, сайжруулах урьдач нөхцөл болж өгдөг.

Эрхмэдэлжүүлэх зарчмыг хангах нь эрх агуулагч болон үүрэг хүлээгч талуудын аль алиных нь мэдээлэл солилцох эргэх холбоог сайжруулах, улмаар шийдвэр гаргах үйл явцад оролцох боломжийг хангах нөөц, чадавх, мэдлэгийг нэмэгдүүлж байдаг.

Слайд 7. Зарчим 3. Оролцоог хангах

ХЭСХ-ын бусад зарчмын адил оролцооны эрх нь олон улсын хуулийн тодорхойлолтоор “идэвхтэй, чөлөөтэй, утга бүхий байх” цогц ойлголт бөгөөд үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, боловсрол эзэмших, мэдээлэл олж авах зэрэг олон эрхийг хангах явдлыг шаарддаг.



Эрх мэдэл буюу эрх мэдэлжсэн иргэд оролцоотой байж чадна. Учир нь тэд шийдвэр гаргахаас өмнө, түүний хэрэгжилтэд, үнэлэх бүхий л явцад мэдээлэлтэй байж, мэдэлжсэн байдаг. Үнэн зөв мэдээлэлтэй иргэд утга учиртай оролцоотой байж чаддаг.

Үр дүнтэй оролцох нь үүрэг хүлээгчдээс иргэдэд эрх мэдэл олгох хүсэл эрмэлзэл болон эрх агуулагчдаас эрх мэдэл олох санаачлага, аль алинаас хамаарах бөгөөд “орон нутгийн хүмүүс өөрсдийн нутаг орны өмнө тулгарч буй бэрхшээл, тулгамдсан асуудлыг тодорхойлж, эдгээрийг шийдвэрлэх хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, улмаар гарч буй үр дүнд хяналт тавих чадвартай” байх асуудал юм.

Слайд 8. Зарчим 4. Үл ялгаварлах ба эмзэг бүлэгт тэргүүлэх ач холбогдол өгөх

ХЭСХ-ын бусад дөрвөн зарчимтай адил, энэ зарчим нь олон улсын эрх зүйн тогтолцооноос шууд урган гарах ба хүний эрхийг хамгаалах гол цөм хэсэг нь юм.

Хүний эрхийг хангахад ялгаварлан гадаархах байдлыг халах, эрх мэдэл багатай, дуу хоолой үзэл бодлоо шийдвэр гаргах түвшинд хүргэх нөөц боломж, чадавх багатай хэсэгт тэргүүлэх ач холбогдол өгөх нь хүний эрхийн талаарх бүх гэрээнүүдэд тусгагдсан байдаг.

ХЭСХ-ын 4 дэх зарчмыг хүндэтгэх нь хөгжлийн үйл ажиллагаанд гол төлөв хэрэглэгдэж байдаг ч аливаа нэг цөөнх эсхүл эмэгтэйчүүдийг тэргүүлэх чиглэл болгох, эмзэг гэж авч үзэх тухай асуудал огтхон ч биш юм.

Слайд 9. Зарчим 5 – Хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх

ХЭСХ-ын хариуцлагын тогтолцоо гэдэг нь эрхзүйн тогтолцоо, эрх мэдэл олголт, оролцоог хангах, эмзэг бүлэгт анхаарах гэсэн ХЭСХ-ын дээрх дөрвөн зарчим нэгэн зэрэг хангагдах хөшүүрэг болох бөгөөд хүний эрхийн үүрэг хариуцлагыг сахин хэрэгжүүлэх хариуцлагын тогтолцоо гэж ойлгоно.

Хариуцлагын тогтолцооны зарчим нь зөвхөн буруутгах, шийтгэх тухай асуудал биш ч гэсэн нөхцөл байдлаас шалтгаалан эдгээр арга хэмжээ авах шаардлага гарч болно. Энэхүү зарчмыг хангахдаа эрх агуулагч, үүрэг хүлээгч талуудын мэдээллийн урсгалыг сайжруулах, үйл явцыг үр дүнтэй засч залруулах, талууд тэгш эрх эдлэх, шударга ёсыг хангах зэрэг бусад олон эрхийг хангаж байхыг шаарддаг.

Слайд 10. Хүний эрхийг ХЭН биелүүлэх вэ?


“Төр ба бусад үүрэг бүхий этгээд хүний эрхийг хангахад мэдрэмжтэй байна. Энэ утгаараа, тэд хүний эрхийн асуудалд тусгагдсан эрхзүйн норм, стандартыг дагаж мөрдөх үүрэгтэй.

Ингэж чадаагүй нөхцөлд, хуулийн дагуу тогтоосон дүрэм, зарчмын дагуу холбогдох шүүх, тохируулагч байгууллага арга хэмжээ авахаас өмнө эрхээ эдлэгчид нь зохих арга хэмжээ авах эрхтэй байна.

Слайд 11. Төрийн үүрэг

Олон улсын хүний эрхийн эрх зүйн хэм хэмжээгээр төр бол хүний эрхийг хамгаалах, хангах үүрэг хүлээдэг. Төр нь нэн тэргүүнд өөрийн улсын нутаг дэвсгэр дээрх хүмүүсийн эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах үүрэгтэй.

Слайд 12. Хүний эрхэд суурилсан хандлага





Слайд 13. Төрөөс хүний эрх, эрх чөлөөг БИЕЛҮҮЛЭХ үүргээ дараах үндсэн гурван хэлбэрээр хэрэгжүүлнэ. Үүнд:

Хүний эрхийг хүндэтгэх: Тухайн эрхийг эдлэхэд ямарваа нэгэн саад учруулахгүй, зөрчихгүй байхыг ойлгодог. Төрийн зүгээс хүмүүсийн эрхээ эдлэх гэсэн үйлдлийг хязгаарлах, хууль зөрчсөн үйл ажиллагаа явуулж болохгүй (жишээлбэл, эрүүдэн шүүх, хууль бусаар баривчлах, хүчээр нүүлгэх буюу төлбөрийн чадваргүй хүмүүст төлбөртэй эмнэлгийн үйлчилгээ санал болгох гэх мэт).

Хүний эрхийг хамгаалах: Хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг нь сэргээх, хохирлыг арилгах бүтэц, тогтолцоог бий болгох боловсронгуй хууль тогтоомж батлахыг ойлгодог.

Хүний эрхийг биелүүлэх: Хүний эрхийг хэрэгжүүлэхэд чиглэсэн баталгааг бий болгох эерэг алхамуудыг ахиц дэвшил гаргасан байдлаар авах ёстой. Ялангуяа хялбаршуулах (үйлчилгээний хүртээмжийг амар хялбар болгох), хөхиүлэн дэмжих (мэдээллэх), хэрэгжүүлэх (эмзэг бүлгийг эн тэргүүнд анхаарч, тэгш байдлыг бүрдүүлэхэд чиглэх) арга хэмжээг авна.

Слайд 14. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 2 дугаар зүйлийн 1-т заасны дагуу “Энэхүү Пактад оролцогч улс бүр дангаараа болон олон улсын тусламж, хамтын ажиллагаагаар, тухайлбал эдийн засаг, техникийн салбарт, энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг бүрэн хэрэгжүүлэхийг дэвшилттэйгээр хангахын тулд хууль тогтоомжийн арга хэмжээг оролцуулан, байгаа бүх боломжийнхоо хэрээр зохистой арга хэмжээг авах үүрэгтэй”

“Дэвшилттэйгээр хангах” гэдэгт эдийн засаг, нийгэм, соёлын бүхий л эрхийг богино хугацаанд бүрэн хэрэгжүүлэх боломжгүй болохыг хүлээн зөвшөөрч, эрхүүдийг хүндэтгэн хангах арга хэмжээг нэн даруй авч аажим аажмаар хангахыг ойлгоно.

“Бүх боломжийнхоо хэрээр” гэдэгт улсуудын эдийн засаг, санхүүгийн бололцоо, бусад нөөц харилцан адилгүй тул тодорхой цаг хугацааны дараа эрхүүдийг бүрэн дүүрэн хэрэгжүүлж болно. Гэхдээ үүнийг төр өөрөө хангалттай нөөц бололцоотой болох хүртлээ эрхүүдийг хамгаалахгүй гэж буруугаар тайлбарлаж болохгүй. Харин өөрийн чадах хэрээр эрхүүдийг эдлэх явдлыг сайжруулахаар бүхий л талаар хичээх ёстой.

“Зохистой арга хэмжээг авах” гэдэгт оролцогч улсууд энэ Пактад нэгдэн орсны дараа богино хугацаанд авч хэрэгжүүлэх зорилгод чиглэсэн дэвшилттэй алхам хийнэ гэсэн үг. Эрх бүртэй холбоотой нөхцлийг харгалзан тэдгээрт тохирсон зохистой арга хэмжээг өөрсдөө шийдвэрлэн авч хэрэгжүүлэх ёстой.

Слайд 15. Төр үүргээ биелүүлж чадахгүй бол яах вэ?

Иргэд төрийн холбогдох байгууллага, удирдлагатай хариуцлага тооцохыг шаардах, зөрчигдсөн эрхээ сэргээх, учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр төрөөс шаардах эрхийг баталгаажуулсан. Холбогдох байгууллага гэдэгт тухайн албан хаагч, эсвэл байгууллагын дээд шатны удирдах эрх бүхий этгээдэд, мөн энгийн болон захиргааны хэргийн шүүхэд, Хүний эрхийн Үндэсний Комисст, Үндсэн хуулийн цэцэд хандаж, өөрийн эрхээ шаардаж болно.

Слайд 16. “НҮБ-ын Хамгаал, Хүндэл, Эрхийг Сэргээ хэмээх бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх Бизнес ба хүний эрхийн удирдах зарчим”

2011.06.16-ны өдөр НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөл

Бизнес ба хүний эрхийн удирдах зарчим” нь үндсэн 3 тулгуур зарчмаас бүрдэх ба зарчим тус бүрийг хэрэгжүүлэх ерөнхий арга замуудыг тодорхойлсон юм.

Нэгдүгээр зарчим-Хамгаал. Төр бол зохистой бодлого, зохицуулалтаар дамжуулан хүний эрхийг гуравдагч талууд зөрчихөөс хамгаалах үүрэгтэй.

Хоёрдугаар зарчим-Хүндэл. Бизнесийн байгууллага нь хүний эрхийг хүндэтгэх үүрэг хүлээнэ. Энэ нь “үл хохироох” гэдэг зарчим юм. Бизнесийн байгууллага нь эрсдлийн судалгаа, нөлөөллийн үнэлгээ, хуулийг чанд мөрдөх зэрэг үйл ажиллагаагаар дамжуулан хүний эрхийг зөрчихөөс сэргийлэх ёстой юм. Энэ зарчим нь бизнесийн байгууллага шууд бус байдлаар хүний эрхийг зөрчсөн үйл ажиллагаанд оролцох тухай асуудалд ч хамааралтай бөгөөд урьдчилсан үнэлгээ судалгаа чухал болохыг онцолдог. Бизнесийн байгууллага нь хүний эрхийг хүндэтгэх, эрх зөрчсөн үйл ажиллагааг дэмжих, хамтран оролцохоос татгалзах үүрэгтэй.

Гуравдугаар зарчим - Эрхийг сэргээ. Эрх нь зөрчигдсөн иргэд буюу хохирогчид эрхээ хамгаалах шүүхийн ба шүүхийн бус тогтолцоог бий болгосон байх явдал юм. Төр нь хуулийн хүрээнд хохирсон иргэдийн эрхийг хамгаалах, хохирлыг барагдуулах, гэм буруутай этгээдэд шүүх болон захиргааны аргаар хариуцлага тооцох ажлыг хариуцах ёстой.



Слайд 17. Даян дэлхийн гэрээ. 2002

1. Бизнесийн үйл ажиллагаанд хүний эрхийг хамгаалах олон улсын тунхаглалуудыг дэмжин хүндэтгэх.
2. Бизнесийн үйл ажиллагаанд хүний эрхийг аливаа хэлбэрээр зөрчихгүй байх.
3. Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, хамтын хэлэлцээр байгуулах эрхийг үр ашигтайгаар хүлээн зөвшөөрөх.
4. Хүчээр болон албадан хөдөлмөрлүүлэх аливаа хэлбэрийг арилгах.
5. Хүүхдийн хөдөлмөрийг арилгах.
6. Хөдөлмөр эрхлэлт, ажил мэргэжлийн хүрээнд ялгаварлан гадуурхах явдлыг арилгах.
7. Бизнесийн үйл ажиллагаанд байгаль орчны өөрчлөлт, доройтлоос урьдчилан сэргийлэх.
8. Бизнесийн үйл ажиллагаанд байгаль орчны хариуцлагыг өндөржүүлэх.
9. Байгаль орчинд ээлтэй технологийг хөгжүүлэх, нэвтрүүлэх.
10. Авилга, хээл хахуулийн бүх хэлбэрийн эсрэг тууштай ажиллах.

Слайд 18. “Бизнес ба хүний эрхийн удирдах зарчим”. 2011

1. Оновчтой бодлого, зохицуулалт, шийдвэрийн тусламжтайгаар гуравдагч этгээд болох Бизнесийн байгууллагуудын зүгээс хүний эрхийг зөрчихөөс хамгаалахыг төрд үүрэг болгодог.
2. Бизнесийн байгууллагууд үйл ажиллагаандаа бусдын эрхийг зөрчихөөс сэргийлэхийг хичээнгүйлэн эрмэлзэж, хүний эрхийг хамтаараа хүндэтгэхийг үүрэг болгодог.
3. Шүүхийн болон шүүхийн бус арга хэлбэрээр хохирогчдын эрхийг идэвхийлэн сэргээх, сэргээн эдлүүлэх хэрэгцээ шаардлагыг чухалчилдаг.

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл эдгээр гурван зарчмыг

- Хүний эрхийг хамгаалах төрийн үүрэг нь олон улсын хүний эрхийн тогтолцооны нэн чухал бүрэлдэхүүн учраас
- Хүний эрхийг байнга хөндөж байдаг бизнесийн үйл ажиллагаанд уг эрхийг хүндэтгэх нь нийгмийн хүсэл эрмэлзэл байдаг учраас
- Хүний эрх зөрчигдөхөөс байнга сэргийлж чаддаггүйгээс зөрчигдсөн эрхийг сэргээх шаардлага гардаг учраас чухал үр нөлөөтэй гэж үзжээ.

Слайд 19. Хүний эрхийг хамгаалах үндэсний механизм

Хүний эрхийг хамгаалах үндэсний механизмын хүрээнд хамрагдах байгууллагуудыг үйл ажиллагааных нь онцлог, байгуулагддаг зарчмыг нь харгалзан дор дурдсан 4 ангилалд авч үзэж болох юм.

1. Төрийн механизм
2. Орон нутгийн механизм /бүх шатны ИТХ, ЗД/
3. Хүний эрхийг хамгаалах үндэсний байгууллага /ХЭҮК/
4. Иргэний нийгэм

Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлд “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж заасан байдаг. Тиймээс төр бол хүний эрхийг хамгаалах хамгийн анхдагч механизм байх ёстой.

Хүний эрхийг хамгаалах төрийн механизмд дараах байгууллагууд хамаарна.

1. Хууль тогтоох эрх мэдлийн байгууллага: Монгол Улсын Их Хурал
2. Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагууд:
 - Монгол Улсын Засгийн газар
 - Аймаг, нийслэл, сум, дүүрэг, багийн засаг захиргааны нэгж
3. Шүүх эрх мэдлийн байгууллагууд:
 - Монгол Улсын Үндсэн хуулийн цэц
 - Бүх шатны шүүх
 - Бүх шатны прокурорын газар

3.7.1 Орон нутгийн бодлогын баримт бичигт эрхэд суурилсан хандлагаар дүн шинжилгээ хийх зааварчилгаа 1

Орон нутгийн БОДЛОГО ХӨТӨЛБӨР-т ХЭСХ-ын дүн шинжилгээ хийх:

Доорх асуултуудад хариулах замаар оногдсон тухайн тулгамдсан асуудлыг зохицуулж буй бодлого, бодлогын баримт бичигт дүн шинжилгээ хийх

Бодлогын баримт бичигт ХЭСХ-ын үндсэн зарчмуудад суурилсан үнэлгээ хийж цаашид илүү сайжруулах стратегийн суурийг эхлүүлэх

Бүлгийн ажлыг чиглүүлэх асуултууд:

Тухайн асуудал шийдэгдэхгүй байх нь хэний ямар бүлгийн эрх ашгийг илүү зөрчиж байгааг урьд хийсэн бүлгийн ажлаар тодорхойлсон.

Хүний эрхэд суурилсан хандлага түүний таван зарчмыг өөрийн орон нутгийн түвшний бодлогын баримт бичиг боловсруулж батлах, хэрэгжүүлэх, хэрэгжилтийг үнэлэх бүх үйл явцад хэрэглэсэн эсэхийг тулган үнэлж үзнэ.

- Олон улсын хүний эрхийн тогтолцоог үндэсний түвшиндээ хэрэгжүүлэх зарчим:** ХЭТТ-ын хураангуй жагсаалт, Үндсэн хуулийн хураангуй жагсаалт дахь заалтуудаар үнэлж үзэхдээ тэр заалтууд хэр тусгагдаж вэ гэдэгт багаар хэлэлцэж хариулна.
- Оролцоог хангах зарчим:** Тухайн бодлого шийдвэрийг боловсруулах явцад эрх ашиг нь хамгийн ихээр зөрчигдөж буй хэсгийн саналыг авсан уу? Тэдгээр хүмүүст энэ бодлого хөтөлбөрийн талаар тайлбар танилцуулга хийж мэдээллээр хангасан уу? Мэдээлэл өгөх уулзалт хэлэлцүүлэгт эрэгтэй, эмэгтэй, залуус, ахмад, хөгжлийн бэрхшээлтэй нийгмийн бүлгүүдийн төлөөллийн харьцаа ямар байсан бэ? Тэдгээрийн орон нутгийн хөгжилд оруулж буй хувь нэмрийг хэрхэн бүртгэдэг вэ?, урамшуулдаг систем байгаа юу?
- Эрх мэдэл олгох зарчим:** Иргэдийн хэлэлцүүлэг явуулсаны дараа иргэдээс гарсан саналыг хэрхэн бодлогод тусгасан, тусгах боломжгүй талаар эргэж мэдээлсэн үү? Малчид эсвэл гэрээр байгаа иргэд, ажилгүй хүмүүсийг оролцуулах, саналыг авах ямар хэлбэрийн арга хэмжээ зохион байгуулсан эсвэл авсан бэ? Зар мэдээллийг хүмүүс хүртээмжтэй амар хялбар авах боломж байсан уу? Энэ бүлгийн хүмүүст эдийн засгийн ямар боломжуудыг эрх мэдлийн хүрээнд олгосон бэ? Тэд ашиглаж чадсан уу? Тэр чадавхийг бий болгох талаар үр дүнтэй сургалт мэдээлэл хийсэн үү?
- Үл ялгаварлах болон эмзэг бүлэгт тэргүүлэх ач холбогдол өгөх зарчим:** Асуудлыг шийдэхгүй байснаар эрх ашиг нь хамгийн их зөрчигдөж байгаа эсвэл хязгаарлагдаж байгаа бүлгийг ямар арга замаар оролцоог хангасан бэ? Тэр хүмүүсийн гаргасан санал бодлогод хэр туссан бэ? Тэдэнд тийм чадавх байсан уу? Байгаагүй бол тэр боломжийг олгох ямар арга хэмжээ авсан бэ? Тэдэнд хүрэх төсөв захиргааны зардалд байдаг уу? Төрөөс илүү анхаарах бүлгийн хүүхдүүд бүгд цэцэцрлэг сургуульд хамрагдсан уу?
- Хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх.** ЗДТГ-ын өрөөнд энэ бодлогын үр нөлөөний талаар хөгжлийн бэрхшээлтэй тэргэнцэртэй иргэн хүссэн үедээ орж уулзах боломжтой юу? Бодлогын асуудлаар иргэдийн саналыг тогтмол хүлээж авдаг механизм байсан уу? Нийт хэдэн иргэд энэ бодлогод санал өгсөн бэ? ИТХ-ын төлөөлөгчид энэхүү бодлогыг хэдэн хүнд таниулсан бэ? Бодлогын хэрэгжилтийг үнэлэх ажлын багт иргэд оролцсон уу? Дүгнэлтэд иргэдийн санал хэр тусгалаа олдог вэ? Бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх, үнэлэх төсөв байгаа юм бэ?

Асуултуудад багаараа хэлэлцэж хариултаа самбарын цаасан дээр бичиж бусад багийнханд танилцуулна.



3.7.2 Орон нутгийн бодлогын баримт бичигт эрхэд суурилсан хандлагаар дүн шинжилгээ хийх хяналтын матриц

ХЭСХ-ЫН ҮНДСЭН ТАВАН ЗАРЧИМ	ТӨРИЙН ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ ҮҮРГҮҮДИЙН ХЭЛБЭР		
	ЭРХИЙГ ХҮНДЭТГЭХ Хүмүүс эрхээ эдлэхэд нь ямар нэг саад болохгүй, саад болох шийдвэр гаргахгүй байх	ЭРХИЙГ ХАМГААЛАХ ХЭ-ийг хамгаалсан хууль тогтоомж, бодлого шийдвэр гаргасан байх	ЭРХИЙГ ХАНГАХ ХЭ-ийг хэрэгжүүлэх баталгааг бий болгох, төрийн үйлчилгээг хөнгөвчлөх, хялбаршуулах
Ялгаварлан гадуурхахгүй байх			
Хүрэлцээтэй байх			
Хүртээмжтэй байх			
Хүлээн зөвшөөрөгдсөн байх			
Цаг үетэйгээ зохицсон байх			



3.8.1 “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал” танилцуулга

Тогтвортой хөгжлийн тухай ойлголт

Слайд 1

1972 онд Стокгольмд “Хүрээлэн буй орчин”
1992 онд Рио Де Жанейрод “Тогтвортой хөгжил”
2012 онд РИО+20 “Бидний хүсч буй ирээдүй”

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний хүрээлэн буй орчны тухай бага хурлаас 1972 оны 6 дугаар сарын 16-нд баталсан Стокгольмын тунхаглал баталснаар тогтвортой хөгжлийн үзэл баримтлал хэрэгжиж эхэлсэн

Слайд 2

Тогтвортой хөгжил:

Тогтвортой хөгжил гэдэг нь ирээдүй үеийнхнийхээ хэрэгцээ шаардлагыг хязгаарлахгүйгээр, одоо үеийнхний хэрэгцээ шаардлагыг хангахад чиглэгдсэн хөгжил


Слайд 3

Монгол Улсын Тогтвортой Хөгжлийн Бодлого

Монгол Улсын 21-р зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр 2015 оноос хойш хөгжлийн хөтөлбөрийн гол суурь нь “Тогтвортой Хөгжил” ба ногоон эдийн засаг

Слайд 4

Тэнцвэртэй, Тогтвортой Бодлого






Слайд 5

Тогтвортой хөгжлийн бодлого, ХЭСХ-аар боловсруулсан бодлого, үйл ажиллагаа

	Бодлого боловсруулах	Бодлого хэрэгжүүлэх	Бодлогын үр нөлөөг үнэлэх
ОУ-ын зарчмыг хэрэгжүүлэх			
Эрх мэдэлжүүлэх			
Оролцоог хангах			
Зорилтот бүлэгт чиглэсэн байх			
Хариуцлагын механизмыг агуулсан байх			

Слайд 6

Бидний хүсч буй хөгжил



Слайд 7

Орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд оролцогчид



Слайд 8

Нөөцийг хөгжил болгох зам

- ЯАХ гэж НӨӨЦ-ийг олборлодог вэ? ХӨГЖИЛ
- Байгалийн баялгийг олборлох нь нийгмийн хөгжил, эдийн засгийн өсөлтөд өвөрмөц боломжуудыг бий болгож байна.
- ГЭВЧ байгалийн баялагийн олборлолт болон эдийн засаг, нийгмийн хөгжлийн хооронд эерэг бус хамаарал оршиж байдаг.
- БАС өөр өөр эрх, ашиг сонирхол бүхий гурван талын хооронд үргэлжийн зөрчилдөөн үүсгэж ЗӨВШИЛЦӨЛ шаардаж байдаг.
- Голланд өвчин ҮЗЭГДЭЛ: валютын ханш чангарах, уул уурхайн бус, байгалийн баялагтай холбоогүй бусад салбаруудыг эдийн засгаас шахах, их ихэмжээний тогтворгүй төсвийн зардлын өсөлт, эдийн засгийн огцом өсөлт эсвэл огцом уналт дагуулсан мөчлөгүүд бий болох, - Эмчилгээ- тогтвортой хөгжлийн бодлогод уялдсан оновчтой эдийн засгийн бодлого
- Баялагийн хараал: үзэгдлийн ҮР ДАГАВАР: улс төрийн тогтворгүй байдал, эдийн засаг нийгмийн хөгжлийн сулрал, тогтворгүй байдал үүсэх- Эмчилгээ нь тогтвортой хөгжлийн бодлогод уялдсан зөв Төсвийн бодлого

3.9.1 Стратеги төлөвлөгөө боловсруулах бүлгийн ажлын заавар



Дээрх загварыг ашиглаад эрхэм зорилго, зорилтууд, үйл ажиллагаануудаа тодорхойлно уу:

1	Алсын хараа: Шийдвэрлэхийг зорьж буй тулгамдсан асуудалтайгаа холбоотой мөрөөдөл юм. Алсын хараа буюу мөрөөдөл нь таны бүх үйл ажиллагааг хэзээ ямагт чиглүүлж, удирдаж байдаг “жанжин шугам” юм. Зарим жишээ: Сумын хэмжээнд ядууралгүй болох ХАМО иргэдийн эрүүл мэндийг сайжруулах Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт хийх
2	Зорилго: Алсын хараандаа хүрэхэд чиглэсэн тодорхой, хүрч болохуйц зорилго буюу үр дүн. Алсын хараа ерөнхий, өргөн хүрээтэй байдаг бол таны зорилго тодорхой, хүрч/хэрэгжүүлж болохуйц, хэмжигдэхүйц, цаг хугацаатай, тодорхой бүлгүүд рүү чиглэсэн, үйл ажиллагаа болон бодит үр дүн рүү хөтөлсөн байх ёстой. Зорилгын зарим жишээ: Сумын орлого багатай иргэдийн ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх ХАМО иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх Олборлох үйлдвэрлэх эрхлэгчдэд хүний эрхийг биелүүлэх зарчмыг мөрдөхөд нь дэмжлэг үзүүлэх Зорилгоо тодорхойлохдоо дараах асуултуудыг бодолцоорой: Энэ зорилго таны алсын хараа, үнэт зүйлс, зарчимтай нийцэж байна уу? Энэ зорилго хүний эрх, эрх чөлөөг биелүүлэх үүрэгт дэмжлэг болох уу? Энэ зорилгод хүрвэл хүмүүсийн, ялангуяа эрх нь зөрчигдөж буй хэсгийн амьдралд бодит эерэг өөрчлөлт гарах уу? Энэ зорилго иргэдийг илүү хүчтэй, эрх мэдэлтэй болгох уу? Хариуцлагатай, ил тод, ардчилсан засаглалыг хөгжүүлэх үү? Олон хүний дэмжлэгийг авч, иргэдийг нэгтгэж чадах уу? Энэ зорилгыг хүмүүст тайлбарлаж ойлгуулахад амархан уу? Энэ зорилго хөрөнгө босгоход дөхөм үү?
3	Зорилтууд: Том зорилгодоо хүрэхийн тулд юуг, яаж, хэзээ хийхийг илтгэсэн богино хугацааны үйлдэл түүний үр дүн. Зорилтуудын зарим жишээ: Аймаг, сумын ажил эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн үр нөлөөг нэмэгдүүлэх, сайжруулах ХАМО иргэдийн дунд эрүүл мэндийн клубууд байгуулах Олборлох бизнес эрхлэгчдэд хүний эрхийн мэдлэгийг нэмэгдүүлэх
4	Үйл ажиллагаа: Богино хугацааны үр дүн, зорилтдоо хүрэхийн тулд хэрэгжүүлэх тодорхой үйл ажиллагаа буюу алхамууд. Жишээ нь: Орлого багатай иргэдийг хэрэгцээ, сонирхолд нь нийцсэн сургалтуудад хамруулах Өрхийн эмнэлгийн ажилтнуудад ХАМО иргэдэд эрүүл мэндийн явуулын үйлчилгээ хүргэх сургалт явуулах “Бизнес ба хүний эрх” гарын авлага боловсруулж сурталчилах Үйл ажиллагаануудаа тодорхойлохдоо дараах асуултуудад мөн хариулна уу: Энэ үйл ажиллагаа хэнд хандсан байх вэ? Түүнийг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын хэнтэй, хэдийд нь хамтрах вэ? Иргэдийг ялангуяа ХАМО иргэдийг тэдний нөхөрлөл, ТББ-уудыг хэрхэн оролцуулах вэ? Ямар хөрөнгө, нөөц шаардагдах вэ? Хаанаас дайчлах вэ?



3.9.2 Боловсруулсан стратеги төлөвлөгөө түүний үйл ажиллагаа ХЭСХ болон Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн эсэхийг хянах матриц

ХЭСХ-ын үндсэн 5 зарчим	Тогтвортой хөгжлийн үндсэн бүрэлдэхүүн		
	Байгаль орчин	Нийгэм	Эдийн засаг
Олон улсын хүний эрхийн стандартыг мөрдөж хэрэгжүүлэх			
Эрх мэдэл олгох буюу эрхмэдэлжүүлэх			
Бодитой оролцоог хангах			
Үл ялгаварлах ба эмзэг бүлэгт илүү анхаарал хандуулах			
Хариуцлагын тогтолцоог бүрдүүлж хэрэгжүүлэх			

Боловсруулсан төлөвлөгөөгөө дээрх матрицаар үнэлнэ. Ингэхдээ харалдаа нүдэнд тийм, үгүй, хагас гэж үнэлээд түүнийг хэрхэн тэнцвэртэйгээр хэрэгжүүлэх талаар төлөвлөгөөгөө дахин сайжруулна.



3.10.1 Сургалтын үнэлгээний хуудасны загвар

20... оны сар.... өдөр Аймаг / Сум / Дүүрэг

1. Энэ аргачлалыг та цаашид үйл ажиллагаандаа ашиглах уу? Тийм бол яагаад? Үгүй бол яагаад?

.....
.....

2. Сургалтын хамгийн ойлгомжтой байсан хэсэг, сэдвээ тодорхойлно уу? Яагаад?

.....
.....

3. Сургалтын хамгийн ойлгомжгүй байсан хэсэг, сэдвээ тодорхойлно уу? Яагаад?

.....
.....

4. Сургалтын аргачлалын талаарх таны бодол? Цаашид хэрхэн сайжруулах талаар зөвлөнө үү?

.....
.....

Чиглүүлэгчдэд өгөх зөвлөгөө, санал

.....
.....

5. Та нэмж санал сэтгэгдэл бичихээр бол энд бичээрэй

.....
.....


Танд баярлалаа



БҮЛЭГ

IV

СУРГАЛТЫН ЧИГЛҮҮЛЭГЧИД ӨГӨХ
ЗӨВЛӨГӨӨ





4.1.1 Чиглүүлэгч сургалтад бэлтгэх талаар

- Насанд хүрсэн ямар ч хүн өөрийн гэсэн байр суурь, нийгмийг үзэх үзэл бодол, өөрийгөө хүндэтгэх чадвартай болсон байдаг. Иймд оролцогчдыг ямар ч оролцоотой байсан, ямар ч байр суурьтай байсан хувь хүнийх нь хувьд хүндэтгэлтэй хандаж, үл ялгаварлах, үл ойшоох, яриаг нь таслах, дараалан үзэл бодлыг нь үгүйсгэх нь тэдний оролцоог хязгаарлахад хүргэдгийг ямагт санаж байх хэрэгтэй.
- Сургалтад оролцогчид нь хүний эрхийн мэдлэг, туршлагын талаар харилцан адилгүй байдаг. Тэр ч бүү хэл хүний эрхийг үүрэг, хариуцлагаа ухамсарласан, түүнийгээ хэрэгжүүлдэг хүмүүс л эдлэх эрх гэж үздэг хүмүүс ч байдаг. Зарим оролцогчид өөрийнхөө маш сайн мэддэг зүйлийг тайлбарлаж байхад анх удаа сонсч байгаа мэт өөрийн мэдлэгтэй харьцуулж хүлээцтэй сонсдог бол зарим нэг оролцогч зориуд санаатай мушгих байдал үзүүлдэг. Гэвч тэр хүмүүс сургалтын дараа өөрчлөгдсөн байдаг.
- Иймд чиглүүлэгч нар сэтгэл зүйн хувьд бэлтгэлтэй, оролцогчдын олон янз байдалд мэдрэмжтэй, хүнд нөхцлийг эвтэйхэн залруулах, өөр асуудал руу чиглүүлэх чадварт суралцах хэрэгтэй байдаг. Мөн тэвчээртэй сайн сонсоход суралцах хэрэгтэй.



**4.2.1 Чиглүүлэгчийн чиг үүргийн онцлог, анхаарах асуудал**

Энэ сургалт онол практик хосолсон, оролцогч хүн бүрийн амьдралын туршлага, мэдлэгт үндэслэсэн, оролцогчдын идэвхтэй, тэгш оролцоог хангасан, харилцан суралцаж хамтдаа хөгжих, хийнгээ суралцаж бүтээгдэхүүн гаргах зарчимд суурилсан онцлогтой юм.

- Сургагч багш нь чиглүүлэгчийн үүрэгтэй байна. Чиглүүлэгч нь өөрийн үзэл бодлыг оролцогчдод тулгаж, мөн өгч буй мэдлэг, мэдээллээ туйлын үнэн зөв, хөдлөшгүй мэт ойлгогдохоор танилцуулахаас зайлсхийж, харин өөрийн буюу тухайн нутгийн хамт олны мэдлэг туршлага, үзэл бодол, байр суурийг хүндэтгэн оролцогчидтой мэдлэг хуваалцаж, асуудлын суурь шалтгааныг тодорхойлж улмаар эрхэд суурилсан хамтын шийдэл гаргахад нь туслах замаар сургалтыг чиглүүлнэ. Энэ зарчим сургалт эхлэхээс дуусах бүх үед мөрдөгдөнө.
- Сургалтын чиглүүлэгч нь өөрийгөө бусдын адил харилцан суралцах үйл явцад оролцогч гэж үзнэ. Ялангуяа хүний эрхийн сэдэвт сургалт, нөлөөллийн ажлын үед энэ байдал илүү гарч ирдэг. Өөрөөр хэлбэл, сургагч нь бүхнийг мэдэгч, асуудлыг шийдэгч, “хамгийн мундаг” нь биш, харин тухайн асуудлаар илүү мэдээлэлтэй, сайн сонсогч, олон янз байр суурь, үзэл бодлыг базаж дүгнэлт хийх, мэдрэмж сайтай чиглүүлэх л үүрэг хүлээнэ.
- Учир нь хүний эрхийн асуудлаар хичнээн олон жил ажиллаж, хичнээн их мэдлэг туршлага хуримтлуулсан сургагч байлаа ч энэ сэдэв, асуудлын хүрээнд үргэлж шинэ зүйл урган гарч, үргэлж суралцаж байдгийг олон жил хүний эрхийн талаар судалгаа, сургалт, нөлөөллийн ажил хийсэн хүмүүс нотолдог. Тухайлбал, улс төрийн болон иргэний эрхийн асуудлаар олон жил судалгаа, сургалт хийсэн хүн байж болно. Харин тэр хүнд эдийн засаг эсвэл соёлын эрхийн асуудал, эсвэл тодорхой бүлгийн эрхийн асуудлаар мэдлэг, туршлага дутмаг байдаг. Түүнчлэн даяарчлал тэлэх тусам хүний эрхүүд хувьсч өөрчлөгдөн, шинэ нэр тодорхойлолт урган гарч байна. Жишээлбэл, хөгжих эрх, оролцооны эрх гэх зэрэг эрх, нэршлийг нэлээд хожим ОУ-ын баримт бичгээр баталгаажуулсан зэргээс харж болно.
- Тиймээс чиглүүлэгч нь суралцагч юм. Харин чиглүүлэгчийн анхаарах нэг зүйл нь сургалтын агуулга, үнэт зүйл, зарчмыг тайлбарлахын зэрэгцээ оролцогчдын сурч мэдэж буй зүйлд нь анхаарал хандуулж, хүмүүс олон янз гэдгийг хүлээн зөвшөөрч, аливаа нас, хүйс болон бусад төрлийн ялгаварлал гаргалгүй хүн бүртэй тэгш харьцаж, энгийн, элгэмсэг, нээлттэй байж, оролцогчдын ялгаатай хэрэгцээ, шаардлагад мэдрэмжтэй хандах шаардлагатай.



Зөвлөмж 1

1. Сургалтын баг тухайн сургалт болох орон нутгийн талаар мэдээлэл цуглуулж судалсан байх нь ач холбогдолтой. Тухайн орон нутаг хэдэн хүн амтай, хөдөлмөрийн насны хүн амын тоо, үүнээс бичил уурхай эрхлэгч хэд, хэдийнээс энэ нутагт бичил уурхайн үйл ажиллагаа явагдсан, нөхөн сэргээгдээгүй талбайн мэдээллийг сайтар судалсан байх нь сургалтыг үр дүнтэй удирдахад ач холбогдол үзүүлнэ.
2. Мөн тухайн аймаг сумын ЗД-ын мөрийн хөтөлбөр, бусад бодлогын баримт бичигт хүний эрх, тогтвортой хөгжил, ажлын байр, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах, ХАМО иргэдийг өөр салбарт ажиллах боломжийг хэрхэн бий болгох талаар ямар зорилтууд төлөвлөгдсөн талаар мэдээлэл авсан байх хэрэгтэй. Энэ нь чиглүүлэгч нар сургалтын явцад кейс жишээ болгон ашиглах баялаг мэдээлэл, бүлгийн ажлыг чиглүүлэхэд мэдээлэлтэйгээр зөвлөн туслахад хэрэг болно.
3. Улс даяар 2010 онд засаг захиргааны нэгж бүр 2020 он хүртэлх 10 жилийн стратеги төлөвлөгөөг нэгдсэн журмаар боловсруулсан билээ. Энэ нь нэгдсэн удирдамжтай байсан бөгөөд түүн дотор Азийн сангийн зорилтот чиглэл болох байгаль орчныг хамгаалах, ажлын байр нэмэгдүүлэх замаар ядуурлыг бууруулах чиглэл багтсан тул аймаг, сум бүр энэ чиглэлээр урт хугацааны төлөвлөгөө хөтөлбөртэй байдаг.



Зөвлөмж 2

- “Эрх мэдлийн алхалт” дасгал тоглоом нь их зай шаарддаг тул дотор боломжгүй бол гадаа хийж болно.
- Дасгалыг гадаа хийх тохиолдолд “нийгмийн нөөц баялагийн ханыг” зураасаар орлуулж болно.
- Дүрүүд болон асуумжийг орон нутаг, тухайн бүлгийн онцлогт тохируулан өөрчилвөл илүү үр дүнтэй.
- Дүрүүдийн тоог оролцогчдын тоонд тохируулан нэмж эсвэл хасах хэрэгтэй болно. Тэгэхдээ урагшаа алхах буюу асуултуудад илүүтэй “тийм” гэж хариулах, хойшоо алхах буюу асуултуудад илүү “үгүй” гэж хариулах, эргэлзэж байгаа бол байрандаа зогсоно. Мөн дундаж давхаргын дүрүүдийн тоог тэнцвэртэй байлгахыг хичээгээрэй. Гэхдээ сүүлийн 2 хэсэгт багтах дүрүүд арай олон байхад гэмгүй.
- Цаг бага байгаа бол асуултуудаа цөөлөх хэрэгтэй. Асуулт хасахдаа дүрүүдийн онцлогийг бодолцоорой.



Зөвлөмж 3

Тулгамдсан асуудал уу? Бэрхшээл үү? Ялгаж харах зааварчилгаа

- Тухайн асуудлын агуулга, мөн чанар нь нийтийн эрх ашгийн төлөө, нийтийн сайн сайхны төлөө, аймаг, сумын нийт хүн амыг бүхэлд нь эсвэл томоохон төлөөллийн эрх ашгийг хөндсөн бол АСУУДАЛ байдаг. Түүнийг шийдэхийн тулд бодлого, хөтөлбөр, тогтолцооны түвшинд анхаарах хэрэгтэй болдог.
- Харин хувь нэг хүн, нэгэн гэр бүлд хамааралтай бол тэр нь БЭРХШЭЭЛ байдаг. Түүнийг шийдэхийн тулд тодорхой чиглэсэн, нэг удаагийн арга хэмжээ хэрэгжүүлэх хэрэгтэй болдог.
- Энэ ялгаатай байдлыг санаж оролцогчдын дэвшүүлсэн тулгамдсан асуудал нь хэний хэдий хэмжээний хүмүүсийн эрх ашиг хөндөгдөж байна вэ? гэдгийг ялгаж тайлбарлан чиглүүлэх хэрэгтэй.



Зөвлөмж 4

Тулгамдсан асуудлын суурь шалтгаанд дүн шинжилгээ хийх дасгал ажлыг хийхэд бас нэг анхаарах чухал зүйл нь сургалтад ямар бүлэг, хэн оролцож байгаагаас шалтгаалан аргачлал өөрчлөгдөнө. Тухайлбал, үүрэг хүлээгч буюу төрийн албан хаагчид, бизнесийн салбарынхан, том жижиг уул уурхайн эзэд оролцож байгаа тохиолдолд нэг өөр аргачлал, харин эрх агуулагч буюу иргэд олон нийт оролцож байгаа тохиолдолд өөр аргачлал, эсвэл холимог бүрэлдэхүүнтэй оролцогчдод сургалт зохион байгуулах бол бас өөр гэх мэт аргачлалууд уян хатан хөрвөх хэдий ч тодорхой чиглэсэн аргачлал хэрэглэгдэнэ. Тухайлбал,

1. Сургалтад оролцогчид бүгд үүрэг хүлээгчид байгаа бол эсвэл олонхи нь үүрэг хүлээгчид оролцож байгаа тохиолдолд:

“Оюуны дайралт хийх” аргаар орон нутгийн тулгамдсан асуудлыг гаргаж авна.

- Орон нутгийн түвшинд төрийн өмнөөс үүрэг хүлээгчид (засаг дарга, ЗДТГ-ын ажилтанууд, ИТХ түүний тэргүүлэгч, төлөөлөгчид, БИНХ-ын дарга, багийн засаг дарга нар) байх учраас тэдгээрт бүр тодорхой асуултаар чиглүүлж, сонгуульт хугацаандаа бид нутгийнхаа иргэд, ах дүү, танил хүмүүсийнхээ эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэх талаар юу хийж чадах вэ? ялангуяа байгаль орчныг хамгаалах замаар эрүүл аюулгүй орчинд амьдрах хүмүүсийн эрхийг хангах, ажлын байр нэмэгдүүлэх замаар иргэдийнхээ эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хэрхэн дэмжих вэ зэрэг асуултаар чиглүүлнэ.
- Ингэснээр нийтийн эрх ашгийг хамрах, нэн тулгамдсан асуудлыг сонгон авч түүнд дүн шинжилгээ хийх, улмаар сургалтын туршид олсон мэдлэгт үндэслэн эрхэд суурилсан хандлагаар үнэлж хандлага арга барилаа өөрчлөх сэдэл төрүүлэх, чадавх олгох юм.
- Өөрөөр хэлбэл, тэд тулгамдсан асуудлаа эрэмбэлэх, дүн шинжилгээ хийх, эрхэд суурилсан хандлага, тогтвортойгоор ахиц гарч байх хөгжилд чиглэсэн шийдлийг гаргах аргачлалд суралцангаа сургалтын дараа хийх ажлын төлөвлөгөөтэй болно гэсэн үг.

2. Сургалтад оролцогчид бүгд эрх агуулагчид байгаа бол эсвэл олонх нь байгаа тохиолдолд:
Оролцогчдыг 4 бүлэг болгон ажиллуулна.

1-2-р бүлэгт дараах асуултыг тавина.

- Таны, та бүхний ямар эрхүүд зөрчигдөж буюу хангагдахгүй байна, ямар эрхээ эдэлж чадахгүй байна. Өнөөдөр танай нутагт яг тан шиг энэ эрхээ эдэлж чадахгүй хэр олон хүн байна. Жагсаан бичнэ үү.
- Үүнтэй холбоотой шийдэх шаардлагатай, та бүхний санааг зовоож байгаа ямар ямар асуудлууд байна. Жагсааж бичнэ үү.

3-4-р бүлэгт дараах асуултыг тавина.

- Та болон таны гэр бүлийн амьдарлын чанар жилээс жилд ахиц өөрчлөлт гарч байх ёстой. Ингэж хөгжиж дэвжихэд саад болдог санаа зовоож буй асуудлуудыг жагсаан бичнэ үү.
- Танай орон нутаг илүү сайн хөгжихөд юу юу саад болж байна. Тэдгээр асуудлуудыг жагсаан бичнэ үү гэсэн аргачлалыг хэрэглэх нь зохистой. Учир нь тэд шийдвэр гаргадаг хүмүүс биш харин зөв шийдэл гаргахад нөлөөлөх, оролцож чадах субъект.

Дээрх дөрвөн бүлгүүдээс гарсан асуудлуудыг нэгтгэн жагсааж түүнээс 4 хүртэл асуудлыг оролцогчдоор эрэмбэлүүлэн сонгож асуудлын суурь шалтгааныг тодруулах “Асуудлын мод” аргачлалаар дасгал ажил хийнэ.

Гэхдээ эдгээр хувилбар бүхий аргачлал удирдамж нь гарын авлага зохиогчийн зүгээс санал болгож байгаа, сургалтын онцлог, агуулгад тулгуурлаж дэвшүүлсэн удирдамж.

Тиймээс чиглүүлэгчид өөр өөрийн туршлага, аргачлалаар илүү сайжруулах нь зүйтэй.

1-р бүлэгт тайлбарласнаар эрх агуулагчид буюу иргэд нь эрхээ эдлэх, эрх чөлөөгөө хангуулахаар төрд өөрийгөө төлөөлөх хүмүүсээ сонгож, түүнийг татвар төлөх замаар цалинжуулж байгаа субъект. Бид нэг ширхэг талх, шүдэнз, уутаар гурил авах бүрт нэмэгдсэн өртгийн албан татвар төлж авдаг. Тухайлбал, талхны өөрийн өртөө 1000 төгрөг, түүн дээр 10% нэмэгдээд бид 1100 төгрөгөөр авч байгаа нь бид бүгдээрээ татвар төлөгч болдог гэдгийг иргэдэд сайн ойлгуулах хэрэгтэй. Энэ нь хувцас хэрэглэл авах, цахилгааны үнэ төлөх, утсандаа нэгж авахад ч адилхан татвар төлж байдаг. Ингэснээр бид улсын төсвийг бүрдүүлэгч учраас улсын төсвөөс цалин авч байгаа бүх хүн, улсын төсвийн хөрөнгөөр хувийн хэвшил гэрээ хийх замаар зам барилга барьж байгаа болон нийтийн хоолны үйлчилгээ үзүүлэгч бүр бидний мөнгөөр бидэнд үйлчилгээ үзүүлдэг. Тиймээс бид төрөөс, төрийн албан хаагчдаар, цагдаагаар эрхээ хамгаалуулах, эрх чөлөөгөө бүрэн эдлэх нөхцөл шаардах, хангалттай чанартай үйлчилгээ авах эрхтэй юм.

Энэ утгаар эрх агуулагч болж байгааг сайтар ойлгуулж байж сургалтыг эхлүүлнэ. Сургалтын явцад ч энэ эрхийг сануулсаар байх шаардлага гардаг. Оролцогчдод эрх агуулагчийн ойлголтыг сайн тайлбарлаж, энэ байр суурьт өөрийг нь аваачиж өгөх нь иргэд өөрсдийн өмнө, орон нутгийн нийтийн эрх ашгийн өмнө тулгамдсан, санаа зовоосон асуудал, ирээдүй үеийнхэнд хохирол учруулах асуудлаа сайн томьёолж гаргаж чаддаг.



Эрх агуулагч гэдгийг сайтар ойлгуулаагүйгээр тулгамдсан асуудлыг гаргуулахад хэн нэгэн ирээд асуудлыг нь шийдэх юм шиг, хэн нэгнээр асуудлаа шийдүүлэх хүлээлттэй, өөрсдөө идэвхи санаачлагагүй байдаг. Тиймээс асуудлаа харахдаа ч ингэж хардаг. Хэн нэгнийг буруутгадаг, би идэвх санаачлагатай оролцох үүрэгтэй, мэдэх, хариуцлага нэхэх хянах, шаардах эрхтэй ингэснээр өөрчлөлтийг бий болгоход өөрийн биеэр оролцож, ардчиллыг бэхжүүлэхэд хариуцлага хүлээсэн иргэн гэдгээ ойлгож хүлээн зөвшөөрч чадахгүй байх явдал их байдаг. Тиймээс энэ сургалтаар энэ хандлагыг өөрсдийнх нь оролцоотойгоор өөрчлөхийг зорьж байгаа юм.



Зөвлөмж 5

Асуудлын дүн шинжилгээ хийх, асуудлын суурь шалтгааныг тодохойлох дасгал ажлыг “Асуудлын мод” загвар ашиглаж хийх аргыг нарийвчлан оруулсан билээ.

Цаашид өөр томоохон төсөл, томоохон бодлогын дүн шинжилгээ хийх бол дараахь аргачлалыг ашиглаж болно. Чиглүүлэгч нар нь сургалтыг хэрхэн чанартай болгох, шинэлэг аргачлалаар явуулах талаар үргэлжийн эрэл хайгуул хийж байх хэрэгтэй.

- Асуудалд дүн шинжилгээ хийхдээ оролцооны аргаар хийнэ. Ялангуяа тухайн асуудал шийдэгдэхгүй байхад ямар бүлгийн эрх ашиг ихээр хөндөгдөж байгаа тэдгээрийн оролцоотой хийвэл илүү бодитой, үр дүнтэй дүн шинжилгээ болно гэдгийг чиглүүлэгч нар ойлгуулахад чиглэсэн асуулт таьж ажиллана.
- Хэрвээ үүрэг хүлээгч төрийн байгууллагын баг, ИТХ-ын төлөөлөгчид дангаар асуудалд дүн шинжилгээ хийх гэж байгаа бол хүмүүсээс, эрх агуулагчдаас мэдээлэл сайн авах хэрэгтэй. Цуглуулсан мэдээллээ дүн шинжилгээ хийх таван бүтцэд хариулт болгохдоо ашиглана. Харин цуглуулсан мэдээлэл судалгаа тань бодит үнэн байх ёстой. Хэдий чинээ бодитой мэдээлэл байна төдий чинээ энэ арга хэрэглэсний ач холбогдол гарна.
- Хэлбэрийн хувьд нээлттэй ярилцлага эсвэл тодорхой асуудлаар, тодорхой зорилтот бүлгийн төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлэг хийх хэлбэрийн алинаар ч явуулж болно
- Мөн энэхүү чанарын аргачлалыг байгууллагын стратеги, дээвэр холбоо эвсэл, сүлжээний тулгамдсан асуудал, бодлого хөтөлбөрт, бүр тухайлсан нэг төсөл дээр ч дүн шинжилгээ хийхэд ашиглаж болно. Мөн бизнесийн байгууллага эсвэл ижил зорилготой нэг бүлэгт чиглэсэн асуудлаар ажилладаг төрийн бус байгууллагууд бусдаас өөр ялгарах стратеги гаргах, бусадтай хамтрах бодлого стратеги гаргахад ч энэхүү аргыг ашиглаж болно.
- Хөрөнгө санхүүгийн эх үүсвэр босгохдоо энэ аргыг ашиглаж болно. Харин үүний өмнө бодлого хөтөлбөртөө дүн шинжилгээ хийсэн байх хэрэгтэй.






Дүн шинжилгээ хийх аргачлалын хувилбар

Бодлогод дүн шинжилгээ хийх чанарын аргачлалын хувилбар: Үндсэн таван бүтцээр задлан шинжлэх

Энэхүү арга нь нийгэм, эдийн засгийн асуудлыг болоод бодлогын дүн шинжилгээ хийх чанарын аргачлал юм. НҮБ-ын Хөгжлийн сан, Байгаль орчин, цөлжилтийн бодлогын асуудлыг шинжлэхэд хэрэглэдэг өргөн хүрээтэй хүлээн зөвшөөрөгдсөн аргачлал юм. Байгаль орчин + эдийн засаг + нийгмийн тулгамдсан асуудал болон бодлогын харилцан хамаарал түүнд харьцуулсан цогц шинжилгээ хийх үндсэн аргачлал болдог.

Энэ нь орон нутгийн болон байгууллагын түвшнээс арай өргөн, улсын хэмжээний, аймгийн түвшний тулгамдсан асуудал, Засгийн газрын урт хугацааны бодлого, томоохон төсөл хөтөлбөрт дүн шинжилгээ хийхэд тохиромжтой.



Энэхүү аргачлалаар тулгамдсан, шийдвэрлэх шаардлагатай АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ хийх, энэ асуудлыг зохицуулж буй одоогийн БОДЛОГОД ДҮН ШИНЖИЛГЭЭ хийхэд дээрх үндсэн таван бүтцээр задлан шинжилнэ.



Энэхүү дүн шинжилгээний чанарын аргачлалаар хэрхэн дүн шинжилгээ хийх тухай Нийслэлийн агаар, хөрсний бохирдол, ундны усны аюулгүй байдал гэсэн тулгамдсан гурван асуудалд дүн шинжилгээ хийж үзье.

	Нийслэлийн агаарын бохирдол	Нийслэлийнхний ундны усны аюулгүй байдал
Асуудал	Агаарын бохирдол хэт аюултай хэмжээнд хүрсэн	Усны нөөц болон чанар муудаж байгаа
Шууд нөлөөлж буй хүчин зүйлс	- Түүхий нүүрс их шатаадаг - Хуучин машин ихтэй - Мэдлэг зан үйл хандлага - Ядуурал ихээс гэрийн галлагаа их	- Усны замбараагүй хэрэглээ - Усны өртөг бага, шударга бус - Төрийн бодлого дутагдалтай
Далд буюу дам нөлөөлж буй хүчин зүйлс	- Дэд бүтцийн шийдэл хот төлөвлөлтийн бодлого муу - Гэр хороололд чиглэсэн инженерийн шугам байхгүй - Хүн амын төвлөрөл өндөр - Машины зээлийн шаардлага сул, түүхий нүүрсийг халах технологийн шинэчлэл хийдэггүй - Мэдлэг зан үйл, хандлагад нөлөөлөх ажил хийдэггүй	- Хүн амын болон үйлдвэрлэлийн хэт төвлөрлөөс үүдэн усны хэрэгцээ өсч байгаа - Бүх хэрэгцээг гүний усны эх үүсвэрээр хангадаг - Зөвшөөрөлтэй зөвшөөрөлгүй гүний худаг ихээр ашигладаг
Үр дагавар:	Урт хугацаанд эерэг	- Дагуул хотууд байгуулагдана - Орон нутаг руу чиглэсэн суурьшил бий болно
	Урт хугацаанд сөрөг	2020 онд 1,5 сая хүн амын усны нөөц хүрэлцэхгүй - Туул голын усны түвшин багасна - Ундны усны аюулгүй, баталгаат байдал алдагдана
	Богино хугацаанд эерэг	ОУ-ын төсөл хөтөлбөрүүд хэрэгжиж, доноруудаас зээллэг тусламж авснаар зохих үр дүн гарна
	Богино хугацаанд сөрөг	- Усны үнэ нэмэгдэж ард иргэд ачаа үүрнэ - Усны хэрэглээгээ багасгах шаардлага гарна - Улс төрчид тоглолт хийнэ
Хариу арга хэмжээ, шийдэл	- Олон нийтийн оролцох, хяналт тогтоох мэдлэгийг дээшлүүлэх, хандлага зан үйлийг өөрчлөх - Төрийн бодлого оновчтой болоход иргэд нөлөөлөх - Сайн санаачлага, технологи импортлогч, туршлагыг дэлгэрүүлэх, урамшуулах - Ногоон хөгжил, ногоон эдийн засаг, ногоон бизнесийг дэмжих - Төрийн бодлого суурь шалтгааныг арилгахад чиглэгддэг	- Гүний усны хэрэглээг багасгах - Саарал усыг хэрэглэх - УБ-т гадаргын болон хурын усыг ашигладаг болох - Усны хэрэглээгээр нь төлбөр тооцох, бохирдуулсан усны төлбөр нэмэгдүүлэх - Хүн амын төвлөрлийг сааруулах - Иргэдийн ухамсар хандлагыг өөрчлөх



4.3.1 Сэргээх дасгал, тоглоом

Чиглүүлэгч нар нь

- Энэхүү сургалтын модуль нь СУРГАГЧ гэж байхгүй бөгөөд харин, зөвхөн ЧИГЛҮҮЛЭГЧ БАГ зохион байгуулахаар боловсруулагдсан байгааг анхаарах;
- Иймд ЧИГЛҮҮЛЭГЧДИЙН БАГ нь:
 - Бусдыг сонсох
 - Бусадтай ялгаварлалгүй харилцах
 - Өөрөө сургалтын оролцогч байх
 - Ярилцлагыг өдөөж чиглүүлэх
 - Хэлэлцүүлгийг өрнүүлэх
 - Зөвшилцөл бий болгох
 - Сургалтын төлөвлөгөө, агуулгыг баримтлах
 - Тэгш оролцуулах, хөгжүүлэх
- Харилцан суралцах түншлэлийг хөгжүүлэх үүрэгтэй;
- Сургалтын хөтөлбөрийн цагийг маш нарийн баримтлахад онцгой анхаарах бөгөөд цайны болон үдийн завсарлагыг төлөвлөсөн цагтаа хийж оролцогчдоо амрааж байх хэрэгтэй;
- Сургалтын хөтөлбөр хэнд, хаана заахаас хамаараад 12-16 цаг гэж төлөвлөсөн байгаа. Учир нь иргэд, нутгийн хамт олон, малчдад сэдвүүд дээр тогтож сайн ойлгуулах, ярилцах, оролцуулахад цаг шаардана. Харин байгууллагын удирдлага албан тушаалтануудад бол арай хурдан ажиллаж болно. Мөн малчдад бол өглөө 09.00 цагт сургалт эхлэх боломжгүй тул 11.00 цагаас эхлэнэ. Иймд цагийг хэнд, хаана зохион байгуулахаас хамаараад хөтөлбөрөө шинэчилж байх хэрэгтэй;
- Сургалтын явцад 2 цаг тутамд оролцогчдыг сэргээх дасгал, тоглоомын арга хэмжээ зохион байгуулж байх хэрэгтэй;
- Ингэхдээ насанд хүрэгчдийн түвшинд нийцсэн сургалт, дасгал ажил сонгож авахад анхаарах;
- Үүний тулд чиглүүлэгч өөрийн хэрэглэдэг баялаг аргуудтай хэдий ч заавал шинээр эрэл хийж, сургалт бүрийн өмнө хөтөлбөр болон аргачлалаа сайтар нягталж байхад анхаарах.

Ашигласан материал

1. <http://asiafoundation.org>
2. <http://www.undp.org>
3. <http://www.legalinfo.mn>
4. <http://www.parliament.mn>
5. <http://www.mfa.gov.mn>
6. <http://mn-nhrc.gov.mn>
7. <http://www.upr-mongolia.mn>
8. <http://www.chrd.mongolnet.mn>
9. <http://www.eitimongolia.mn>
10. <http://www.pwyp.mn>
11. <http://www.ikon.mn>
12. Төрийн мэдээлэл. Тусгай дугаар. 2004
13. MNS ISO 26000:2012 стандарт
14. ХЭҮК. Хүний эрхийн товч тайлбар толь. 2012
15. ХЭҮК. Хүний эрхийн олон улсын гэрээний хэрэгжилтийн талаар Монгол улсын ээлжит илтгэлүүд, НҮБ-ын холбогдох хороодоос МУ-ын Засгийн газар өгсөн зөвлөмжийн эмхтгэл. 2-р боть. 2012
16. МХЗ-уудын үндэсний 5-р илтгэл. 2013
17. Үндсэн хуулийн мэдлэг. Б.Чимид. 2008
18. Азийн сан. Тогтвортой хөгжлийн загвар. 2014
19. “Монголоо ямар улс болгох, хэрхэн түүнд хүрэх вэ” Сайнхүүгийн Ганбаатар. 2014
20. “Хил хязгааргүй алхам” ТББ. “Хөдөөгийн эзгүйрэл ба хүн амын бодлого” илтгэл. Эмэгтэйчүүдийн нүдээр VIII чуулган. 2014
21. Хөгжлийн ажиглагч форум. “Зээл тусламжийн үр нөлөөг нь” судалгааны тайлан. 2011
22. ШУТИС. “Байгаль орчныг хамгаалах Монголын өв уламжлал” нийтлэл А.Өэлүн.
23. Хүний эрхэд суурилсан хандлагыг хөтөлбөрийн удирдлагын үе шатанд ашиглах нь, IHRN
24. Хүний эрхэд суурилсан хандлагыг хөтөлбөрт ашиглах нь, UNFPA. 2010
25. Хүний эрхэд суурилсан хандлагыг хөгжлийн практикт ашиглах нь: хөтөлбөрийн гол асуултууд, Швейцарийн хөгжлийн агентлаг. 2007
26. Хүний эрхэд суурилсан хандлагыг хүрээлэн буй орчин ба уур амьсгалын өөрчлөлтийн асуудалд ашиглах нь. Гарын авлага, GI-ESCR. 2014
27. Хүний эрхийн тойм, IHRN. 2013
28. Африк дахь иргэдийн газрыг баталгаажуулах болон хүний эрхийн нөөцүүд: эрх зүйн шинэчлэл болон сайн туршлагууд гарын авлага. 2014
29. Хүний эрх эмхэтгэл, Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс, Швейцарийн хөгжлийн агентлаг. 2014
30. www.hrbportal.org
31. www.unep.org/environmentalgovernance/Events/ HumanRightsandEnvironment

